МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ






# Ерөнхий боловсролын салбарын чиглэлээр 2019 онд баталсан баримт бичгийн эмхэтгэл













МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

# ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР 2019 ОНД БАТАЛСАН БАРИМТ БИЧГИЙН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2020 он

| № | Баримт бичгийн нэр | Дугаар | Огноо | Хуудасны дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | Сурах бичгийн талаар авах арга зарим арга хэмжээний тухай | **98** | 2019.03.06 | 5 |
| 2 | Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд,олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах үлгэрчилсэн чиглэл | **А/119** | 2019.03.07 | 6 |
| 3 | Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам | **А/156** | 2019.03.19 | 11 |
| 4 | Сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах тухай | **А/192** | 2019.04.02 | 25 |
| 5 | Ерөнхий боловсролын сургуулийн элсэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай | **А/200** | 2019.04.05 | 27 |
| 6 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам, “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-д байвал зохих хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслийн жагсаалт | **А/292** | 2019.05.14 | 28 |
| 7 | Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам | **А/302** | 2019.05.14 | 35 |
| 8 | Суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж хувь бодох аргачлал | **А/46** | 2019.05.07 | 41 |
| 9 | Монгол улсын Засгийн газрын тогтоол “Үндэсний хөтөлбөр батлах тухай “ | **200** | 2019.05.22 | 13 |
| 10 | Нийслэлийн анги дүүргэлт хэт өндөртэй хүүхдийн цэцэрлэгийн ачааллыг бууруулах, 3 ээлжээр хичээллэж буй ерөнхий боловсролын сургуулийг 2 ээлжид шилжүүлэх аргачилсан заавар | **А/323** | 2019.05.23 | 45 |
| 11 | Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай “Иргэний ёс зүйн боловсрол сургалтын хөтөлбөр” | **А/390** | 2019.06.13 | 50 |
| 12 | 2019-2020 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангах ерөнхий төлөвлөгөө | | | 52 |
| 13 | Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах тухай | А/490 | 2019.08.01 | 57 |
| 14 | Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай | А/491 | 2019.08.01 | 60 |
| 15 | Хөтөлбөр батлах тухай | А/492 | 2019.08.02 | 64 |
| 16 | Ерөнхий боловсролын сургалтад цахим журнал хөтлөх талаар авах арга хэмжээний тухай | А/499 | 2019.08.12 | 69 |
| 17 | Тушаалд өөрчлөлт оруулах тухай | А/507 | 2019.08.14 | 71 |
| 18 | Гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай | А/508 | 2019.08.15 | 72 |
| 19 | Хуулийн хэрэгжилтийг хангах тухай | А/512 | 2019.08.15 | 79 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 20 | Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын салбарын 2019-2020 оны хичээлийн жилийн зорилго, зорилт | | | 80 |
| 21 | Чиглэл батлах тухай | А/528 | 2019.08.27 | 82 |
| 22 | Аргачлал батлах тухай “Ерөнхий боловсролын сургуульд секц, дугуйлан зохион байгуулах, санхүүжүүлэх аргачлал” | А/659 | 2019.10.18 | 88 |
| 23 | Хуулийн хэрэгжилтийг хангах тухай | А/689 | 2019.10.28 | 93 |
| 24 | Албан тушаалд тавих нийтлэг шаардлага, үндсэн чиг үүрэг батлах тухай | А/692 | 2019.10.29 | 94 |
| 25 | Насан туршийн боловсролын хөтөлбөр батлах тухай | А/756 | 2019.11.28 | 105 |
| 26 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам | А/803 | 2019.12.17 | 112 |
| 27 | Монгол улсын Засгийн газрын тогтоол “Хоолны зардлын норматив тогтоох тухай” | 450 | 2019.12.18 | 129 |
| 28 | Монгол улсын стандарт “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ Ерөнхий шаардлага” | MNS6781:2019 | 2019.10.16 | 130 |
| 29 | Монгол улсын стандарт “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал Ерөнхий шаардлага” | MNS6782:2019 | 2019.10.16 | 131 |
| 30 | Монгол улсын стандарт “Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага Ерөнхий шаардлага” | MNS6799:2019 | 2019.12.23 | 132 |
| 31 | Монгол улсын стандарт “Монгол брайль үсгийн тэмдэглэгээ | MNS6800:2019 | 2019.12.13 | 133 |
| **Засгийн газрын бусад гишүүдтэй хамтран баталсан тушаал** | | | | |
| 1 | Журам батлах тухай “Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх журам” | **ХНХС, БСШУСС А/506 А/266** | 2019.08.13 | 134 |
| 2 | Журам, загвар батлах тухай “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдөд мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээ олгох журам” | **ХНХС, БСШУСС А/505 А/267** | 2019.08.13 | 144 |
| 3 | Сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь хэсгийн агуулгыг шинэчлэн батлах тухай | **ХНХС, БСШУСС А/324 А/690** | 2019.10.29 | 157 |

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# ТОГТООЛ

2019 оны 3 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 98 | Улаанбаатар хот

Сурах бичгийн талаар авах зарим
арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Боловсролын тухай хуулийн 42.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдыг сурах бичгээр бүрэн хангах зорилгоор сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг ерөнхий боловсролын сургуулиудад нэвтрүүлэх, энэ үйл ажиллагаанаас хуримтлагдсан орлогын хүрээнд дунд, ахлах ангийн сурах бичгийн хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэн нийлүүлэх, төлбөртэй ашиглуулах үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх, холбогдох журам, аргачлалыг батлан мөрдүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай.

2. Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад төлбөртэй ашиглуулах сурах бичиг хэвлүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх боломжийг судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт даалгасугай.

3. 2019 онд хэвлэн нийлүүлэх шаардлагатай сурах бичгийн зардлыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн сурах бичгийн түрээсийн үйл ажиллагааны хүрээнд хуримтлагдсан орлогоос санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн түрээсийн тухай" Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 385 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд — У.ХҮРЭЛСҮХ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд — Ё.БААТАРБИЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 01 сарын 07 өдөр Дугаар А/119 Улаанбаатар хот

Үлгэрчилсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.9 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах үлгэрчилсэн чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үлгэрчилсэн чиглэлийг удирдлага болгон хэрэгжүүлэх ажлыг суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч, иргэдтэй хамтран ажиллах төлөвлөгөө батлан, үр дүнтэй зохион байгуулахыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг удирдлагаар ханган ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/-т даалгасугай.

САЙД Е.БААТАРБИЛЭГ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/112 тоот тушаалын хавсралт

# ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ, ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО, ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗӨВЛӨМЖ

## НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Дэлхий ертөнц тасралтгүй хувьсан өөрчлөгдөж, нийгэм, эдийн засгийн хувьд даваршин, өдөр бүр шинэ техник, технологи бүтээгдэж, ашиглагдаж байгаа нь бидний амьдралд байнга нөлөөлж байна. Үүнээс үлбэалан сургуульд олон төрлийн амьдрах хэв маяг, шашин, соёл, үнэт зүйлстэй хүүхдүүд хамтдаа суралцаж байна. Тиймээс энэ бүх өөрчлөлтийг дан ганц сургууль, багш шийдэж, өөрчлөгдөж буй дэлхий ертөнцтэй зохицон амьдрах иргэнийг төлөвшүүлэх боломжгүй юм. Нийгэм, эдийн засгийн эдгээр өөрчлөлтөөс шалтгаалан сургууль, анги, багшийн олж харж чадахгүй олон нууцлаг зүйл, хүндрэл бэрхшээл бий болж байна. Эдгээр асуудлыг даван туулахад арга зүйн дэмжлэг болох, боловсролыг эрэлхийлэхэд тухайн орон нутгийн иргэд, олон нийт, эцэг эх, асран хамгаалагчийн сургуулийн үйл ажиллагаан дахь оролцоо, дэмжлэг, хамтын ажиллагаа чухал байна.

**"Монгол Улсын Үндсэн хууль"**-ийн 2.17.2 дахь заалтад "Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн" хэмээн заасан.

Монгол улсын **"Бага, дунд боловсролын тухай"** хуулийн 20.2.2 дахь заалт "Сургууль хөгжүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад багш, сурагч, эцэг эх, олон нийтийн оролцоо, түншлэлийг хангаж ажиллах", 20.2.4 дэх заалт "Сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг сургуулийн зөвлөл, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотойгоор төлөвлөх, сургалтын орчныг бэхжүүлэх, төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, мэдээлэх, 20.2.11 дэх заалт "Шийдвэр гаргахад багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл, багш, суралцагч, эцэг эх, олон нийтийн оролцоог хангах, сургуулийн үйл ажиллагаа, сургалтын явц, үр дүнгийн талаар нээлттэй мэдээлэх"-ээр заасан. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан **"Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"**-ын баримт бичигт "Боловсролын үйл хэргийг удирдахад төрийн болон нутгийн захиргааны, иргэний нийгмийн байгууллага, гэр бүл, нийгмийн бүх салбарын оролцоонд суурилсан хамтын ажиллагааг бэхжүүлнэ" хэмээн тус тус тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт "Боловсролын түвшин, чиглэл тус бүрээр үнэлгээний систем, шалгуур, аргачлалыг хянан сайжруулж, үйлчилгээний чанар, үр дүнг, эцэг эх, сурагчдын оролцоотой үнэлэх боломжтой болно" гэсэн зорилт тусгагдан хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа билээ.

## ХОЁР. ЗОРИЛГО

Боловсролын үйлчилгээний чанар, суралцагчийн хөгжил төлөвшлийг дэмжихэд эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

## ГУРАВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Чиглэлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

1. Бүтээлчээр хамтран ажиллах
2. Харилцан бие биеэ хүндэтгэх
3. Шийдлийг хамтдаа эрэлхийлэх
4. Сайн дурын санаачилгыг дэмжих
5. Олон талт түншлэлийг хөгжүүлэх

## ДӨРӨВ. ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ

1. Ерөнхий боловсролын сургууль нь эцэг эх, асран хамгаалагч, олон нийттэй холбоо тогтоож, мэдээллээр хангах, тэдний сайн дураараа, бүтээлчээр хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
2. Хүүхэдтэй холбоотой аливаа шийдвэр гаргах үйл явцад эцэг эх, асран хамгаалагчийг оролцуулах, тэдний санал бодлыг сонсох, шийдвэрт тусгадаг байх;
3. Эцэг эх, асран хамгаалагчийн хүүхдээ хөгжүүлэх ур чадвар, насан туршдаа суралцахад дэмжлэг үзүүлэх;
4. Сургуулийн зүгээс суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийттэй хамтран үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээ хийж, үр дүнг хэлэлцэн, асуудлыг хамтран шийдвэрлэдэг байх

## ТАВ. ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

### Нэг. Эцэг эх, асран хамгаалагч, олон нийттэй холбоо тогтоож, мэдээллээр хангах, тэдний сайн дураараа, бүтээлчээр хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

1.1 Сургуулийн зүгээс эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдийн хөгжил, төлөвшил, суралцагчийн хүмүүжил, авьяасыг хөгжүүлэх, гэр бүлийн зүгээс хүүхдийг дэмжих арга зүйн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгч хамтран ажиллах,

1.2 Эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтээс сургуулийн үйл ажиллагаа, үйлчилгээ, хүүхдийн хөгжил төлөвшлийн талаарх сэтгэл ханамжийн судалгаа, санал бодлыг сонсох, тулгамдаж байгаа асуудал ба шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад сургуулийн зүгээс дэмжлэг үзүүлэх,

1.3 Эцэг, эх, асран хамгаалагчидтай хамтран зохион байгуулах ажлын талаар хичээлийн жилийн эхэнд хэлэлцэн, төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх,

1.4 Эцэг эх, иргэд, олон нийтэд түншлэл, хамтын ажиллагаа, харилцан бие биеэ дэмжин хөгжих, сайн дурын ажлын талаарх ойлголт хандлагыг төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах,

1.5 Сургуулийн үйл ажиллагаа, үйлчилгээ, төсөв санхүү зэрэг мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр боловсруулан эцэг эх, иргэд, олон нийтэд хүргэж, нээлттэй, ил тод мэдээлэл ашиглах боломжийг бүрдүүлэх,

1.6 Орон нутгийн иргэд, олон нийт, төр, төрийн бус болон бизнесийн байгууллагас сургуулийн хөгжилд оруулж болохуйц нөөцийг тодорхойлж, хамтран ажиллах чиглэл түншлэлийг өргөжүүлэх,

1.7 Эцэг эх, асран хамгаалагчийн эзэмшсэн мэргэжил, ур чадварын давуу талд тулгуурлан сургуультай хамтран ажиллах, суралцагчдын хөгжил төлөвшилд дэмжлэг үзүүлэх санаачилгыг өрнүүлэх,

1.8 Суралцагчийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх, тэдний амьдрах ухаан, мэргэжлийн чиг баримжаатай болгох, мэргэжлээ сонгоход иргэд, олон нийт, эцэг эх, асран хамгаалагчийн санаачилгыг өрнүүлэн, хамтран ажиллах.

1.9 Сургуулийн зүгээс эцэг эх, иргэд, олон нийтийн шийдвэр гаргах үйл явц дахь оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны эргэх холбоог сайжруулах үйл явцыг сургуулийн төлөвлөлтийн бүрэлдэхүүн болгох;

**Хоёр. Хүүхэдтэй холбоотой аливаа шийдвэр гаргах үйл явцад эцэг эх, асран хамгаалагчийг оролцуулан, тэдний санал бодлыг сонсон, шийдвэрт тусгадаг байх;**

2.1 Суралцагчийн талаар аливаа шийдвэр гаргахдаа тэдний санал бодлыг заавал сонсдог байх талаар холбогдох дүрэмд тусгах, хэрэгжүүлэх;
2.2 Сургууль дээрх аливаа шийдвэр гаргах үйл явцад суралцагч, эцэг эх, багш, ажилтны санал бодлоо хэлэх, оролцох нөхцөлийг бүрдүүлэх;
2.3 Суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, иргэд, багш, ажилтнууд санал бодлоо солилцож, бие биенээ хүндэтгэн хамтын шийдвэр гаргах соёлд суралцах, сургуулийн шийдвэрт тусгах зохицуулалт бий болгох;
2.4 Эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн зүгээс гаргасан аливаа санал санаачилга, хүсэлтийг сургуулийн зүгээс хэрхэн шийдвэрлэж, хамтран ажилласан тухай эргэн мэдээлдэг байх ажлыг сургууль зохион байгуулж хэвших;

**Гурав. Эцэг эх, асран хамгаалагчийн хүүхдээ хөгжүүлэх ур чадвар, насан туршдаа суралцахад дэмжлэг үзүүлэх;**

3.1 Эцэг эх, асран хамгаалагчийг хүүхдийнхээ давуу тал, авьяас, хөгжил төлөвшилд байнга дэмжлэг үзүүлэх чадвар, өөрсдийн үлгэр дуурайл, хувь хүний хөгжлийн талаарх сургалт бусад үйл ажиллагаанд хамруулах;
3.2 Хүүхдийнхээ сурч хөгжих, боловсрол эзэмших, хүмүүжил, төлөвшлийг дэмжихэд хүлээх үүрэг, хариуцлагын талаар эцэг эх, асран хамгаалагчдын туршлагыг бусдад нь түгээн дэлгэрүүлэх, бие биенээсээ суралцахад дэмжлэг үзүүлэх
3.3 Эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн насан туршдаа суралцах хэрэгцээ, тэдэнд шаардлагатай дэмжлэгийг тодорхойлон, арга замыг эрэлхийлэх, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;
3.4 Эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн насан туршийн хөгжлийг дэмжих чиглэлээр талуудтай шинэлэг арга зүй, хандлагаар хамтран ажиллах
3.5 Сургуулийн зүгээс эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа төрийн болон төрийн бус байгууллага, бусад сонирхлын бүлэгтэй хамтран зохион байгуулах;

**Дөрөв. Сургуулийн зүгээс суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийттэй хамтран сургуулийн үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ хийж, үр дүнг хэлэлцэж, асуудлыг хамтран шийдвэрлэдэг байх**

4.1 Эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн сургуулийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарт өөрийн үнэлгээг хийх чадавхийг нэмэгдүүлэх;
4.2 Үнэлгээгээр илэрсэн тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар эцэг эх, асран хамгаалагч, иргэдийн гаргасан санал санаачилгыг хэлэлцэх, шийдвэрт тусгах;
4.3 Өөрийн үнэлгээний үр дүн, түүнтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээг эцэг эх, асран х иргэд, олон нийт, холбогдох бусад талуудад танилцуулах, эргэн мэдээлэх ажлыг тогтмолжуулах;

## ЗУРГАА. ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах үзэл баримтлалын хэрэгжилтийн үр дүнг хичээлийн жилд нэг удаа дараах шалгуурын дагуу үнэлж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтөнд тусгаж ажиллана.

1. Эцэг эх, асран хамгаалагчийн сургуулийн үйл ажиллагаанд сайн дураар оролцож буй байдал
2. Сургуулийн зүгээс суралцагчийн хөгжлийг дэмжих чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчийн ур чадварыг хөгжүүлэхээр зохион байгуулсан арга хэмжээ, түүний үр дүн
3. Удирдлага, багш нарын сургуулийн эцэг эх, асран хамгаалагчийн үр дүнтэй оролцоог бий болгох арга зүй эзэмшсэн байдал
4. Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдах хүрээний өсөлт
5. Хүүхэдтэй холбоотой гаргасан шийдвэрийн тоо, түүнд суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийг оролцуулсан байдал

***

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2019 оны 04 сарын 11-ны
өдрийн [illegible] дугаараар бүртгэв.

# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 19 өдөр Дугаар А/156 Улаанбаатар хот

## Журам батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.5 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 155 дугаар зарлигийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалаар баталсан журмыг 2018-2019 оны хичээлийн жилийн ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөөс эхлэн мөрдсүгэй.

3. Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нам-Очир/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /З.Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Журам, загвар батлах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд боловсролын баримт бичиг олгох журам", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны "Тушаалд өөрчлөлт оруулах тухай" А/108 дугаар тушаалын 1, 2 дугаар заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Ё.БААТАРБИЛЭГ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн [illegible] дугаар тушаалын хавсралт

**СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШИГЧДЭД БОЛОВСРОЛЫН БАРИМТ БИЧИГ ОЛГОХ, ДҮЙЦҮҮЛЭХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг зүйл**

1.1. Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг /цаашид "гэрчилгээ, үнэмлэх" гэх/ олгохтой холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Гадаад улсад суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэний хэйл түвшний боловсролын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэхэд энэхүү журмыг баримтална.

1.3. Гэрчилгээ, үнэмлэх нь тухайн иргэний суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг гэрчилсэн төрөөс олгох бүй баримт бичиг мөн.

1.4. Суурь боловсрол эзэмшсэн иргэнд суурь боловсролын гэрчилгээ, бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэнд бүрэн дунд боловсролын үнэмлэх олгоно.

1.5. Гэрчилгээ, үнэмлэхийг суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага олгоно.

1.6. Гэрчилгээ, үнэмлэхийг үнэт цаасан дээр батлагдсан загвар 1, загвар 2-ын дагуу хэвлэнэ.

1.7. Иргэнд суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн эсэх талаар тодорхойлолтыг боловсролын салбарын мэдээллийн систем /цаашид "мэдээллийн систем"/ дэх төгсөгчийн мэдээлэл эсхүл архивын баримтад үндэслэн аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс олгоно.

**Хоёр. Боловсролын баримт бичиг олгох бэлтгэл хангах**

2.1. Мэдээллийн системд бүртгэгдсэн суурь, бүрэн дунд боловсролын төгсөх ангийн суралцагчийн эцэг/эх/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар төрсний гэрчилгээ/иргэний үнэмлэхийн холбогдох мэдээлэлтэй тохирч буй эсэхийг сургалтын байгууллага жил бүрийн 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор хянаж, мэдээлэл зөрүүтэй тохиолдолд төрсний гэрчилгээ/иргэний үнэмлэхийг үндэслэн өөрчлөлтийг мэдээллийн системд бүртгэж илгээнэ.

2.2. Мэдээллийн системд суурь, бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөх суралцагчийн мэдээлэл бүрэн орсон эсэхэд аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс хяналт тавина.

2.3. Суурь, бүрэн дунд боловсролын төгсөх ангийн суралцагчдын шилжилт, хөдөлгөөнийг жил бүрийн 5 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгоно.

2.4. Гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаас хэвлүүлэх зардлыг суурь, бүрэн дунд боловсрол эзэмшиж төгсөгч хариуцна.

**Гурав. Боловсролын баримт бичиг хэвлэх үнэт цаасыг бэлтгэх, түгээх, хадгалах**

3.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бага, дунд боловсролын асуудал хариуцсан нэгж үнэт цаасны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл бүхий эх акуйн нэгж, байгууллагатай холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаасыг батлагдсан загварын дагуу бэлтгүүлнэ.

3.2. Мэдээллийн системд бүртгэлтэй суурь, бүрэн дунд боловсролын төгсөх ангийн суралцагчийн тоонд үндэслэн гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаасыг хуваарилж битүүмжлэн орон нутагт хүргүүлэх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бага, дунд боловсролын асуудал хариуцсан нэгж зохион байгуулна.

3.3. Гэрчилгээ, үнэмлэх хэвлэх хүртэл хугацаанд үнэт цаасыг албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтсийн холбогдох албан тушаалтан хадгална.

3.4. Аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаасыг сургалтын байгууллагад хуваарилан хүргүүлнэ.

**Дөрөв. Боловсролын баримт бичгийн хэвлэлийн эх бэлтгэл, хянах, хэвлэх, баталгаажуулах, олгох**

4.1. Гэрчилгээ, үнэмлэхийг үнэт цаасан дээр хэвлэхийн өмнө мэдээллийн системд түүний хэвлэлийн эх бэлтгэгдэнэ.

4.1.1. Сургалтын байгууллага нь суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчийн гэрчилгээ, үнэмлэхэд бичигдэх хичээл, шалгалтын үнэлгээг улсын шалгалт дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор мэдээллийн системд үнэн зөв, бүрэн бүртгэж, аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэст илгээнэ.

4.1.2. Сургалтын байгууллагаас илгээсэн гэрчилгээ, үнэмлэхийн мэдээлэлд үндэслэн "Суурь боловсролын гэрчилгээ олгох бүртгэл", "Бүрэн дунд боловсролын үнэмлэх олгох бүртгэл" мэдээллийн системд анги, бүлэг бүрээр үүснэ.

4.1.3. Энэхүү журмын 4.1.2-т заасан бүртгэлд үндэслэн мэдээллийн системд QR кодоор баталгаажиж үүссэн гэрчилгээ, үнэмлэхийн хэвлэлийн эхийг төгсөгчдөд танилцуулна.

4.1.4. Гэрчилгээ, үнэмлэхийг үнэт цаасан дээр хэвлэхийн өмнө төгсөгчид танилцуулах ажлыг сургалтын менежерийн хяналт дор анги удирдсан багш зохион байгуулна.

4.1.5. Төгсөгч нь гэрчилгээ, үнэмлэхийн хэвлэлийн эцэг эх/асран хамгаалагч/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, суралцагчийн үнэлгээний мэдээлэл үнэн зөв эсэхийг хянах бөгөөд мэдээлэл зөрүүтэй бичигдсэн тохиолдолд сургалтын менежер тэмдэглэл хөтлөн холбогдох өөрчлөлтийг тухайн төгсөгчийг байлцуулан мэдээллийн системд хийнэ.

4.2. Гэрчилгээ, үнэмлэхийн хэвлэлийн эхийг төгсөгчдөд танилцуулсны дараа сургалтын байгууллагын захирал хянан цахим баталгаажуулалт хийж, аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэст 2 хоногийн дотор илгээнэ.

4.3. Энэхүү журмын 4.2-д заасан албан тушаалтны илгээсэн бүртгэлийг аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс, нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл бүхий 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хянах, аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтсийн удирдах албан тушаалтан/дарга/ цахим баталгаажуулалт хийнэ.

4.4. Аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтсийн удирдах албан тушаалтан цахим баталгаажуулалт хийснээр мэдээллийн системээс гэрчилгээ, үнэмлэх хэвлэх эрх нээгдэнэ.

4.5. Төгсөгчдөд олгох гэрчилгээ, үнэмлэх дэх мэдээллийн үнэн, зөв байдлыг энэхүү журмын 4.3-т заасан ажлын хэсэг, цахим баталгаажуулалт хийсэн этгээд тус тус хариуцна.

4.6. Мэдээллийн системээс гэрчилгээ, үнэмлэхийг үнэт цаасан дээр хэвлэх ажлыг сургалтын байгууллага хариуцна.

4.6.1. Гэрчилгээ, үнэмлэхийн бичвэрийг батлагдсан загварын дагуу "Arial" үсгийн фонтоор, хар өнгөөр бичнэ.

4.6.2. Гэрчилгээ, үнэмлэх нь дахин давтагдахгүй улсын дугаар, нууцлалтай байх бөгөөд суурь боловсролын гэрчилгээг БГ, бүрэн дунд боловсролын үнэмлэхийг БҮ гэсэн хоёр үсэг бүхий 11 оронтой тоогоор дугаарлана. Улсын дугаарын эхний 4 орон тухайн оныг, дараагийн 2 орон нь аймаг, нийслэлийн дүүргийг, сүүлийн 5 орон нь тухайн жилийн төгсөгчдийн дугаарыг тус тус илэрхийлнэ.

4.6.3. Гэрчилгээ, үнэмлэхэд тухайн баримт бичиг эзэмшигчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, төгссөн он, сургалтын байгууллагын нэр, суралцсан хичээл болон улсын шалгалтын үнэлгээ, дундаж үнэлгээ, баримт бичиг олгосон огноо зэрэг мэдээллийг кирил, монгол бичгээр зэрэгцүүлэн бичнэ.

4.6.4. Сургуулийн нэршлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан загварыг баримтлан бичнэ.

4.6.5. Боловсролын үнэлгээний байгууллагаас баталсан аргачлалын дагуу тухайн төгсөгчийн сурлагын үнэлгээний дундажийг тооцож гэрчилгээ, үнэмлэхэд бичнэ.

4.6.6. Гэрчилгээ, үнэмлэхийн мэдээллийн системд бэлтгэгдсэн хэвлэлийн эхийг үнэт цаасан дээр төгсөгч бүрээр хэвлэж, анги удирдсан багш, сургалтын менежер, сургалтын байгууллагын захирал гарын үсэг зурж, тамга дарна.

4.7. Гэрчилгээ, үнэмлэхэд гарын үсгийн дардас хэрэглэхгүй.

4.8. Мэдээллийн системд хянаж баталгаажуулсан "Суурь боловсролын гэрчилгээ олгох бүртгэл", "Бүрэн дунд боловсролын үнэмлэх олгох бүртгэл"-ийг 3 хувь үйлдэн гэрчилгээ, үнэмлэх эзэмшиж иргэнээр гарын үсэг зуруулж, баримт бичгийг хуулбарлан өгнө.

4.9. Гэрчилгээ, үнэмлэх олгосон тухай мэдээллийг сурагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, сургалтын байгууллагын захирал гарын үсэг зурж, тамга дарна.

4.10. Энэхүү журмын 4.8-д заасан бүртгэлд анги удирдсан багш, сургалтын менежер, сургалтын байгууллагын захирал гарын үсэг зурж, аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэст 3 хоногийн дотор хүргүүлнэ.

4.11. Энэхүү журмын 4.8-д заасан бүртгэлийг аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтсийн дарга хянаж баталгаажуулна.

4.12. Иргэнд гэрчилгээ, үнэмлэх олгосон бүртгэлийг сургалтын байгууллага, аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтсийн архивт тус тус хадгална.

4.13. Гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаасыг ашиглах боломжгүй болгосон тохиолдолд дахин хэвлэх зардлыг буруутай этгээд төлнө.

4.14. Мэдээллийн системд албан ёсны бүртгэлгүй иргэнд гэрчилгээ, үнэмлэх олгохгүй.

**Тав. Боловсролын баримт бичиг дахин олгох**

5.1. Гэрчилгээ, үнэмлэхийг иргэн үрэгдүүлсэн, гэмтээсэн, хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд дахин олгоно.

5.2. Гэрчилгээ, үнэмлэх дахин авах иргэн энэхүү журмын 2.4-т заасан зардлыг 3 дахин нэмэгдүүлж төлнө.

5.3. Иргэнд анх олгосон гэрчилгээ, үнэмлэхийн улсын дугаар дахин олгох гэрчилгээ, үнэмлэхэд хэвээр хадгалагдана.

5.4. Суурь, бүрэн дунд боловсролыг 2018 он болон түүнээс өмнө эзэмшсэн иргэнд дахин олгох гэрчилгээ, үнэмлэхийн эхийг мэдээллийн системд байршсан маягтад бэлтгэнэ.

5.5. Энэ журмын 5.1-д заасан шалтгааны улмаас гэрчилгээ, үнэмлэх дахин авах иргэн дараах материал бүрдүүлж, аймгийн боловсролын газар, нийслэлийн харьяалах дүүргийн боловсролын хэлтэст хандана:

5.5.1. Гэрчилгээ, үнэмлэх дахин авах болсон шалтгааныг бичсэн хүсэлт;

5.5.2. Энэ журмын 1.7-д заасан тодорхойлолт эсхүл гэрчилгээ, үнэмлэх анх олгосон архивын лавлагаа;

5.5.3. Гэрчилгээ, үнэмлэхийн хуулбар;

5.5.4. Иргэний хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд нотлох баримтын хуулбар;

5.5.5. Энэ журмын 5.5.3-т заасан хуулбар байхгүй тохиолдолд архивын баримт /дүнгийн жагсаалт, ангийн журнал болон бусад нотлох баримт/-ыг үндэслэн гаргасан сургалтын байгууллагын тодорхойлолт;

5.6. Аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь энэ журмын 5.4-д заасан нотлох материалд үндэслэн иргэнд гэрчилгээ, үнэмлэхийг дахин олгоно.

5.6.1. 2018 он болон түүнээс өмнө төгсөгчдөд дахин олгох гэрчилгээ, үнэмлэхийн хэвийг энэ журмын 5.3-т заасан маягтад бэлтгэж, үнэт цаасан дээр хэвлэн баруун дээд хэсэгт "Дахин олгов" гэсэн тэмдэглэгээ хийж, эрх бүхий этгээд баталгаажуулан иргэнд хүлээлгэн өгнө.

5.6.2. 2019 он болон түүнээс хойш төгсөгчдөд гэрчилгээ, үнэмлэх дахин олгоход мэдээллийн системд хадгалагдсан тухайн баримт бичгийн хэвийг үнэт цаасан дээр хэвлэн баруун дээд хэсэгт "Дахин олгов" гэсэн тэмдэглэгээ хийж, эрх бүхий этгээд баталгаажуулан иргэнд хүлээлгэн өгнө.

5.6.3. Гэрчилгээ, үнэмлэх дахин олгоход иргэний бүрдүүлсэн материалыг байгууллагын архивт хадгална.

5.7. Аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь гэрчилгээ, үнэмлэх дахин олгосон бүртгэлийг мэдээллийн систем дэх маягтын дагуу хөтөлнө.

**Зургаа. Гадаад улсын боловсролын**
**баримт бичгийг дүйцүүлэх**

6.1. Гадаад улсын ерөнхий боловсролын сургуульд суралцаж суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэнд тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлж болно.

6.2. Энэхүү журмын 6.1-д заасан баримт бичиг Монгол Улсын тухайн түвшний боловсролын баримт бичигтэй дүйцэх эсэх тодорхойлолтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.

6.3. Журмын 6.2-д заасан тодорхойлолт авах хүсэлт гаргагч иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

6.3.2. Гадаад улсад суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг гэрчлэх боловсролын баримт бичгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар, түүний албан ёсны орчуулга;

6.3.3. Гадаад паспортын хувийн мэдээлэл бүхий хуудас, суралцах хугацаанд Монгол Улсын хилээр гарсан, орсон тухай тэмдэглэлийн хуулбар.

6.4. Гадаад улсын ерөнхий боловсролын сургуулиас Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн бага ангид үргэлжлүүлэн суралцах иргэний хүсэлтийг шилжин суралцах сургалтын байгууллага шийдвэрлэнэ.

6.4.1. Сургалтын байгууллага нь иргэний хүсэлтийг бага ангийн ээлж ахлах ангийн нэгдлийн хурлаар хэлэлцэж, үргэлжлүүлэн суралцах ангийг тогтооно.

6.5. Гадаад улсын ерөнхий боловсролын сургуулиас Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангид үргэлжлүүлэн суралцах иргэний хүсэлтийг аймаг, нийслэлийн боловсролын газар шийдвэрлэнэ.

6.5.1. Ахлах ангид суралцах иргэн энэхүү журмын 6.1-д заасны дагуу суурь боловсролын гэрчилгээ дүйцүүлсэн байна.

6.5.2. Аймаг, нийслэлийн боловсролын газар нь дунд, ахлах ангид суралцах иргэний хүсэлтийг судлан, суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үнэлж, үргэлжлүүлэн суралцах ангийг тогтооно.

6.6. Журмын 6.4, 6.5-д заасан асуудлаар хүсэлт гаргагч иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

6.6.1. Суралцах хүсэлт;

6.6.2. Сурлагын дүнгийн жагсаалт, тодорхойлолт/анги бүрээр/, түүний албан ёсны орчуулга;

6.6.3. Гадаад паспортын хувийн мэдээлэл бүхий хуудас, суралцах хугацаанд Монгол Улсын хилээр гарсан, орсон тухай тэмдэглэлийн хуулбар.

6.7. Боловсролын баримт бичиг дүйцүүлэх, Монгол Улсын ерөнхий боловсролын сургуульд үргэлжлүүлэн суралцах иргэний бүрдүүлсэн материал, гаргасан шийдвэрийг байгууллагын архивт хадгална.

## Долоо. Тайлан, мэдээ гаргах

7.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жил олгогдоогүй болон хүчингүй болсон гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаасыг жил бүрийн 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтсээр дамжуулан татан авч, хүчингүй болсон үнэт цаасыг устгалд оруулж акт үйлдэнэ.

7.2. Тухайн жил олгогдоогүй үнэт цаасыг үнэт цаас үйлдвэрлэх аж ахуйн нэгж, байгууллагад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бага, дунд боловсролын асуудал хариуцсан нэгж тушаана.

7.2.1 Аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь энэ журмын 4.8-д заасан бүртгэлийн хувийг гэрчилгээ, үнэмлэх олгосон тайлангийн хамт боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор хүргүүлнэ.

7.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага "Суурь боловсролын гэрчилгээ олгох бүртгэл", "Бүрэн дунд боловсролын үнэмлэх олгох бүртгэл"-ийг Архивын тухай хуульд заасны дагуу архивт шилжүүлнэ.

7.4. Гэрчилгээ, үнэмлэх дахин олгосон тухай тайлang аймгийн боловсролын газар, нийслэлийн боловсролын хэлтэс нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 30, дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ.

**Найм. Бусад**

8.1. Гэрчилгээ, үнэмлэхэд бичигдэх мэдээлэл, сурлагын үнэлгээнд өөрчлөлт оруулах, хууль бусаар баримт бичиг олгохыг хүсэх, шаардах, дарамтлах зэрэг хууль бус аливаа үйлдлийг хориглоно.

8.2. Гэрчилгээ, үнэмлэхийг хууль бусаар олгосон, хуурамчаар үйлдсэн, ашигласан, боловсролын баримт бичгийн дахин олгоход энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээдийг хууль хяналтын байгууллагад иргэн, хуулийн этгээд мэдэгдэнэ.

8.3. Энэхүү журмын 4.5-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---000---

Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дуйцуулах журмын нэгдүгээр хавсралт

Загвар 1

А. Суурь боловсролын гэрчилгээний загвар

/Хавтасны загвар/

МОНГОЛ УЛС
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

СУУРЬ БОЛОВСРОЛЫН
ГЭРЧИЛГЭЭ

Тайлбар:

1. Гэрчилгээ нь A5 /A4 нугалбар/ хэмжээтэй, ногоон өнгийн хамгаалалтын хавтастай байна.
2. Хавтасны гадна талд хэвлэгдэх Монгол Улсын төрийн сүлд, бичээр алтан шармал өнгөтэй байна.
3. Засгийн газрын тухай хуулийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийг тухайн үеийн нэршлээр бичнэ.


МОНГОЛ УЛС
СУУРЬ БОЛОВСРОЛЫН ГЭРЧИЛГЭЭ
БГ
овогтой
20__ онд
“СУУРЬ БОЛОВСРОЛЫН ГЭРЧИЛГЭЭ” олгов.
Сургуулийн захирал

Хөвсгөл: БГ ____________

СУРЛАГЫН ҮНЭЛГЭЭ /Хувь/

1. Монгол хэл 97
2.
3.
4.
5.
6.
7.
8.
9.
10.
11.
12.
13.
14.
15.
16.

СОНГОН СУДАЛСАН ХИЧЭЭЛ

1. Монгол хэл 97
2.
3.

УЛСЫН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭ /Хувь/

1. Монгол хэл 97
2.
3.
4.

ТӨРӨЛЖСӨН ГҮНЗГИЙРҮҮЛЭН СУРАЛЦСАН ХИЧЭЭЛ

1. Монгол хэл 97
2.

Үнэлгээний дундаж хувь:
Тайлбар: Үнэлсэн ахуйтэй эзэмшилтийн хувь

Сургалтын менежер ____________ /____________/

Анги удирдсан багш ____________ /____________/

Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журмын хоёрдугаар хавсралт

Загвар 2

Б. Бүрэн дунд боловсролын үнэмлэхийн загвар

/Хавтасны загвар/

МОНГОЛ УЛС
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

БҮРЭН
ДУНД БОЛОВСРОЛЫН
**ҮНЭМЛЭХ**

Тайлбар:

1. Үнэмлэх нь А5 /А4 нугалбар/ хэмжээтэй, үзмэн ягаан өнгийн хамгаалалтын хавтастай байна.
2. Хавтасны гадна талд хэвлэгдэх Монгол Улсын төрийн сүлд, бичээс алтан шармал өнгөтэй байна.
3. Засгийн газрын тухай хуулийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийг тухайн үеийн нэршлээр бичнэ.

**МОНГОЛ УЛС**

**БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ҮНЭМЛЭХ**

**БҮ ____________**

________________ овогтой ________________ /РД** ********/ нь

20__ онд

________________________________ сургуулийг төгсөж,

бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг гэрчлэн

**"БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ҮНЭМЛЭХ"** олгов.

Сургуулийн захирал ________________ / ________________ /

гарын үсэг

20. . . оны . . . сарын . . . -ны өдөр

Хавсралт: БҮ ___________

**СУРЛАГЫН ҮНЭЛГЭЭ /Хувь/**

1. Монгол хэл 97
2.
3.
4.
5.
6.
7.
8.
9.
10.
11.
12.
13.
14.
15.
16.

**СОНГОН СУДАЛСАН ХИЧЭЭЛ**

1. Монгол хэл 97
2.
3.

**УЛСЫН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭ /Хувь/**

1. Монгол хэл 97
2.
3.
4.

**ТӨРӨЛЖСӨН/ГҮНЗГИЙРҮҮЛЭН СУРАЛЦСАН ХИЧЭЭЛ**

1. Монгол хэл 97
2.

Үнэлгээний дундаж хувь:
Тайлбар: Үнэлгээ-[illegible] хувь

Сургалтын менежер ______________ /______________/
тамга

Анги удирдсан багш ______________ /______________/

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 04 өдөр Дугаар А/192 Улаанбаатар хот

Сургалтын үйл ажиллагааны зохион
байгуулалтыг сайжруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.8, 28.1.15, 44 дүгээр зүйлийн 44.1.1, 45 дугаар зүйлийн 45.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" улсын 2 дугаар зөвлөгөөний зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Сургалтын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, багшийн ажлыг хүүхэд бүрийг хөгжүүлэх, сургалтын чанарт ахиц гаргахад чиглүүлэх, суралцагчдын суралцах нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн эрхлэгч, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

1.1. Бага ангид хүүхдийг эрэмбэлэх ялгаа үүсгэсэн, суралцах хүсэл эрмэлзлэлийг бууруулсан, сургалтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан олимпиад, уралдаан, тэмцээн зохион байгуулахгүй байх;

1.2. Тухайн хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх, ахмад үе, уламжлалаа хүндэтгэх, байгаль орчноо хайрлан хамгаалах, хүнлэг тусч зан чанар, харилцааны соёлтой болох, бие бялдрын хөгжлийг хангахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа, багийн уралдаан,тэмцээн зохион байгуулахыг дэмжих;

1.3. Улсын шалгалтад чанартай бэлтгэх нөхцөлийг хангах зорилгоор 2018-2019 оны хичээлийн жилд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн 9, 12 дугаар ангийн суралцагч, холбогдох багш нарыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас баталсан олон улсын болон дотоодын төрөлжсөн олимпиад, Монголын хүүхдийн спортын YI наадмын зуны төрлийн анхан шатны тэмцээнээс бусад уралдаан, тэмцээнд тус тус зохион байгуулалттай оролцуулахгүй байх;

1.4. Цаашид аливаа олимпиад, уралдаан тэмцээнийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас батлах журамд нийцүүлэн зохион байгуулах;

1.5. Хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулах, сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй аливаа үйл ажиллагаанд багш нарыг оролцуулахыг хязгаарлах, үүнээс шалтгаалсан нэмэлт ачаалал үүсгэхгүй байх;

100584

1.6. Энэ тушаалын 1.2-т заасан уралдаан, тэмцээн зохион байгуулахад суралцагчаас хураамж авахыг хориглох;

2. Аймаг, нийслэлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг дэмжих, багш, суралцагчийг хуульд заасан сургах, суралцах нөхцөл боломжоор хангах, сургалтын бус үйл ажиллагаанд зохион байгуулалттайгаар оролцуулахгүй байх талаар холбогдох шийдвэрүүдийг гаргах, энэхүү тушаалын хэрэгжилтийг удирдлагаар хангаж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт зөвлөсүгэй.

3. Тушаалыг хэрэгжүүлэх, бодит үр дүн, чанарын өөрчлөлт гаргахад хяналт тавьж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Г.Дуламжав/, Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/-т тус тус даалгасугай.

САЙД Е.БААТАРБИЛЭГ

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 05 өдөр | Дугаар A/200 | Улаанбаатар хот

Ерөнхий боловсролын сургуулийн
элсэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.1, Бага, дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулиас бусад ерөнхий боловсролын сургуульд нэгдүгээр ангид элсэгчийг аливаа хэлбэрийн шалгалтгүйгээр элсүүлэн суралцуулахыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

2. Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид тухайн онд 6 нас хүрээгүй хүүхдийг элсүүлэхийг хориглосугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн байршил, хэв шинж, сургалтын орчноос хамаарсан чанарын ялгаатай байдлыг арилгах, сургууль бүр сургалтыг чанартай зохион байгуулахад чиглэсэн бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт чиглэл болгосугай.

4. Ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийг бүтээн байгуулалт, аймаг, нийслэлийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан, судалгаанд үндэслэн шинэчлэн тогтоох арга хэмжээ авахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, Нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд Г.Ганбаярт даалгасугай.

САЙД Е.БААТАРБИЛЭГ

# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 14 өдөр | Дугаар А/292 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.2, 15.1.1 дэх заалтыг үндэслэн, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 3.2.13, 3.2.14 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам"-ыг нэгдүгээр, "Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим"-д байвал зохих хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмыг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн мөрдсүгэй.

3. Журмыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч нэгдсэн удирдлагаар хангах ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нам-Очир/, журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах сургуулийн дад бүтцэд орох өөрчлөлтийн судалгаа хийж, санал боловсруулж 2019 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Нансалмаа/-т тус тус үүрэг болгосугай.

4. Журмыг хэрэгжүүлэх бэлтгэл хангах, сургуулийн орчин нөхцөлийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах боломжоор тохижуулах, харьяа нутаг дэвсгэрийн сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа гаргах ажлыг энэ оны 8 дугаар сард багтаан хэрэгжүүлэхийг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД Е.БААТАРБИЛЭГ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 05 дугаар сарын 14 -ний өдрийн A/291 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ТЭГШ ХАМРАН СУРГАХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд /цаашид "хүүхэд" гэх/-ийг ерөнхий боловсролын тусгай сургуулиас бусад хэв шинж бүхий сургууль /цаашид "сургууль" гэх/-д сургахтай холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Нэгдсэн Үндэстний байгууллагаас баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Хүүхдийн эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах талаар тусгасан зэм хэмжээг удирдлага болгоно.

## Хоёр. Баримтлах зарчим

2.1. Хүүхдийг сургуульд тэгш хамран сургах үйл ажиллагаанд дараах зарчим баримтална:

2.1.1. Хүүхдийн сурч боловсрох, хөгжих эрхийг хүндэтгэх;

2.1.2. Хүүхдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн чанартай боловсрол эзэмшүүлэх;

2.1.3. Хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэх, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлэх бусадтай харилцах, хамтран ажиллах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох оролцоог дэмжих;

2.1.4. Аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх.

## Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1. Сургууль нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.3.1 дэх заалтад заасны дагуу хамран сургах тойрогт хамаарах хүүхдийг сургуульд бүрэн хамруулах ажлыг хариуцна.

3.2. Сургууль нь нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран баталсан зааврын[1] дагуу сум, хорооны "Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-тэй хамтран ажиллана.

[1] Хөдөлмөр нийгмийн хамгаалал, Боловсрол,соёл,шинжлэх ухаан, спорт, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Заавар, маягт батлах тухай" 2018 оны A/304, A/599, A/460 тоот тушаал

3.3. Сургууль нь хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.4. Сургууль нь хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг эцэг эх, холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

3.4.1. хүүхдийг сургууль, анги танхим, хонгил, ариун цэврийн өрөөнд саадгүй нэвтрэх, аюулгүй зорчих боломжийг бүрдүүлэх

3.4.2. хүүхдийн онцлог хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэгцээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах;

3.4.3.багш, ажилтанд хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн заах арга зүй, арга барил эзэмшүүлэх;

3.5 Хүүхдийг сургуульд тэгш хамран сургах, сургуулийн орчинд дасан зохицох, бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшихэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэг бүхий "Дэмжлэгийн баг"-ийг сургуулийн захирлын тушаалаар байгуулж ажиллуулна.

3.5.1. Дэмжлэгийн баг нь хүүхдийг сургуулийн орчинд дасан зохицоход туслах, тэдний хөгжлийн онцлог, давуу тал, суралцах боловсрох, хөгжих хэрэгцээний судалгаа хийх, багш, эцэг, эх, асран хамгаалагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн дэмжлэг үзүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах чиг үүрэгтэй.

3.6. Сургууль нь хүүхдийг сургахад Бага, дунд боловсролын тухай хуулийн 13.4-т заасны дагуу ерөнхий боловсролын тусгай сургуулиас мэргэжил, арга зүйн туслалцаа авч хамтран ажиллана.

## Дөрөв. Сургуульд тэгш хамран сургах үйл ажиллагааг зохион байгуулах

4.1. Сургууль нь хүүхдийн боловсролын ялгаатай хэрэгцээг тодорхойлох, дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, засан сайжруулах, зөвлөгөө өгөх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.2. Энэхүү журмын 4.1-д заасан үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.2.1. Хүүхдийн хувийн хэрэгтэй танилцах, эцэг эх, асран хамгаалагчтай ганцаарчлан уулзах, хичээлийн болон хичээлийн бус цагаар ажиглалт хийх замаар тухайн хүүхдийн ерөнхий хөгжил, тусгай хэрэгцээг тодорхойлох

4.2.2. Хүүхдийг сургуульд элсэхээс өмнө сургуулийн орчинтой танилцуулах, анги даах багштай уулзалт хийх, сургуульд сурах хүсэл сонирхол бий болгох, хүүхдэд тохиолдож буй бэрхшээлийг хамтдаа шийдэж урамшуулах, идэвхжүүлэх, хүүхдээс

хүүхдэд, үе тэнгийн туслагч хөдөлгөөн өрнүүлэх зэргээр шинэ орчин нөхцөлд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх

4.2.3. Хэл засал, хөдөлгөөн засал, өөртөө үйлчлэх, брайль үсэг, дохионы хэл болон харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх, орон зай, чиг баримжааны чадвар олгох нэмэлт сургалт зохион байгуулах

4.2.4. Хүүхэд, түүний гэр бүлд эрүүл, мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд хэрхэн хамрагдах, хүүхдийн хэл яриа, хөдөлгөөнийг засан сайжруулах, өөртөө үйлчлэх дадалд сургах, хүүхдийн харилцах чадварыг хөгжүүлэх, сэтгэл хөдлөлөө хянах, зөрөг зан үйл, хандлагыг төлөвшүүлэх, мэргэжлээ сонгоход нь туслалцаа үзүүлэх арга зүйн зөвлөгөө өгөх

4.2.5. Сургуулийн хамт олон, эцэг эх, асран хамгаалагч, орон нутгийн иргэдэд хүүхдийн хөгжлийн болон сурах онцлогийн талаар мэдээлэл түгээх, нийгмийн зөрөг хандлагыг бий болгох нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.3. Энэхүү журмын 4.2.4-д заасан нэмэлт сургалтын үйл ажиллагааг сургалтын тохирох хэрэглэгдэхүүн, туслах хэрэгсэлтэй танхимд хичээлийн бус цагаар зохион байгуулна.

4.4. Хүүхдийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан суралцагчийн үнэлгээний журмын[2] дагуу үнэлж дүгнэнэ.

4.5. Анги дэвших болон сургууль төгсөх шалгалтыг тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан орчин, нөхцөлд авна.

## Тав. Санхүүжилт

5.1. Сургууль нь төсвийн төлөвлөлт хийхдээ суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсах зардлыг Засгийн газраас баталсан журмын[3] дагуу нэг суралцагчийн хувьсах зардлын нормативыг 3 дахин нэмэгдүүлж тооцно.

5.2. Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид хүүхдийн ахиц, үр дүнг тооцон урамшуулал олгох асуудлыг сургуулийн дотоод дүрэм, хөдөлмөрийн гэрээнд тусган шийдвэрлэнэ.

[1] Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 6 дугаар сарын 29-ны А/425-р тушаалаар баталсан " Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"
[2]

[3] Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолоор баталсан "Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4 дүгээр хавсралт 3.3 дахь хэсэг

5.3. Монгол Улсын Засгийн газрын баталсан журам[4]-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш, нарийн мэргэжлийн ажилтнуудыг бэлтгэхтэй холбоотой зардлыг тухайн сургалтын байгууллагын жил бүрийн төсөвт тусгана.

5.4.Хүүхдийн сургалтын үйл ажиллагаанд зориулан сурах бичиг гарын авлага, сургалтын тоног төхөөрөмж, тохирох хэрэглэгдэхүүн худалдан авах, сургууль, анги, танхим тохижуулахад шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаад дотоодын төсөл хөтөлбөрөөр шийдвэрлэнэ.

.......... o O o ..........

[4] Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт "Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам"

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2019 оны 05 дугаар сарын 17-
ны өдрийн А/228 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

"Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим"-д байвал зохих хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслийн жагсаалт

1. Ширээ, сандал /шаардагдах тоогоор/
2. Цагаан самбар 1ш
3. Компьютер 1ш
4. Принтер 1ш
5. Хувилагч 1ш
6. Телевиз
7. Номын тавиур, шүүгээ
8. Харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад байвал зохих хэрэгсэл
- хараа шалгах энгийн хэрэгсэл буюу самбар
- цагаан таяг
- таягны гэрэлтүүлэгч цаас
- ярьдаг ном
- самбар
- шавуур
- брайль хэлний цагаан толгой
- брайлийн цаас
- брайль бичгийн хэрэгсэл
- брайль шатар
- брайль даам
- сул хараатай хүний дэвтэр
- брайль самлин
- томруулагч шил
- Товгор дэлхийн бөмбөрцөг
- Дейзи ном уншигч
- модон баллуур
- зурган карт
- хуруун мэдрэмж сайжруулах тоглоом /хатуу, зөөлөн, арзгар, хавсгар/ гэх мэт
9. Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад байвал зохих хэрэгсэл
- сонсголын аппарат
- сонсгол шалгах хэрэгсэл
- сонсгол хөгжүүлэх дасгалын ном
- сонсгол хөгжүүлэх дуут тоглоом
- төрөл бүрийн дуу авиа бичдэг CD-нүүд
- авиа тавих ном
- Магнитофон
- Дохионы хэлний толь бичиг
- Дохионы хэлний зурагт үзүүлэн
- Үлгэрийн ном,
- Зурган карт гэх мэт
10. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад байвал зохих хэрэгсэл

- гарын жижиг булчин хөгжүүлэх хэрэгсэл
- хөдөлгөөний чиг баримжаа олгох дасгалын ном
- алхуулагч
- Саажилттай болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийн ширээ сандал гэх мэт

11. Хэл ярианы бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад байвал зохих хэрэгсэл
- хэл заслын тольтой ширээ
- хэл заслын карт
- хэл заслын дасгалын зураг
- хэл яриа хөгжүүлэх зурган картууд
- үлгэрийн ном
- оньсого, зүйр цэцэн үгсийн эмхэтгэл
- хэл заслын багшийн ном гэх мэт

12. Оюун ухааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад зохих хэрэгсэл
- оюуны ухааны тест
- оюун ухаан хөгжүүлэх өрөх байгуулах өнгөт тоглоомууд
- хэл яриа хөгжүүлэх дасгалын өгүүлэл, хураамж өрдийн шатар /хөлөгт нь тэмтрүүл хийдэг/
- хулдаасан хөзөр /тэмтрүүл хийнэ/
- хөлөгт тоглоом
- эвлүүлдэг тоглоом
- оригамийн материалууд
- шүрэн үрлэл /төрөл бүрийн шүрнүүдё заавартай нь их захаас/
- нэхмэлийн хэрэгсэл /утас, нэхмэлийн зүүнүүд/
- буддаг ном гэх мэт

--ооо-

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 14 өдөр Дугаар А/302 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн "Сурах бичгийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 98 дугаар тогтоолын 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нямь-Очир/, Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Нансалмаа/-т тус тус даалгасугай.

4. Боловсролын салбарын мэдээллийн систем, Анги удирдсан багшийн дэвтрийн холбогдох мэдээллүүдэд төлбөртэй ашиглуулах сурах бичгийн талаар тусгах, мэдээллийн нэгдмэл байдлыг хангахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Ю.Хүрэлцоот/, Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нямь-Очир/-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 47 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын суралцагчдад сурах бичгийг түрээсээр ашиглуулах түр журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Е.БААТАРБИЛЭГ

000907

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 20[illegible] оны [illegible] дугаар
сарын [illegible]-ний өдрийн [illegible] дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад
сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ерөнхий боловсролын сургууль /цаашид "сургууль" гэх/-ийн дунд, ахлах ангийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээтэй холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Төрөөс сурах бичгээр үнэ төлбөргүй хангах зорилтот бүлгийн суралцагчдад энэ журмын зохицуулалт хамааралгүй.

1.3. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.3.1. "Сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээ" гэж дунд, ахлах ангийн суралцагчдад сургуулийн номын сангаар дамжуулан тухайн хичээлийн жилд сурах бичгийг тодорхой хэмжээний төлбөртэй, буцаан авах нөхцөлтэй хэрэглүүлэх үйл явц;

1.3.2. "Төлбөртэй ашиглуулах сурах бичиг" гэж дунд, ахлах ангийн сургалтад ашиглагдаж байгаа үндсэн сурах бичиг;

1.3.3. "Сурах бичиг ашиглах төлбөр" гэж суралцагч суралцах ангийнхаа бүх /багц/ сурах бичгийг хичээлийн жилийн турш ашиглахтай холбогдох төлбөр;

1.3.4. "Төлбөртэй ашиглуулах сурах бичгийн ашиглалтын хугацаа" гэж сурах бичиг хэрэглээнд орсноос хойш элэгдэж, шинээр солих шаардлагатай болох хүртэлх хугацааг.

### Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хэмжээнд нэвтрүүлж, дараах үйл ажиллагаа хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1 Төлбөртэй ашиглуулах сурах бичиг /цаашид "сурах бичиг" гэх/-ийг хэвлэн нийлүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, аймгийн боловсролын газар, нийслэлийн сургууль бүрт хүргүүлнэ.

2.1.2 Холбогдох заавар, зөвлөмж боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хүргүүлнэ.

2.1.3 Сурах бичгийн захиалгад үндэслэн нөөцөн хангалт хийх ажлыг жил бүр зохион байгуулна.

2.1.4 Сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

2.2. Аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг орон нутгийн хэмжээнд нэвтрүүлэх, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1 Энэхүү журмын 2.1.1-д заасны дагуу хэвлэн хүргэгдэж ирсэн сурах бичгийг аймгийн боловсролын газар хүлээн авч, сум, тосгоны сургуульд хүргэх ажлыг сургуулийн захиргаатай хамтран зохион байгуулна.

2.2.2 Энэхүү журмын 2.1.1-д заасан дагуу нийслэлийн сургууль тус бүрт сурах бичиг хүргэх ажилд дүүргийн боловсролын хэлтэс дэмжлэг үзүүлэх, хяналт тавьж ажиллана.

2.2.3 Шаардлагатай тохиолдолд сургууль хооронд сурах бичиг шилжүүлэх зохицуулалт хийнэ.

2.3. Ерөнхий боловсролын сургууль нь сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг сургуулийн хэмжээнд нэвтрүүлэх, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.3.1 Сурах бичгийг сургуулийн захирлын тушаалаар  томилогдсон ажлын хэсэг хүлээн авч, акт үйлдэн эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэнэ.

2.3.2 Сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журмыг багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулах, төлбөр төлөх заавар өгөх ажлыг сургуулийн захирал хариуцан зохион байгуулна.

2.3.3 Сурах бичгийг ангилж, төлбөрийн баримтыг үндэслэн анги удирдсан багш нарт хүлээлгэн өгч бүртгэл тооцоо хөтлөх ажлыг сургуулийн номын сан хариуцан зохион байгуулна.

2.3.4 Суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай гэрээ байгуулж, сурах бичгийг суралцагчдад олгох, буцаан авах үйл ажиллагааг анги удирдсан багш нь ангийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран зохион байгуулна.

2.3.5. Багш нар нь сурах бичгийг цэвэр нямбай, гамтай хэрэглэх талаар суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад заавар, зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллана.

**Гурав. Сурах бичиг ашиглуулах үйлчилгээний төлбөр**

3.1. Сурах бичиг ашиглуулах үйлчилгээний төлбөр /цаашид "төлбөр" гэх/-ийн хэмжээг энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу анги тус бүрээр, сурах бичиг ашиглагдсан хугацаанаас хамаарсан элэгдэлтэй тооцож, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар баталгаажуулна.

3.2. Төлбөрийг төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн суралцагч сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансанд, төрийн бус өмчийн сургуулийн суралцагч тухайн байгууллагын дансанд тус тус тушаана.

3.3. Төлбөр төлөгч этгээд төлбөрийн баримтын гүйлгээний утга хэсэгт сургууль, анги, бүлэг, суралцагчийн овог, нэрийг тодорхой бичнэ.

3.4. Сургууль нь энэхүү журмын 3.4-т заасан дансанд төвлөрсөн төлбөрийг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төв төрийн сан дахь "СБТТоглолцоо-Эргэлтийн сан 100900015403" дугаар дансанд шилжүүлнэ.

3.5. Сургууль нь төлбөрийн баримтын гүйлгээний утга хэсэгт аймаг, сум, дүүрэг, сургуулийн нэрийг тодорхой бичнэ.

3.6 Төлбөрийг хугацаанд нь холбогдох дансанд шилжүүлэх, өр авлага үүсгэхгүй байхад сургуулийн захирал хяналт тавина.

3.7. Төлбөрийг сургууль бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

3.8. Сурах бичиг ашиглуулсны төлбөрөөр бий болсон эх үүсвэрийг төлбөртэй ашиглуулах сурах бичгийг нөхөн хангах болон хяналт тавих зардал, сум, тосгонд сурах бичиг хүргэлтэй холбоотой зардлын зарим хэсэгт зарцуулна.

3.9. Энэхүү журмын 3.9-д заасан зардлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар жил бүр батална.

## Дөрөв. Захиалга, тайлан, мэдээ

4.1. Сургууль нь сурах бичиг төлбөртэй ашиглуулсантай холбоотой тайлан, мэдээг энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан Маягт 1-ийн дагуу жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор, сурах бичгийн нөхөн хангалт хийх захиалгыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэст ирүүлнэ.

4.2. Аймгийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь сургуулиудаас ирүүлсэн тайланг нэгтгэн энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан Маягт 2-ын дагуу жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор, сурах бичгийн нөхөн хангалт хийх захиалгыг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

## Тав. Бусад

5.1. Төлбөртэй ашиглуулах сурах бичгийг үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болгосон тохиолдолд буруутай этгээд тухайн сурах бичгийн үнийг энэхүү журмын 3.4-д заасан дансанд тушаана.

5.2. Төлбөртэй ашиглуулах сурах бичиг нь бусад сурах бичгээс ялгагдах тэмдэглэгээтэй байна.

5.3. Энэхүү журмыг зөрчсөн албан хаагчийн үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

---oOo---

**Хавсралт 1**

Сурах бичиг ашиглуулах үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох аргачлал

1. Сурах бичиг ашиглуулах үйлчилгээний төлбөр /цаашид "төлбөр" гэх/-ийн хэмжээг тооцохдоо гурваас дөрвөн жилийн дараа төлбөртэй ашиглуулах хэрэгцээт бүх сурах бичгийг дахин худалдан авахад шаардагдах зардлын эх үүсвэр хуримтлуулсан байх ёстойг харгалзана. Төлбөрийн хэмжээ сурах бичиг ашиглагдсан жилээс хамаарч жил бүр буурсан байна.

2. Дараах хүчин зүйлсийг тооцон төлбөрийн хэмжээг тодорхойлно.

Сурах бичгийн багц дахь номын тоо ...

| № | Тооцоололд хамаарах хүчин зүйлс | Коэффициент |
|---|---|---|
| a | Сурах бичгийн багцын үнэ | x |
| b | 4 жилийн элэгдэл /12%/ | 1.12 |
| c | 4 жилийн инфляци /32%/ | 1.32 |
| d | Суралцагчийн тооны 4 жилийн өсөлт /4%/ | 1.04 |
| e | Сурах бичгийн ашиглалтын хугацаа | 4 жил |
| f | Төлбөрийн хуримтлалын хувь /98%/ | 0.98 |

3. Төлбөрийн дунджийг тооцоолох томьёо:

$$\text{Төлбөрийн дундаж} = \frac{\text{Сурах бичгийн багцын үнэ } (a) \times \text{ элэгдлийн хувь } (b) \times \text{ инфляци } (c) \times \text{ суралцагчийн тооны өсөлт } (d)}{\text{Сурах бичгийн ашиглалтын хугацаа } (e) \times \text{ төлбөрийн хуримтлалын хувь } (f)}$$

4. Сурах бичиг ашиглагдсан хугацаанаас хамааруулж төлбөрийг тооцохдоо (a) шинэ сурах бичгийн хувьд төлбөрийн дунджийг 1,08 гэсэн, (b) 2 дахь жилдээ ашиглагдах сурах бичгийн хувьд төлбөрийн дунджийг 1,03 гэсэн, (c) 3 дахь жилдээ ашиглагдах сурах бичгийн хувьд төлбөрийн дунджийг 0,97 гэсэн, (d) 4 дэх жилдээ ашиглагдах сурах бичгийн хувьд төлбөрийн дунджийг 0,94 гэсэн итгэлцүүрээр тус тус үржүүлнэ.

---oOo---

Хавсралт 2

## Маягт 1

Аймаг, нийслэл: ..............................................................
Сум, дүүрэг: ..............................................................
Сургууль: ..............................................................
Дансны дугаар: ..............................................................
Шилжүүлэг хийсэн огноо: ..............................................

/төгрөг/

| Д/д | Сургуулийн нэр | Анги | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | Үлдэгдэл төлбөр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | VI анги | | | | | | | |
| 2 | | VII анги | | | | | | | |
| 3 | | VIII анги | | | | | | | |
| 4 | | IX анги | | | | | | | |
| 5 | | X анги | | | | | | | |
| 6 | | XI анги | | | | | | | |
| 7 | | XII анги | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | |

## Маягт 2

Аймаг, дүүрэг ..............................................................

/төгрөг/

| Д/д | Сургуулийн нэр | Анги | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | Үлдэгдэл төлбөр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | VI анги | | | | | | | |
| | | VII анги | | | | | | | |
| | | VIII анги | | | | | | | |
| | | IX анги | | | | | | | |
| | | X анги | | | | | | | |
| | | XI анги | | | | | | | |
| | | XII анги | | | | | | | |
| 2 | | VI анги | | | | | | | |
| | | VII анги | | | | | | | |
| | | VIII анги | | | | | | | |
| | | IX анги | | | | | | | |
| | | X анги | | | | | | | |
| | | XI анги | | | | | | | |
| | | XII анги | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | |

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
**БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН**
**ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 09 өдөр | Дугаар А/91 | Улаанбаатар хот

Суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж
хувь бодох аргачлал батлах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/156 дугаар тушаалаар батлагдсан "Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам"-ын 4 дүгээр хэсгийн 4.6.5 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Боловсролын үнэлгээний төвийн дүрэм"-ийн 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж хувь бодох аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Ш.Шижир-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАН-ЭРДЭНЭ

Боловсролын үнэлгээний төвийн захирлын
2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн
А/46 дугаар тушаалын хавсралт

## СУРАЛЦАГЧИЙН СУРЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ ХУВЬ БОДОХ АРГАЧЛАЛ

1. Суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж хувь бодоход сургалтын төлөвлөгөөний дагуу судалж, үнэлэгдсэн хичээл бүрээр авсан үнэлгээ /хувь/-г тухайн хичээлийг 7 хоногт судалсан цагаар үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг 7 хоногт судалсан цагийн нийлбэрт хуваах /арифметикийн жигнэсэн дундаж/, аравны орны нарийвчлалтай бодож гаргана.

$$\text{Сурлагын үнэлгээний дундаж хувь} = \frac{a_1 \cdot S_1 + a_2 \cdot S_2 + \cdots + a_n \cdot S_n}{S_1 + S_2 + \cdots + S_n}$$

n- хичээлийн тоо

$a_1, a_2 \ldots a_n$ – сургалтын төлөвлөгөөний дагуу судалж үнэлэгдсэн заавал болон сонгон судалсан, тэрэлжсэн эсхүл гүнзгийрүүлэн судалсан хичээлийн үнэлгээ /хувь/

$S_1, S_2 \ldots S_n$ – сургалтын төлөвлөгөөний дагуу тухайн хичээлийг 7 хоногт судалсан цаг

2. Сурлагын үнэлгээний дундаж хувийг тооцоход анги дэвших болон улсын шалгалтын үнэлгээ хамааралгүй.

3. Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчдөд олгох боловсролын баримт бичиг /гэрчилгээ, үнэмлэх/-т бичигдэх сурлагын үнэлгээний дундаж хувийг боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэгдсэн суралцагчийн үнэлгээний мэдээлэлд үндэслэн тооцно.

4. Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчийн сурлагын үнэлгээний дундаж хувь тооцоход тухайн түвшинд судалсан хичээлийн сүүлийн ангийн сурлагын үнэлгээ, 7 хоногт судалсан цагийн өгөгдлийг ашиглана.

---ooo---

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# ТОГТООЛ

2019 оны 5 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 200 | Улаанбаатар хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.15, 5.5.10 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хамтран батлахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт, хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг эрхэлсэн салбар болон харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ажиллагааг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, түүнд шаардагдах хөрөнгийг эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд | У.ХҮРЭЛСҮХ

Батлан хамгаалахын сайд | Н.ЭНХБОЛД

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд | Ё.БААТАРБИЛЭГ

Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолын хавсралт

# ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДАД ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ ТӨЛӨВШҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

## Нэг. Ерөнхий мэдээлэл

Монголчуудын эх оронч үзэл эрт эртний уламжлалтай бөгөөд түүний түүхэн улбаа нь эртний нүүдэлчдийн газар нутгаа хайрлан хамгаалах сэтгэлгээнээс эхтэй. Монгол Улс уудам газар нутагтай, нүүдэлчдийн соёл иргэншилтэй, баялаг түүхтэй, хүүхэд, залуучуудад эх оронч ухаарал, үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэх асуудлыг хэт үндсэрхэг үзлийн үүднээс биш, тэдний өөрсдийгөө таних, төлөвшүүлэх, дангааршил хийгээд даяаршихуйд нийцэхүйц боловсрол, соёлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болгон дэвшүүлж байна.

Ийнхүү хүүхэд, залуучуудад эх орноо хайрлан хамгаалах, хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүргийг ухааруулан ойлгуулж, эх орон, тусгаар тогтнол, эх хэл, үндэсний түүх, соёлоороо бахархах, дээдлэн хүндэтгэх, газар нутаг, байгаль орчноо хайрлах итгэл үнэмшлийг төрүүлэх замаар улс орныхоо тогтвортой хөгжлийг хангах, тусгаар тогтнолынхоо баталгааг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх нь Монгол Улсын язгуур эрх ашгийг бодлогын бүх түвшинд эн тэргүүнд тавих, монгол хүний хөгжил, эх оронч ухамсар, хандлага, монгол ахуй, ёс соёл, зан заншлыг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, чанарыг дээшлүүлэх суурь үндэс болно.

Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-д заасны дагуу "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн зорилтуудыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдтэй харьцсан уялдаа байгааг шинжилж үзэхэд 5 үзэл баримтлал, 16 хууль, 9 бодлогын баримт бичиг, 18 үндэсний хөтөлбөрийн нийт 483 хэсэг, заалтуудад шууд тусгагдсан, заримтай нь агуулгын хувьд уялдсан байна.

Тухайлбал, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010 он)-д үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны нэг чухал зарчим нь "Эх оронч үндэсний үзлийг дээдлэх", "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д "Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна" гэсэн хоёрдугаар зорилт, "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс"-ийн 5.3-т "Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж, хэрэгжүүлнэ" гэж тус тус тодорхойлсон.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.15-д "Сургалтын хөтөлбөр, төлөвлөлтөнд хүүхдийг хүнлэг, эх оронч, үндэсний ухамсар, бахархалтай иргэн болж төлөвшүүлэхэд чиглэсэн

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 23 өдөр Дугаар А/323 Улаанбаатар хот

Арганчилсан заавар батлах тухай

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" 183 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 3.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн анги дүүргэлт хэт өндөртэй хүүхдийн цэцэрлэгийн ачааллыг бууруулах, 3 ээлжээр хичээллэж буй ерөнхий боловсролын сургуулийг 2 ээлжид шилжүүлэх арганчилсан зааврыг хавсралт ёсоор баталсугай.

2. Арганчилсан зааварт заасан үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд чанартай шуурхай хийж гүйцэтгэхийг Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /С.Дуламжав/, Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нэм-Очир/, Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Нансалмаа/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд холбогдсон удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд Г.Ганбаярт даалгасугай.

САЙД Е.БААТАРБИЛЭГ

0901002

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн А/[illegible] дугаар тушаалын хавсралт

# НИЙСЛЭЛИЙН АНГИ ДҮҮРГЭЛТ ХЭТ ӨНДӨРТЭЙ ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН АЧААЛЛЫГ БУУРУУЛАХ, 3 ЭЭЛЖЭЭР ХИЧЭЭЛЛЭЖ БУЙ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙГ 2 ЭЭЛЖИД ШИЛЖҮҮЛЭХ АРГАЧИЛСАН ЗААВАР

***Нэг: Нийтлэг үндэслэл***

1. Энэхүү аргачилсан зааврыг /цаашид "заавар" гэх/ нийслэлийн анги дүүргэлт хэт өндөртэй хүүхдийн цэцэрлэгийн ачааллыг бууруулах, нийслэлд 3 ээлжээр хичээллэж буй ерөнхий боловсролын сургуулийг 2 ээлжид шилжүүлэх ажлын хүрээнд хичээл, сургалтын үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомжид заасны дагуу түрээсийн байранд түр зохион байгуулахад мөрдөнө.

2. Зааврын гол зорилго нь нийслэлийн анги дүүргэлт хэт өндөртэй хүүхдийн цэцэрлэгийн ачааллыг бууруулах, нийслэлд 3 ээлжээр хичээллэж буй ерөнхий боловсролын сургуулийг 2 ээлжид шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмч, хувийн өмчийн барилгын зарим анги танхим, хэсгийг түр хугацаагаар эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, шийдвэрт үндэслэн харилцан тохиролцсоноор түрээслэх, зохих төлбөрийг шилжүүлэх харилцааг зохицуулахад оршино.

***Хоёр: Эрх зүйн үндэслэл***

Нийслэлийн анги дүүргэлт хэт өндөртэй хүүхдийн цэцэрлэгийн ачааллыг бууруулах, 3 ээлжээр хичээллэж буй ерөнхий боловсролын сургуулийг 2 ээлжид шилжүүлэх үйл ажиллагааг богино хугацаанд зохих шаардлага, стандарт хангасан сургалтын орчинтой байр, адил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын байр, анги танхимыг холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу түрээсийн гэрээ байгуулж шийдвэрлэх нь эрх зүйн хувьд боломжтой байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.3-т "Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжинд шилжүүлнэ" гэж заасан.

Иргэний хуулийн 27 дугаар бүлэгт Түрээсийн гэрээний харилцааг хуульчилсан байх бөгөөд тус хуулийн 318 дугаар зүйлийн 318.1 дэх хэсэгт "Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ." гэж заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр концессын болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулах болно." гэж заасан нь өмчийн хэлбэр үл харгалзан зохих шаардлага, стандарт хангасан сургалтын орчинтой байр, адил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын байр, анги танхимыг холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу түрээсийн гэрээ байгуулах шийдвэрлэх эрх зүйн гол зохицуулалт юм.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн "Журам батлах тухай" 134 дүгээр тогтоолын хавсралтаар "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ыг баталсан байна. Тус журмыг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай" 119 дүгээр тогтоол, 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 102 дугаар тогтоолоор "Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ"-ний үлгэрчилсэн загварыг тус тус баталсан байна.

***Гурав: Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулах ажлын зохион байгуулалт***

Зохион байгуулалтыг 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

<u>1 дүгээр үе шат:</u> Нийслэлийн анги дүүргэлт хэт өндөртэй хүүхдийн цэцэрлэгийн ачааллыг бууруулах, нийслэлд 3 ээлжээр хичээллэх бүй ерөнхий боловсролын сургуулийг 2 ээлжид шилжүүлэхэд шаардлагатай судалгаа тооцооллыг хийж, шаардлагатай тохиолдолд эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх.

<u>2 дугаар үе шат:</u> Гэрээ байгуулах ажлыг хийж гүйцэтгэх.

**<u>1 дүгээр үе шатанд доор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.</u>**

1. Шинээр цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилга барих ажил 3 хүртэл жилийн хугацаанд үргэлжилнэ. Барилгын ажил үргэлжлэх хугацаагаар цэцэрлэгийн зориулалттай баригдсан барилгыг ашиглах, ерөнхий боловсролын сургуулийн бүлэг шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд сургуулийн үйл ажиллагааг бүхэлд нь зохион байгуулах түр түрээсийн гэрээ байгуулахад дараах асуудлыг Нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс, тухайн цэцэрлэг, сургуулийн удирдлага судлан тооцоолж, хэрэв эрсдэлтэй гэж үзвэл түүнийг арилгасны дараа гэрээ байгуулах. Үүнд:

1.1. Түрээслэх боломжтой барилга, байр, анги танхим нь сургалтын орчны стандарт, шаардлагыг бүрэн хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргах.

1.2. Нэг хүүхдэд ногдох м.кв-ын талбайн шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргах.

1.3. Хичээл сургалтын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай лаборатори, тоног төхөөрөмж, тоглоом хэрэгсэл хүрэлцээтэй эсэх, тэдгээрийг холбогдох шаардлагыг хангах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын талаар гэрээнд тусгах санал боловсруулах.

1.4. Анги бүлгээр хичээллэхэд хүүхдийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хийх хүн хүчний болон бусад автомашин зэрэг

зайлшгүй шаардагдах нөөц боломж хүрэлцээтэй эсэх, шаардлагатай авах арга хэмжээний санал боловсруулах.

1.5. Хичээл заах багш нарын ажлын ачаалал, илүү цагийн зардлыг санхүүжүүлэх боломжтой эсэх, авах арга хэмжээний санал боловсруулах.

1.6. Хичээл, сургалтын үйл ажиллагаанаас гадна суралцагчдын хөгжих боломж алдагдуулахгүй байх нөхцөл хангагдах эсэх, авах арга хэмжээний санал боловсруулах.

1.7. Боловсролын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.4 дэх заалтад заасан "Боловсролын байгууллагыг бэхжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, иргэн тэтгэсний төлөө хууль тогтоомжид заасан зохих хөнгөлөлт эдлэх" хөшүүргийг хэрэглэх боломжтой эсэх, санхүүгийн тооцооллыг хийх, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний санал боловсруулж эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх.

1.8. Түрээсийн гэрээнд тусгах саналыг багцлан боловсруулах.

2. Түрээсийн гэрээний төслийг яамны Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар, Ерөнхий боловсролын бодлогын газар танилцан тус тус саналаа тусгана.

3. Төрөөс олгох хувьсах зардал, тогтмол зардлыг хэрхэн олгох, санхүүжүүлэх эх үүсвэрийг эрх бүхий этгээдтэй хамтран шийдвэрлэх эсэх асуудлыг Нийслэлийн боловсролын газар яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт танилцуулж, хамтран санал боловсруулна.

4. Нийслэлийн Засаг дарга 2019 оны 06 дугаар сард багтаан түрээсийн байранд үйл ажиллагаа явуулах цэцэрлэг, сургуулийн жагсаалтыг үндэслэл, дэлгэрэнгүй тайлбарын хамт Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдад албан бичгээр ирүүлнэ.

<u>2 дугаар үе шатанд доор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.</u>

Нэгдүгээр үе шатанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд үндэслэн холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохих шаардлага стандарт хангасан барилгыг түрээсийн гэрээ байгуулан ашиглах, хичээл сургалтын үйл ажиллагааг сурагч, багш, ажилтны эрх ашигт нийцүүлэн зохион байгуулах. Ингэхдээ доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Нийслэлийн анги дүүргэлт хэт өндөртэй хүүхдийн цэцэрлэгийн ачааллыг бууруулах, нийслэлд 3 ээлжээр хичээллэж буй ерөнхий боловсролын сургуулийг 2 ээлжид шилжүүлэх түрээсийн байранд үйл ажиллагаа явуулах сургууль, цэцэрлэгийн жагсаалтыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар батална.

2. Түрээсийн гэрээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолоор батлагдсан үлгэрчилсэн загварын дагуу байгуулна.

3. Түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын баталсан жишиг үнэд нийцүүлж түрээслэгчтэй тохиролцон тогтоох зохион байгуулалтын арга хэмжээг авч, Сангийн яамнаас санал авна. Түрээсийн төлбөрийн хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар баталгаажуулна.

4. Түрээсийн гэрээг талууд харилцан тохиролцон байгуулж, албажуулсны дараа Эд хөрөнгийн улсын бүртгэлийн эрх бүхий байгууллагад бүртгүүлнэ.

5. Гэрээ хэрэгжих 3 ээлжтэй ерөнхий боловсролын сургууль 2 ээлжид шилжих хүртэл хугацаанд гэрээний хэрэгжилт, сургалтын үйл ажиллагаа болон бусад холбогдох үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах чиг үүргийг яамнаас үе шаттай зохион байгуулна.

- - - oOo - - -

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 12 өдөр    Дугаар А/390    Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" багш нарын улсын хоёрдугаар зөвлөгөөнд оролцогчдын санал, зөвлөмж, "Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр" үндэсний хэлэлцүүлэгт оролцогчдын санал, дүгнэлт, Монголын багш нарын VII их хурлын төлөөлөгчдийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн суралцагчдын судлах "Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөрийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. "Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр үл харгалзан ерөнхий боловсролын нийт сургуульд 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсүгэй.

3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажиллагааг Ерөнхий боловсролын бодлогын газар /Г.Ням-Очир/, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх ажиллагааг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус даалгасугай.

4. "Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны "Сургалтын төлөвлөгөө, цөм хөтөлбөр, багийн бүрэлдэхүүн батлах тухай" А/240 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн" 6.1, 6.2-т заасан "Иргэний боловсрол" хэсэгт хамаарах хэсгийг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны "Сургалтын цөм хөтөлбөр батлах тухай" А/302 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн" "Иргэний боловсрол" хэсэгт хамаарах хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД    Ё.БААТАРБИЛЭГ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2019 оны 08 дугаар сарын 15-ны
өдрийн А/552 дугаар тушаалын хавсралт

## "ИРГЭНИЙ ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ" СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

### Нэг. Удиртгал

Монгол Улсын 1992 онд батлагдсан "Үндсэн хууль"-ийн эхэнд "Монголын ард түмэн бид:

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
- хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
- хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно" хэмээн заажээ.

Монгол Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх зэргийг эрхэм зорилго болгосон иргэн "Үндсэн хууль"-аа хэрэгжүүлэх юм.

"Үндсэн хууль"-ийн энэхүү заалт бодитой болгох бүх иргэн хойч үеэ хүмүүжүүлэхэд нийцүүлэх байгаа багш нар эгүүлж, юу дараа хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны талаар Монгол Улсын Засгийн газарт уламжилсан юм.

Монголын багш нарын VII их хурлын тогтоолд "Хүүхэд бүрийг монгол хэл, түүх, соёл, ёс заншил, эх уламжлалыг өвлөх, хөгжүүлэх, амьдрах ухааны чадвартай болгоход сургалтын бодлогыг чиглүүлэх. Бүх шатны боловсролын байгууллага нь хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн талаар үүрэг, хариуцлага хүлээдэг байх хууль, эрх зүйн орчин бий болгох, эцэг эх, асран хамгаалагчийн хүүхдийнхээ хөгжил, төлөвшил, хүмүүжил, хичээл, сургалтанд анхааран хандуулах, сургууль, багшид дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах журмыг үүргийг хуульчлах, улмаар багшийн ёс зүйн боловсролыг дээшлүүлэх, нийгэмд ээ үлгэр дуурайл үзүүлж, хөгжлийг түүчээлэх, салбарын үнэт зүйл, хариуцлага, хандлагын сайн жишээг тогтоох" хэмээн дурджээ.

1

БАТЛАВ.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
ДЭД САЙД Г.ГАНБААР

## 2019-2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Бэлтгэл хангах үйл ажиллагаа | | Зохион байгуулах үйл ажиллагаа | Хугацаа 2019 он | Хэрэгжүүлэх байгууллага | Зохион байгуулалтын удирдлагаар хангах байгууллага | Хяналт тавих байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, багшлах боловсон хүчин, хүний нөөцийн асуудлаар | | | | | | | |
| 1 | Сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 1 | Сургалтын төлөвлөгөө, цагийн норм нормативын тооцоог гаргах холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх | VII/15-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУТ | БСШУСЯ БХ |
| | | 2 | Сайжруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах | VIII/15-VIII/31 | СӨББ ЕБС | НБГ-ДБХ БСУТ | БСШУСЯ БХ |
| | | 3 | Шинээр гарсан дүрэм журмуудыг боловсролын сургалтын байгууллагын удирдлага, багш нарт сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих | VIII/15-VIII/31 | НБГ-ДБХ БСУТ | БХ БМДИ БҮТ НТБҮТ | БСШУСЯ |
| | | 4 | БСШУС-ын сайдын 2019 оны А/302 дугаар тушаалын дагуу сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний бэлтгэлийг хангах | VII/15-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУТ | БСШУСЯ БХ |
| | | 5 | БСШУС-ын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалын дагуу хамран сургах тойргийн ХБХ-ийн судалгааг нарийвчлах, суралцуулах бэлтгэл ажлыг хангах | VII/15-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУТ | БСШУСЯ Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 6 | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 145 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахад анхаарч, төсвийн төлөвлөлт, судалгаа тооцоог нарийвчлах | VII/15-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУТ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Багшлах боловсон хүчин, хүний нөөцийг зөв төлөвлөх | 1 | Дутагдалтай болон илүүдэлтэй багшийн судалгаа гаргах, төлөвлөлт хийх, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах | VI/01-VI/15 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | БОШУСЯ БХ БМДИ |
| | | 2 | Удирдах ажилтны сургалт, багш нарын бага хурлыг хичээлийн жил эхлэхээс өмнө зохион байгуулах | VIII/15-VIII/30 | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ | БОШУСЯ БХ БМДИ |
| | | 3 | Багш нарыг төлөвлөгөөт сургалт, семинаруудад оролцуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах | Батлагдсан хуваарь, графикийн дагуу | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | БОШУСЯ БХ БМДИ |
| | | 4 | Багш, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулах, тэр дундаа сүрьеэгийн үзлэг шинжилгээнд заавал хамруулсан байх | VIII/15-VIII/30 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 5 | Багшийн хувийн хэргийг хянах чиглэлд анхаарч, зуны хугацаанд мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх заавар, зөвлөмж өгч ажиллах | VI/15-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | БОШУСЯ БМДИ Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| 3 | Хичээлийн шинэ жилийн бэлтгэлийг хангах | 1 | 2019-2020 оны хичээлийн жилийн элсэлт, төгсөлтийн төлөвийг урьдчилан гаргах, 2020 оны төсвийн төлөвлөлттэй уялдуулах | VI/15-VIII/01 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 2 | Элсэлтийг эцэг эх, иргэдэд чиглэсэн, хүндрэлгүйгээр зохион байгуулах, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах | VI/15-VII/01 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 3 | Удирдлага, багш нэг бүр шинэ хичээлийн жилийн бэлтгэл ажлыг бүрэн хангах, хичээлийн шинэ жилийг эхлүүлэх | VIII/15-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | БОШУСЯ Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| 4 | Багш, суралцагчдын аюулгүй байдлыг хангах | 1 | Эрдмийн баяр, тайлант өдөрлөг зэрэг төлөвлөсөн үйл ажиллагааг зохион, зуны амралтын хугацаанд эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах, тэдний аюулгүй байдлыг хангах, | VI/01-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эрүүл мэндийг дэмжих талаар зайлшгүй анхаарахуйц ач, эцэг эхчүүдийг мэдээ мэдээллээр хангах | | | | |
| | | 2 | Зүүн аймагт эхлэж байгаатай холбогдуулан гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй, эцэг эхийн хараа хяналт сул, эрсдэлд өртөж болзошгүй хүүхдүүдийг хяналттай байлгах арга хэмжээ авч, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах | VI/01-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 3 | Бага, ахлагчдын холбооны ажилтныг бүрэн зүүгүүлэхэд анхаарч, шаардлагатай зохицуулалт хийх | VI/01-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 4 | Байгууллагын харуул хамгаалалтыг сайжруулах, гэнэтийн осол аваараас /байгалийн гамшиг, аюулт үзэгдэл/ урьдчилан сэргийлэх хяналт тавьж ажиллах | VI/01-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| **Хоёр. Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр** | | | | | | | |
| 1 | Орчны аюулгүй байдлыг хангах | 1 | Цэцэрлэг, сургуулийн орчин дахь "Эрсдэлийн зөрлийн үнэлгээ" хийх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах | VI/01-VIII/25 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 2 | Орчны аюулгүй байдалд тавигдах ерөнхий шаардлагыг мөрдөж ажиллах | Хичээлийн жилийн туршид | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 3 | Монгол Улсын стандарт MNS 6444:2014 "Сургуулийн бус, техникийн ерөнхий шаардлага"-ын хэрэгжилтийг хангах | VI/01-VIII/25 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| 2 | Эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах | 1 | Барилга байгууламжийн ариутгал, халдваргүйтгэлийг хичээл эхлэхээс өмнө хийсэн байх | VI/01-VIII/25 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 2 | Хоол, хүнсний аюулгүй байдалд хяналт тавих нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, хичээлийн жилийн турш мөрдөж ажиллах | Хичээлийн жилийн туршид | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эрүүл мэндийг дэмжих талаар заавар зөвлөмжийг өгч, эцэг эхчүүдийг мэдээ мэдээллээр хангах | | | | |
| | | 2 | Зуны амралт эхэлж байгаатай холбогдуулан гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй, эцэг эхийн хараа хяналт сул, эрсдэлд өртөж болзошгүй хүүхдүүдийг хяналттай байлгах арга хэмжээ авч, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах | VI/01-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 3 | Багш, ажилтны ээлжийн амралтыг бүрэн эдлүүлэхэд анхаарч, шаардлагатай зохицуулалт хийх | VI/01-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 4 | Байгууллагын харуул хамгаалалтыг сайжруулж, гэнэтийн осол аюулаас /Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл/ урьдчилан сэргийлж хяналт тавьж ажиллах | VI/01-VIII/31 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| **Хоёр. Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр** | | | | | | | |
| 1 | Орчны аюулгүй байдлыг хангах | 1 | Цэцэрлэг, сургуулийн орчин дахь "Эрсдэлийн үнэлгээ" хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах | VI/01-VIII/25 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 2 | Орчны аюулгүй байдалд тавигдах ерөнхий шаардлагыг мөрдөж ажиллах | Хичээлийн жилийн туршид | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 3 | Монгол Улсын стандарт MNS 6444:2014 "Сургуулийн бүс, техникийн ерөнхий шаардлага"-ын хэрэгжилтийг хангах | VI/01-VIII/25 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| 2 | Эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах | 1 | Барилга байгууламжийн арчилгаа, халдваргүйтгэлийг хичээл эхлэхээс өмнө хийсэн байх | VI/01-VIII/25 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 2 | Хоол, хүнсний аюулгүй байдалд хяналт тавих нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, хичээлийн жилийн туршид мөрдөж ажиллах | Хичээлийн жилийн туршид | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ-ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Өвөлжилтийн бэлтгэлийг хангах | 1 | Байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах комиссыг одооноос ажиллуулж, шаардагдах хөрөнгө төсвийг холбогдох байгууллагуудад уламжилж шийдвэрлүүлэх | VI/01-VIII/25 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 2 | Халаалт, дулааны асуудал, түлшний нөөц, барилга байгууламжийн хана, цонх, хаалга, дээврийн дулаан алдагдлыг бууруулах арга хэмжээ авах | VI/01-VIII/25 | СӨББ ЕБС АБ-НТБТ | НБГ ДБХ БСУГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга ЗДТГ |
| | | 3 | Төвлөрсөн бус халаалттай нийслэлийн цэцэрлэг, сургуулийн асуудалд анхаарч, холбогдох шийдвэр гаргах | VI/01-VIII/25 | Нийслэлийн СӨББ ЕБС | НБГ ДБХ | нийслэлийн Засаг дарга ЗДТГ |

---оОо---

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 01 өдөр Дугаар А/490 Улаанбаатар хот

Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах тухай

Бага, дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсэг, "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" багш нарын улсын хоёрдугаар зөвлөгөөнд оролцогчдын санал, зөвлөмж, "Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр" үндэсний хэлэлцүүлэгт оролцогчдын санал, дүгнэлт, Монголын багш нарын VII их хурлын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, сум, тосгон, багийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцийг нэгдүгээр, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцийг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан хичээлийн жилийн бүтцийг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуульд мөрдсүгэй.

3. Хичээлийн жилийн бүтцийн нийт долоо хоногоос нийтээр тэмдэглэх баярын өдрүүдийг нийлүүлэн 1 долоо хоног байхаар тооцож, бага ангид 31, дунд, ахлах ангид 32 долоо хоногоор сургалтын хөтөлбөрийн агуулгыг төлөвлөхийг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга /Т.Нина-Очир/, Боловсролын хүрээлэнгийн захирал /П.Пүрэвсүрэн/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах тухай" А/081, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Хичээлийн жилийн бүтцэд өөрчлөлт оруулах тухай" А/747 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Ё.БААТАРБИЛЭГ

301567

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын [illegible] өдрийн А/490 дугаар тушаалын хавсралт

**Аймаг, сум, тосгон, багийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц**

| Улирал | Нэг | | Хоёр | | Гурав | | Дөрөв | | | Нийт 7 хоног |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сар | IX–X | | XI–XII | | I–III | | IV–VI | | | |
| 7 хоног | 1–8 | 9 | 10–18 | 19 | 20–30 (24 – А) | 31 | 32–38 | 39 | 40 | |
| Анги I–V | 8 долоо хоног | А | 8 долоо хоног | А | 9 долоо хоног | А | 7 долоо хоног | Ш | А | 32 |
| Анги VI–XII | 8 долоо хоног | А | 8 долоо хоног | А | 9 долоо хоног | А | 7 долоо хоног | Ш | А | 33 |

1. Хичээлийн жилийн сүүлийн 7 хоногт 1-3 дугаар анги, бүрэн, дунд ... бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулна.
2. 1, 2, 3 дугаар улирлын амралт Даваа гарагт эхлэж, Баасан гарагт дуусна.
3. 3 дугаар улирлын хугацаанд Цагаан сарын баяр 1 долоо хоног амрах тул бүх ангийн суралцагчид 9 долоо хоног хичээллэнэ. Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3-ны өдрүүд тохиох бүтэн 7 хоногт амарна. Шинийн 1, 2-ны өдөр 7 хоногийн Баасан, Ням гарагт тохиолдвол дараа 7 хоногт нь амарна.
4. Газар зүйн байршил, цаг уурын онцлог, мал төллөх хугацаанаас хамааран 32 дугаар 7 хоногийн амралтыг 29 дүгээр 7 хоног, 30 дугаар 7 хоногийн амралтыг 33 дугаар 7 хоногт тус тус шилжүүлэн болно.
5. Газар зүйн байршил, цаг уурын онцлог, газар тариалангийн ажлын хугацаанаас хамааран зарим аймаг орон нутаг суралцагчдын 1 дүгээр улирлын 9 дүгээр 7 хоногийн амралтыг 8 эсвэл 10 дугаар 7 хоногт шилжүүлэн болно. Мөн 3 дугаар улирлын 30 дугаар 7 хоногийн амралтыг 1 дүгээр улирлын амралтад шилжүүлэн амралтын хугацааг 1 долоо хоногоор нэмж болно.

Тайлбарлолт: А - амралт
Ш - шалгалт

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны [illegible] дугаар сарын [illegible] өдрийн А/490 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц**

| Улирал | Нэг | | Хоёр | | Гурав | | Дөрөв | | | Нийт 7 хоног |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сар | IX–X | X | XI–XII | XII | I–III | III | IV–V | V–VI | VI | |
| 7 хоног | 1–8 | 9 | 10–16 | 17–18 | 19–27 | 28–29 | 30–37 | 38–39 | 40 | |
| Анги I–V | 8 долоо хоног | А | 7 долоо хоног | А | 9 долоо хоног (А) | А | 8 долоо хоног | Ш | А | 32 |
| Анги VI–XII | 8 долоо хоног | А | 7 долоо хоног | А | 9 долоо хоног (А) | А | 8 долоо хоног | Ш | А | 33 |

1 Хичээлийн жилийн бүтцийн 7 хоногт 1-3 дугаар анги, дунд, ахлах ангид бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулна.

2 1, 2, 3 дугаар улирлын амралт Даваа гараг эхэлж, Баасан гараг дуусна.

3 3 дугаар улирлын [illegible] Цагаан сарын үеэр 1 долоо хоног амрах тул бүх ангийн сурагчид 9 долоо хоног хичээллэнэ. [illegible] 1, 2, 3 [illegible] 7 хоногт амарна. [illegible] 1, 3 [illegible] 7 хоногийн [illegible] гараг [illegible] дараа 7 хоног нь амарна.

4 [illegible] 2 дугаар улирлын 16 дугаар эхлэл 20 дугаар 7 хоногт [illegible] 1 долоо хоногоор [illegible] болно.

Тэмдэглэгээ: А - амралт
Ш - шалгалт

# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 01 өдөр Дугаар А/491 Улаанбаатар хот

Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.8-3.2.17 дахь заалтууд, "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" багш нарын улсын хоёрдугаар зөвлөгөөнд оролцогчдын санал, зөвлөмж, "Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр" үндэсний хэлэлцүүлэгт оролцогчдын санал, дүгнэлт, Монголын багш нарын VIII их хурлын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургалтын төлөвлөгөөг нэгдүгээр, дунд ангийн сургалтын төлөвлөгөөг хоёрдугаар, ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг гуравдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар шинэчлэн баталсан сургалтын төлөвлөгөөг ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангид 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсүгэй.

3. Шинэчлэн баталсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах ажлыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга /Т.Ням-Очир/, сургалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхийг Боловсролын хүрээлэнгийн захирал /П.Пүрэвсүрэн/, сургалтын төлөвлөгөөг чанартай хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2018 оны А/453 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Ё.БААТАРБИЛЭГ

0901574

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2019 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн
А/491 дүгээр тушаалын хавсралт

## БАГА АНГИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д.д | Анги / Хичээл | I | II | III | IV | V | Нийт цаг |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бэлтгэл хөтөлбөр | 60 | | | | | 60 |
| 2 | Монгол хэл | 192 | 224 | 224 | 224 | 224 | 1088 |
| 3 | Иргэний ёс зүйн боловсрол | 64 | 64 | 64 | 64 | 64 | 320 |
| 4 | Математик | 112 | 160 | 160 | 160 | 160 | 752 |
| 5 | Хүн ба орчин | 64 | 64 | 64 | | | 192 |
| 6 | Хүн ба байгаль | | | | 64 | 64 | 128 |
| 7 | Хүн ба нийгэм | | | | 32 | 64 | 96 |
| 8 | Дүрслэх урлаг, технологи | 58 | 64 | 64 | 64 | 64 | 314 |
| 9 | Хөгжим | 58 | 64 | 64 | 64 | 32 | 282 |
| 10 | Биеийн тамир | 58 | 64 | 64 | 64 | 64 | 314 |
| 11 | Эрүүл мэнд | | | | 32 | 32 | 64 |
| 12 | Англи хэл | | | | | 96 | 96 |
| | Дүн | 666 | 704 | 704 | 768 | 864 | 3706 |
| 1 | Багш зохицуулах цаг | 64 | 34 | 34 | 34 | 33 | 199 |
| | Жилийн нийт цаг | | | | | | 3905 |
| | Долоо хоногийн нийт ачаалал | 20.8 | 22.0 | 22.0 | 24.0 | 27.0 | |
| | Өдрийн ачаалал | 4.2 | 4.4 | 4.4 | 4.8 | 5.4 | |

1. Хичээлийн жилд 32 долоо хоног хичээллэнэ. [illegible] хичээлийн үргэлжлэх хугацаа I-II ангид 35 минут, III-V ангид 40 минут байна.
2. Нэгдүгээр ангийн "Бэлтгэл" хөтөлбөр нь суралцагч сургуулийн амьдрал, сурах үйл ажиллагаанд бэлтгэхэд чиглэсэн нэгдмэл агуулгатай үйл ажиллагаа бөгөөд хичээлийн жилийн эхэнд хэрэгжүүлнэ.
3. "Багш зохицуулах цаг"-аар суралцагчдын хоцрогдол арилгахаас гадна, суралцагч, эцэг эхэд "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлээр зөвлөгөө өгнө.
4. "Багш зохицуулах цаг"-ийг хичээлийн цагт тооцно.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн
А/491 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

## ДУНД АНГИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д.д | Анги | | VI | VII | VIII | IX | Нийт цаг |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хичээл | | | | | | |
| 1 | Монгол хэл, бичиг | Монгол хэл | 99 | 66 | 66 | 66 | 297 |
| | | Үндэсний бичиг | 66 | 66 | 66 | 66 | 264 |
| | | Уран зохиол | 66 | 66 | 66 | 66 | 264 |
| 2 | Математик | | 165 | 132 | 132 | 132 | 561 |
| 3 | Мэдээллийн технологи | | 33 | 33 | 33 | 33 | 132 |
| 4 | Байгалийн ухаан | Физик | 33 | 66 | 66 | 66 | 231 |
| | | Биологи | 33 | 66 | 66 | 66 | 231 |
| | | Хими | 33 | 66 | 66 | 66 | 231 |
| 5 | Нийгмийн ухаан | Иргэний ёс зүйн боловсрол | 66 | 66 | 66 | 66 | 264 |
| | | Газар зүй | | 33 | 33 | 33 | 99 |
| | | Түүх | 33 | 66 | 66 | 66 | 231 |
| | | Нийгэм судлал | | 33 | 33 | 33 | 99 |
| 6 | Урлаг | Дүрслэх урлаг | 33 | 33 | 33 | | 99 |
| | | Хөгжим | 33 | 33 | 33 | 33 | 132 |
| 7 | Дизайн технологи | Зураг зүй, Технологи | 66 | 66 | 66 | 66 | 264 |
| 8 | Биеийн тамир, эрүүл мэнд | Биеийн тамир | 66 | 66 | 66 | 66 | 264 |
| | | Эрүүл мэнд | 33 | 33 | 33 | 33 | 132 |
| 9 | Гадаад хэл | Англи хэл | 99 | 99 | 99 | 99 | 396 |
| | | Орос хэл | | 66 | 66 | 99 | 231 |
| | Дүн | | 957 | 1155 | 1155 | 1155 | 4422 |
| 1 | Багш зохицуулах цаг | | | | | | 268 |
| | Жилийн нийт цаг | | | | | | 4690 |
| | Долоо хоногийн нийт ачаалал | | 29 | 35 | 35 | 35 | |
| | Өдрийн нийт ачаалал | | 5.8 | 7.0 | 7.0 | 7.0 | |

1. Хичээлийн жилд 33 долоо хоног хичээллэнэ. Заалгах хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна.
2. Сургалтын төлөвлөгөөний заасан цагт багтаан орон нутаг, сургуулийн онцлог болон багшийн нөөц хүчин зүйлээс үндэслэн заалгах хичээлийн үргэлжлэх хугацааг сургууль 80 минутаар зохион байгуулж болно.
3. "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлийг нийгмийн ухааны багш заана.
4. Хичээлийн жилд "Багш зохицуулах цаг"-аар монгол хэлний багш 18, нийгэм судлал, дүрслэх урлаг, зураг зүй, технологи, эрүүл мэндийн багш тус бүр 10, бусад хичээлийн багш нар тус бүр 15 цагт багтаан суралцагчдын хоцрогдол арилгах, давтлага өгөх, дугуйлан хичээллүүлэхээс гадна, суралцагч, эцэг эхэд "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлээр болон ажил мэргэжлийн талаар зөвлөгөө өгнө.
5. "Багш зохицуулах цаг"-ийг хичээлийн цагт тооцно.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2019 оны 08 дугаар сарын 01 -ны өдрийн
А/491 дүгээр тушаалын хавсралтаар хавсралт

## АХЛАХ АНГИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Хичээл \ Анги | X | XI | XII | Нийт цаг |
|---|---|---|---|---|---|
| **Заавал судлах** | | | | | |
| 1 | Монгол хэл | 33 | 33 | 33 | 99 |
| 2 | Үндэсний бичиг | 66 | 66 | 66 | 198 |
| 3 | Уран зохиол | 33 | 33 | 33 | 99 |
| 4 | Иргэний ёс зүйн боловсрол | 66 | 66 | 66 | 198 |
| 5 | Математик | 99 | 99 | 99 | 297 |
| 6 | Мэдээллийн технологи | 33 | 33 | 33 | 99 |
| 7 | Физик | 66 | 66 | | 132 |
| 8 | Хими | 66 | 66 | | 132 |
| 9 | Биологи | 66 | 66 | | 132 |
| 10 | Монголын түүх | 33 | 33 | | 66 |
| 11 | Нийгмийн судлал | 66 | 66 | | 132 |
| 12 | Газар зүй | 66 | 66 | | 132 |
| 13 | Англи хэл/Орос хэл | 99 | 99 | 99 | 297 |
| 14 | Биеийн тамир | 66 | 66 | 66 | 198 |
| 15 | Эрүүл мэнд | 33 | 33 | 33 | 99 |
| 16 | Дизайн/зураг зүй, технологи | 66 | 66 | 66 | 198 |
| | Дүн | 957 | 957 | 594 | 2508 |
| **Сонгон судлах** | | | | | |
| Хэл | Монгол хэл, бичиг | 198 | 231 | 594 | 1023 |
| | Уран зохиол | | | | |
| | Англи хэл | | | | |
| | Орос хэл | | | | |
| Математик | Математик | | | | |
| Байгалийн ухаан | Биологи | | | | |
| | Физик | | | | |
| | Хими | | | | |
| Нийгмийн ухаан | Түүх | | | | |
| | Нийгэм судлал | | | | |
| | Газар зүй | | | | |
| | Бизнес судлал | | | | |
| Дизайн технологи | Дизайн, зураг зүй | | | | |
| | Технологи | | | | |
| | Мэдээллийн технологи | | | | |
| 1 | Бага хөндийрүүлэх цаг | | | | 144 |
| | Заавал болон сонгон судлах хичээлийн нийт цаг | 1155 | 1188 | 1188 | 3531 |
| | Жилийн нийт цаг | | | | 3675 |
| | Долоо хоногийн нийт ачаалал | 35 | 36 | 36 | |
| | Өдрийн нийт ачаалал | 7 | 7 | 7 | |

1. Хичээлийн жилд 33 долоо хоног хичээллэнэ. Заавал хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна. Сургууль 80 минутаар хичээллэх зохицуулалт хийж болно.
2. Сургалтын төлөвлөгөөний заасан цагт багтаан орон нутаг, сургуулийн онцлог болон байгалийн нөөц [illegible] суралцагчийн хэрэгцээ сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлнэ.
3. "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлийг нийгмийн ухааны багш заана.
4. Суралцагч заавал судлах англи, орос хэлний аль нэгийг судална.
5. Суралцагч X ангид 4 хичээлийг 7 хоногт 1-2 цагаар (2 хичээлийг 2 цагаар, 2 хичээлийг 1 цагаар), XI ангид 3 хичээлийг 7 хоногт 2-3 цагаар (1 хичээлийг 3 цагаар, 2 хичээлийг 2 цагаар), XII ангид 3 хичээлийг 7 хоногт 4-6 цагаар (1 хичээлийг 4 цагаар 2 удаа, 1 хичээлийг 3 цагаар 2 удаа, 1 хичээлийг 4 цагаар 1 удаа) тус тус сонгон судална.
6. Заавал болон сонгон судлах хичээлийг 10, 11, 12 дугаар ангийн суралцагчдыг бүлэглэн холимог бүлгээр хичээллэж болно.
7. Заавал судлах хичээлийн цаг дээр сонгон судлах хичээлийн цагийг нэмж, заавал болон сонгон судлах сургалтын хөтөлбөрийг баримтлан хичээллэнэ.
8. Хичээлийн жилд "Бага хөндийрүүлэх цаг"-аар суралцагчдын хөгжлийг [illegible], дүгнэлт хийх, дутуйган хичээллүүлэхээс гадна, суралцагч, эцэг эхэд "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлтэй [illegible] тогтоож ажиллаж болно.
9. "Бага хөндийрүүлэх цаг"-ийг хичээлийн цагт тооцно.

# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 02 өдөр Дугаар А/492 Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 28.1.2, 28.1.8, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.8-3.2.17 дахь заалтууд, Боловсролын хүрээлэнгийн 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 124 дүгээр албан бичиг, "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" багш нарын улсын хоёрдугаар зөвлөгөөнд оролцогчдын санал, зөвлөмж, "Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр" үндэсний хэлэлцүүлэгт оролцогчдын санал, дүгнэлт, Монголын багш нарын VII их хурлын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага боловсролын монгол хэл, математик, хүн ба орчин, хүн ба нийгэм, хүн ба байгаль, дүрслэх урлаг, технологи, хөгжим, биеийн тамир, англи хэлний сургалтын сайжруулсан хөтөлбөрийг нэгдүгээр, суурь боловсролын монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик, биологи, хими, газар зүй, түүх, нийгэм судлал, хөгжим, дүрслэх урлаг, дизайн технологи, биеийн тамир, англи хэл, орос хэлний сургалтын сайжруулсан хөтөлбөрийг хоёрдугаар, бүрэн дунд боловсролын заавал судлах, сонгон судлах монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик, биологи, хими, газар зүй, нийгэм судлал, англи хэл, орос хэлний болон заавал судлах монголын түүх, биеийн тамир, дизайн зураг зүй, технологи, сонгон судлах түүх, дизайн технологийн сайжруулсан хөтөлбөрийг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр үл харгалзан ерөнхий боловсролын нийт сургуульд 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн тус тус сургалтад хэрэгжүүлсүгэй.

3. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах ажиллагааг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Мөнх-Очир/, хөтөлбөр хэрэгжүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхийг Боловсролын хүрээлэн /П.Пагмасүрэн/, хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

0301577

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төлөвлөгөө, цөм хөтөлбөр, багийн бүрэлдэхүүн батлах тухай" 2014 оны А/240 дугаар тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын цөм хөтөлбөр батлах тухай" 2015 оны А/302 дугаар тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр батлах тухай" 2016 оны А/277 дугаар тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай" 2018 оны А/551 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Ё.БААТАРБИЛЭГ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2019 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн
А/432 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## БАГА БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН САЙЖРУУЛСАН ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Боловсролын тухай хуульд "Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино"[1] гэж, Бага, дунд боловсролын тухай хуульд "Бага, дунд боловсролын зорилго нь суралцагчдад ерөнхий боловсрол эзэмшүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх, хүмүүнлэг ёсонд суралцах, авьяас чадвараа хөгжүүлэх, амьдрал, хөдөлмөрт болон тасралтгүй суралцахад өөрийгөө бэлтгэхэд нь туслахад оршино"[2] гэж, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод "Бага боловсролыг эх хэлний чадамжийг эзэмших боломжийг бүрдүүлсэн бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвших үе хэмээн хөгжүүлнэ"[3] гэж тус тус заасан.

Бага дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд нийгмийн амьдралын таатай орчин, хэм хэмжээг бий болгох, түүнд дасан зохицож амьдрах чадвартай, иргэншсэн монгол хүнийг төлөвшүүлэх, хүүхдийн суралцах хүсэл сонирхол, хэйк бүтээх тэмүүллийг боловсролын түвшин бүрт дэмжин хөгжүүлэхийг боловсролын зорилго болгон дэвшүүлсэн.

Ийнхүү Монгол Улсын боловсролын хууль тогтоомж, төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, хүүхэд бүрийн хөгжил, төлөвшлийг дэмжих үзэл баримтлал, хандлагад үндэслэн боловсруулсан бага боловсролын сургалтын хөтөлбөрийг 2014 оноос үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн үндэсний хэмжээний судалгаа, сурагчдын сурлагын амжилтын үнэлгээний үр дүн, боловсролын өнөөгийн хөгжлийн чиг хандлага болон дараах хэрэгцээ шаардлагад нийцүүлэн 2019 онд бага боловсролын сургалтын хөтөлбөрийг сайжруулж, сургууль, багш нарт хүргэж байна. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийн дараагийн үе шатны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;
- Сургууль, багш нарын хамтын ажиллагааг дэмжих, тогтворжуулах;
- Суралцах үйл ажиллагааг сурагчийн үнэт зүйл, хандлага, төлөвшилд чиглүүлэх;
- Сургалтын хөтөлбөрийн агуулгын давхардал, хүндрэлийг арилгах хэрэгжих нөхцөл боломжийг нэмэгдүүлэх;
- Сурагчдын сурах болон багшийн багшлах явцын анхааралыг эзэмшүүлэх зохистой болгох;

[1] Монгол Улсын Боловсролын тухай хууль

[2] Монгол Улсын Бага, дунд боловсролын тухай хууль

[3] Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2019 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн
А/494 дугаар тушаалын хавсралт

## СУУРЬ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН САЙЖРУУЛСАН ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Боловсролын тухай хуульд "Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино"[4] гэж, Бага, дунд боловсролын тухай хуульд "Бага, дунд боловсролын зорилго нь суралцагчдад ерөнхий боловсрол эзэмшүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх, хүмүүнлэг ёсонд суралцах, авьяас чадварыг хөгжүүлэх, амьдрал, хөдөлмөрт болон тасралтгүй суралцахад өөрийгөө бэлтгэхэд нь туслахад оршино"[5] гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолоор 2015 онд баталсан "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-ын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтад "Суурь боловсролыг амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадварыг эзэмшүүлэх үе хэмээн хөгжүүлнэ", 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалтад "Сургалтын ажиллагааны олон улсын чанарын үнэлгээний судалгаанд 2021 онд хамрагдана." хэмээн тус тус тодорхойлсон.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллагаас 2015 онд Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилтын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчеон хотод зохион байгуулсан "Хүн бүрт хүртээмжтэй, тэгш, насан туршдаа суралцах чанартай боловсрол" сэдэвт Дэлхийн боловсролын форумаас Инчеоны тунхаглалыг гаргасан. Тус тунхаглалд 2030 он хүртэлх Дэлхийн боловсролын алсын харааг "Нэгдсэн зорилго, хүсэл эрмэлзэлтэй, хүн бүрт хүрсэн боловсролын хөтөлбөрийг боловсруулна" хэмээн тодорхойлсон. Мөн "Чанартай боловсрол нь бүтээлч болон мэдлэгийг дамжин хөгжүүлж, бичиг үсэг, математикт суралцахтай нягт уялдан шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, танин мэдэхүйн, хувь хүний хөгжил, харилцааны чадваруудыг хөгжүүлдэг"-ийг онцлон тэмдэглэжээ.

Дэлхийн улс орнууд боловсролын бодлогоо шинжлэх ухаан, технологийн хөгжил, дэвшил, нээлттэй нийгэм, иргэдийн зохицон амьдрах чадвартай иргэнийг бэлтгэхэд чиглүүлж буй өнөө үед монгол хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, хамтран ажиллаж амьдрах, шийдвэр гаргах чадвартай, үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг иргэн болж хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байна.

---

[4] Монгол Улсын Боловсролын тухай хууль

[5] Монгол Улсын Бага, дунд боловсролын тухай хууль

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2019 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн
А/492 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН САЙЖРУУЛСАН ХӨТӨЛБӨР**
**НЭГ. МОНГОЛ ХЭЛ**

**Нэг. Зорилго, зорилт**

**1.1. Зорилго**

Аман ба бичгийн хэлний хэм хэмжээг судлан эзэмшиж, харилцааны соёл, хэлний мэдрэмж, авьяас болон оюун санаа, сэтгэлгээгээ хөгжүүлэн, үндэсний хэл, бичиг, өв соёл, оюуны үнэт зүйлсийг эрхэмлэдэг монгол иргэн болж төлөвшинө.

**1.2. Зорилт**

А. Сурагч дараах мэдлэг эзэмшинэ

- Өгүүлбэрийн гишүүд ба үгсийн аймаг, гишүүдийн бүтэц, хэлбэржилт, байр, үүрэг;
- Нийлмэл өгүүлбэр, тэдгээрийн холбох хэрэглүүр(гадаад ба дотоод холбоос);
- Орон, цаг, зорилго, шалтгааны утгатай бүтээвэр, холбох үг, өгүүлбэр;
- Үг, өгүүлбэр, цогцолборыг холбох задлах ба нийлэх арга;
- Уран илтгэх зүйл;
- Аман ба бичгийн найруулгын зарчим, байдал, өнгө аяс;
- Өвөрмөц, хэвшмэл хэлц;
- Уран дүрслэл, яруу хэрэглүүр;
- Толь бичгийн зохиомжлолт, төрөл, бүтэц, ашиглах арга;
- Түүхэн ба хуучин үг хэллэг, түүхэн бүтээвэр;
- Хүндэтгэлийн үг хэллэг;
- Монгол бичгийн залгах ёс;
- Зохиолын санаа, утга, хам сэдэв;
- Үлгэр, туульс, жүжгийн зохиолын шүтэлцсэн ба урсамжилсан үгийн холбоо, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсэг;
- Уран зохиолын хэл, найруулгын онцлог.

Б. Сурагч дараах чадвар эзэмшинэ

- Бичгийн найруулгын төрөл, тэдгээрийн бүтэц, агуулга, санаа, хэл найруулгад дүгнэлт гаргах;
- Эхийн агуулгыг шинжлэх арга барилаа ашиглан бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээгээ хөгжүүлэх;
- Зохиолын агуулга, утга санааг ойлгох, зохиол дахь түүх, нийгэм, соёлын хам сэдвийг тусган эргэцүүлэх;
- Зохиолын төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсгийн холбоо хамаарлыг шинжлэх;
- Зохиолын хэлний онцлогийг тайлбарлах;
- Монгол бичгээр зөв, хурдан, уран тод унших;
- Ярианы соёл, байдал, өнгө аясыг тодорхойлох, дүгнэлт гаргах.

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 12 өдөр Дугаар А/499 Улаанбаатар хот

Ерөнхий боловсролын сургалтад
цахим журнал хөтлөх талаар авах
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолоор баталсан "Цахим засаглал үндэсний хөтөлбөр"-ийн 4.1.9, 5.1.6, 5.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн журналыг цахим хэлбэрээр хөтлөх ажлыг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар нэвтрүүлэх ажлыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/-т даалгасугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Мэдээллийн технологи, статистикийн хэлтэс /Ю.Дуламжамц/-т үүрэг болгосугай:

2.1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/460 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн I-II ангийн багшийн журналын загвар, III-XII ангийн журналын загвар, анги удирдсан багшийн дэвтрийн загвар"-ын дагуу журналыг цахим хэлбэрээр хөтлөх програм хангамжийг хөгжүүлэх, интернэт, мэдээллийн технологийн дэд бүтцийн техникийн бэлэн байдлыг хангах, мэдээллийн аюулгүй байдал, тэдгээрийн хэвийн, тасралтгүй, тогтвортой ажиллагааг хангаж ажиллах;

2.2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтад цахим журнал хөтлөх, хадгалахтай холбогдох харилцааг зохицуулсан журмын төслийг Ерөнхий боловсролын бодлогын газартай хамтран 2019 оны 4 дүгээр улиралд багтаан боловсруулж, батлуулах;

2.3. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн журналыг цахимаар хөтлөх гарын авлагыг сайжруулан боловсруулж, 2019 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн дотор аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газарт цахим хэлбэрээр тус тус хүргүүлэх.

3. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын санал, үндэслэн интернэт, мэдээллийн технологийн дэд бүтцийн техникийн нөхцөл бүрэн бүрдсэн сургуульд цахим журналыг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэх хуваарь баталж, сургуулийн удирдлага, багш нарыг арга зүйн удирдамжаар хангах арга хэмжээ авах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт даалгасугай.

4. Цахим журналыг боловсролын салбарын удирдлагын мэдээллийн систем болон сургуулийн удирдлагын мэдээллийн системээр хөтлөх, хэвлэмэл журналыг

давхардуулан хэтрэхгүй байх арга хэмжээ авахыг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

5. Ерөнхий боловсролын сургуулийн интернэт, мэдээллийн технологийн дэд бүтцийн техникийн нөхцөлийг судалж, сайжруулах санал боловсруулахыг Мэдээллийн технологи, статистикийн хэлтэс /О.Дунжинжамбал/-т, холбогдох дэд бүтцийг сайжруулахад гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Нансалмаа/-т тус тус үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /З.Энхболд/-т даалгасугай.

САЙД



Е.БААТАРБИЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 14 өдөр Дугаар А/504 Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 28.1.2, 28.1.8, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Боловсролын хүрээлэнгийн 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 124 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Хөтөлбөр батлах тухай" А/492 дугаар тушаалын 4 дэх заалтын "Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр батлах тухай" 2016 оны А/277 дугаар тушаал" гэснийг "Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр батлах тухай" 2016 оны А/277 дугаар тушаалын арав дугаар хавсралтаас бусад" гэж өөрчилсүгэй.

САЙД Е.БААТАРБИЛЭГ

С301610

# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 15 өдөр | Дугаар [illegible] | Улаанбаатар хот

**Гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цэцэрлэгийн хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар"-ыг нэгдүгээр, "Ерөнхий боловсролын сургууль суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар"-ыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Гэрээний хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Ж.Мягмар/, Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нямочир/-т, энэхүү үлгэрчилсэн гэрээний загварт нийцүүлэн өөрийн цэцэрлэг, сургуулийн онцлог, зохион байгуулалтаас хамаарч 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн гэрээ байгуулж ажиллахыг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, дүгнэлтийг 2020 оны 6 дугаар сард багтаан танилцуулахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД Ё.БААТАРБИЛЭГ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2019 оны [illegible] дугаар
сарын [illegible]-ны өдрийн [illegible] дугаар
тушаалын хавсралт

ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН
ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ, ХАРГАЛЗАН
ДЭМЖИГЧТЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ
ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Энэхүү хамтын ажиллагааны гэрээг нэг талаас ……………………цэцэрлэгийг төлөөлж ……………………эрхилтэй ……………………… /цаашид "цэцэрлэг" гэх/ нөгөө талаас хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг төлөөлж ……………………… нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

Гэрээнд оролцогч талууд Монгол Улсын Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн конвенц болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1.Энэхүү гэрээний зорилго нь цэцэрлэгийн орчинд хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхдэдээ тавих анхаарал халамж, хараа хяналт, үлгэр дууриалыг сайжруулж, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр талууд хамтран ажиллахад чиглэнэ.

**Хоёр. Эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг**

2.1.Хүүхдийнхээ нас, хөгжлийн онцлог, зан төлөвийг таньж мэдэж, хүүхдээ ойлгох, дэмжин туслах замаар сургуулийн өмнөх боловсрол эзэмших, авьяас чадвараа хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;

2.2.Хүүхдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарал тавьж, бэртэх, гэмтэх, түлэгдэх, жижиг эд зүйлс залгих, төөрөх зэрэг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, байнгын хараа хяналттай байлгах, аюулгүй байдлыг бүрэн хариуцах;

2.3.Хүүхдээ ухаалаг утас, цахим хэрэгслээр тоглуулахгүй байх, зөв зохистой хэрэглээнд багаас нь сургахад өөрийн биеэр үлгэрлэх, хүүхдэдээ ном уншиж өгөх, тоглох, ярилцах, зураг хамт зурах, гар болон шүдээ тогтмол угаах сургах зэргээр тэдний бүх талын хөгжлийг дэмжих;

2.4.Хүүхдээ хичээлийн болон эрүүл цэврийн хэрэглэл, биеийн тамирын хувцсаар бүрэн хангах;

2.5. Хүүхдээ харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байхад анхаарч, заавал өөрийн биеэр хүргэж өгч, авч байх;

2.6.Хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрийн биеэр хүүхдээ хүргэх, авах боломжгүй тохиолдолд багшид мэдэгдэн, хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг бүрэн хариуцах хүнээр хүргүүлж, авахуулж байх;

2.7.Оршин суугаа газар, гэрийн хаяг, холбоо барих утас өөрчлөгдсөн тохиолдолд багшид даруй мэдэгдэх;

2.8. Эцэг эхийн хурал, зөвлөгөөн, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээнд заавал оролцох;

2.9. Хүүхдээ халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах, эрүүл мэндийг нь сахин хамгаалах;

2.10 Багш, ажилтны нэр хүндийг гутаан доромжилсон үг хэллэг, үйлдлийг санаатай болон санамсаргүй байдлаар гаргахгүй, хүндэтгэлтэй харилцах;

2.11 Багшийн үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлт, гомдлыг баримт нотолгоонд үндэслэн цэцэрлэгийн эрхлэгчид тавих;

2.12 Хүүхдийнхээ суралцаж буй анги танхимын эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, орчин нөхцөлийг сайжруулах засвар үйлчилгээнд зориулан хичээлийн жилд нэг удаа хандив, тусламж, дэмжлэг үзүүлэх.

## Гурав. Цэцэрлэгийн эрх, үүрэг

3.1. Цэцэрлэгийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны (MNS 6558:2015) стандарт"-д нийцүүлэх, аливаа осол гэмтэл, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, байнгын хяналт тавих;

3.2. Цэцэрлэгийн орчинд замын гарантуулэг, тэмдэг тэмдэглэгээ хийх, сэргээн засварлах, ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн цэцэрлэгт нэвтрэх нөхцөлийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран бүрдүүлэх;

3.3. Эрүүл, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн хоол, үндвэгээр үйлчлэх, хоол, хүнсний хордлогот халдвараас бүрэн сэргийлэх;

3.4. Цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг хүүхдийн нас, хүйсийн ялгаатай байдал, хөгжлийн онцлогт тохирсон, хувийн орон зайг бүрдүүлсэн байдлаар байгуулж, цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл, засвар үйлчилгээг тогтмол хийх;

3.5 Багш, ажилтан нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг мэдлэг, боловсрол, хэл, соёл, яс үндэс, ажил эрхлэлт, албан тушаал зэргээр ялгаварлахгүй, адил тэгш хүндэтгэлтэй, соёлтой харилцах, тэдний нэр хүндийг гутаан доромжилсон үг хэллэг, үйлдлийг санаатай болон санамсаргүй байдлаар гаргахгүй байх;

3.6 Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувийн мэдээллийн нууцыг чанд хадгалах;

3.7 Багш, ажилтныг халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулах, шаардлагатай арга хэмжээ авах;

3.8 Багш, ажилтан нь хүүхдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүнлэг харилцах, тэдний хувийн мэдээллийг нийтийн дунд задлах, ялгаварлан гадуурхах, бие махбод, сэтгэл санааны дарамт, шийтгэл үзүүлэхгүй байх, шаардлагатай үед хамаарах байгууллагыг холбогдох байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид үзүүлэх, хариу арга хэмжээ авах;

3.9 Хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон, сургалтын хөтөлбөрт тусгагдсан чадварыг эзэмшүүлэх, тэднийг сургуульд бэлтгэх ажлыг эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран зохион байгуулах;

3.10 Багш, ажилтан нь хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх, тэдний аюулгүй байдлыг хангах, хариуцах;

3.11 Цэцэрлэгийн үйл ажиллагаатай холбогдон гарсан шийдвэр, мэдээллийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд танилцуулах;

3.12 Холбогдох хууль, тогтоомжид заагаагүй төлбөр, хураамж авах, үзвэр үйлчилгээний тасалбарыг тулган борлуулах, ном, сонин, сэтгүүл албадан захиалах ажлыг зохион байгуулахгүй байх;

3.13 Анги танхимын орчин нөхцөлийг сайжруулах засвар үйлчилгээнд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс өгсөн хандив, тусламж, дэмжлэг түүний зарцуулалтыг ил тод, нээлттэй тайлагнах.

**Дөрөв. Бусад**

4.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчинтэйд тооцогдоно.

4.2. Гэрээ нь 20..... оны .... дугаар сарын .....ний өдрөөс 20....... оны ..... дугаар сарын ...-ны өдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

4.3. Гэрээг хичээлийн жилийн эцэст дүгнэж, хичээлийн жилийн эхэнд шинэчлэн байгуулна.

4.4. Гэрээг дүгнэж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй цэцэрлэгийн удирдлага, багш, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар хуульд заасан хариуцлага хүлээнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Хүүхдийн цэцэрлэгийг төлөөлж: | Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг төлөөлж: |
| --- | --- |
| ........................................................ | ........................................................ |

20.. оны ... сарын ...өдөр

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2019 оны [illegible] дугаар
сарын [illegible]-ны өдрийн [illegible] дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
СУРАЛЦАГЧИЙН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ,
ХАРГАЛЗАН ДЭМЖИГЧТЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ
ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

Энэхүү хамтын ажиллагааны гэрээг нэг талаас ................... ерөнхий боловсролын сургуулийг төлөөлж ........................ажиллах ........................... /цаашид "сургууль" гэх/ нөгөө талаас суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг төлөөлж ............. нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

Гэрээнд оролцогч талууд Монгол Улсын Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн конвенц, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/478 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого" болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Энэхүү гэрээний зорилго нь сургуулийн орчинд хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхдэдээ тавих анхаарал халамж, хяналтыг сайжруулж, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр талууд хамтран ажиллахад чиглэнэ.

**Хоёр. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүрэг**

2.1. Хүүхдийнхээ нас, хөгжлийн онцлог, зан төлөвийг таньж мэдэж, хүүхдээ ойлгож, дэмжин туслах замаар боловсрол эзэмших, авьяас чадвараа хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;

2.2. Хүүхдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарал тавьж, хичээлийн бус цагаар болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг бүрэн хариуцах;

2.3. Хүүхдээ сурах бичиг, хичээлийн хэрэглэл, дүрэмт хувцсаар бүрэн хангах, хоцрогдолгүй суралцахад дэмжлэг үзүүлэх, тэдний хичээлд явахын өмнө заавал хооллон цай уулгаж хэвшүүлэх;

2.4. Арав хүртэлх насны хүүхдээ харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байхад анхаарч, гэрэл ойлгогч /давхруулагч туузыг/ цүнхэнд нь байршуулж өгөх;

2.5. Оршин суугаа хаяг, гэрийн хаяг, холбоо барих утас өөрчлөгдсөн тохиолдолд анги удирдсан багшид даруй мэдэгдэх;

2.6. Хүүхдээ суралцах боломжоор хангах, хичээл, сургалтаас хоцорч/хоцроохгүй, тасалдуулахгүй байх, хүндэтгэх шалтгаантай тохиолдолд анги удирдсан багшид заавал мэдэгдэх;

2.7. Эцэг эхийн хурал, зөвлөгөөн, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр сургуулиас зохион байгуулсан арга хэмжээнд /тухайлбал, school police/ заавал оролцох;

2.8. Хүүхдээ аливаа халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах, эрүүл мэндийг нь сахин хамгаалах;

2.9. Хичээлийн цагаар гар утас, цахим сүлжээг багшийн зөвшөөрөлгүй ашиглахгүй байх, цахим хэрэгсэл, сүлжээг зөв зохистой хэрэглэх, бусдад хүндэтгэлтэй хандаж соёлтой харилцах талаар хүүхдэдээ зөвлөн туслах, үлгэрлэх;

2.10. Дотуур байранд амьдарч байгаа хүүхэдтэйгээ байнга холбоотой байх, эргэлтээр ирж, дотуур байрны болон анги удирдсан багштай уулзаж, зөвлөгөө авах, мэдээлэл солилцох;

2.11. Дотуур байранд амьдарч байгаа хүүхдэдээ шаардлагатай ахуйн болон ариун цэврийн хэрэглэл, хувцас, хичээлийн хэрэглэлийг хангалттай бэлтгэж өгөх;

2.12. Багш, ажилтны нэр хүндийг гутаан доромжилсон үг хэллэг, үйлдлийг санаатай болон санамсаргүй байдлаар гаргахгүй, хүндэтгэлтэй харилцах;

2.13. Сургууль, багшийн үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлт, гомдлыг баримт нотолгоонд үндэслэн сургуулийн захиргаанд тавих;

2.14. Хүүхдийнхээ суралцаж буй анги танхимын эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, орчин нөхцөлийг сайжруулах засвар үйлчилгээнд зориулан хичээлийн жилд нэг удаа хандив, тусламж, дэмжлэг үзүүлэх.

## Гурав. Ерөнхий боловсролын сургуулийн эрх, үүрэг

3.1. Сургууль, дотуур байрны гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг стандарт шаардлагад нийцүүлэх, аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, байнгын хяналт тавих;

3.2. Сургууль, дотуур байрны орчинд замын гэрэлтүүлэг, тэмдэг тэмдэглэгээ хийх, сэргээн засварлах, суралцагч замын хөдөлгөөнд аюулгүй оролцох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч сургуульд нэвтрэх нөхцөлийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран бүрдүүлэх;

3.3. Хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй хоол, хүнсний бүтээгдэхүүнийг сургууль дээр худалдаалахгүй, цайны газар нь эрүүл, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн хоол, ундаагаар үйлчлэх, хоол, хүнсний хордлогот халдвараас бүрэн сэргийлэх;

3.4. Сургууль, дотуур байрны ариун цэврийн байгууламжийг хүүхдийн нас, хүйсийн ялгаатай байдал, хөгжлийн онцлогт тохирсон, хувийн орон зайг бүрдүүлсэн байхаар байгуулж, цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл, засвар үйлчилгээг тогтмол хийх;

3.5. Багш, ажилтан нь суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг мэдлэг, боловсрол, хэл, соёл, яс үндэс, ажил эрхлэлт, албан тушаал, амьжиргааны түвшин зэргээр ялгаварлахгүй, адил тэгш хүндэтгэлтэй, соёлтой харилцах;

3.6. Хүүхэд хоорондын харилцааны зөрөг орчин бүрдүүлж, хүүхдийг дээрэлхэх, дарамтлах, бие махбодын шийтгэл үзүүлэх асуудлыг гаргахгүй байх;

3.7. Суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувийн мэдээллийн нууцыг чанд хадгалах;

3.8. Сургуулийн орчинд 19 цагаас хойш суралцагчдыг хамарсан аливаа үйл ажиллагаа зохион байгуулахгүй байх;

3.9. Суралцагчийг гэмт хэрэг, хүчирхийлэл, хорт зуршил, болзошгүй осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах сургалт, сурталчилгааг улиралд 1-2 удаа мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

3.10. Багш нь суралцагчийг гэмт хэрэг, хүчирхийлэл, хорт зуршил, авто замын болон болзошгүй эрсдэл, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх анхааруулга, санамж тогтмол өгөх;

3.11. Багш, ажилтныг халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, шаардлагатай арга хэмжээ авах;

3.12. Багш, ажилтан нь суралцагчийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч хүнлэг харилцах, суралцагчийн хувийн мэдээллийг нийтийн дунд задлах, ялгаварлан гадуурхах, бие махбод, сэтгэл санааны дарамт, шийтгэл үзүүлэхгүй байх, шаардлагатай үед камерын бичлэгийг холбогдох байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид үзүүлэх, хариу арга хэмжээ авах;

3.13. Анги удирдсан багш нь хичээл заадаг багш нартай байнгын холбоотой ажиллаж, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй суралцагчийн сурлага, хөгжил, төлөвшлийн талаар мэдээлэл солилцох, зөвлөгөө өгөх ажлыг сард 1 удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр зохион байгуулах;

3.14. Анги удирдсан багш 10 хүртэлх насны суралцагчийг хичээлд ирэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс хүлээн авч, хичээлийн дараа хүлээлгэн өгөх;

3.15. Хичээл заадаг багш нь суралцагч хичээлдээ ирээгүй тохиолдолд анги удирдсан багшид, анги удирдсан багш нь эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид заавал мэдэгдэх;

3.16. Сурлагын хоцрогдлыг арилгах ажлыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран зохион байгуулах;

3.17. Суралцагчдын дунд аливаа сургалт, уралдаан тэмцээн, үзвэр үйлчилгээг зохион байгуулж буй багш, ажилтан нь суралцагчийг хараа хяналтгүй орхихгүй байх, тэдний аюулгүй байдлыг хангах, хариуцах;

3.18. Сургуулийн үйл ажиллагаатай холбогдон гарсан шийдвэр, мэдээллийг багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд танилцуулах;

3.19. Холбогдох хууль, тогтоомжид заагаагүй төлбөр, хураамж авах, үзвэр үйлчилгээний тасалбар тулган борлуулах, ном, сонин, сэтгүүл албадан захиалах ажлыг зохион байгуулахгүй байх;

3.20. Анги танхимын орчин нөхцөлийг сайжруулах засвар үйлчилгээнд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс өгсөн хандив, тусламж, дэмжлэг түүний зарцуулалтыг ил тод, нээлттэй тайлагнах.

**Дөрөв. Бусад**

4.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчинтэйд тооцогдоно.

4.2. Гэрээ нь 20..... оны .... дугаар сарын .....ны өдрөөс 20 .... оны ..... дугаар сарын ...-ны өдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

4.3. Гэрээг хичээлийн жилийн эцэст дүгнэж, хичээлийн жилийн эхэнд шинэчлэн байгуулна.

4.4. Гэрээг дүгнэж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй сургууль, багш, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар хуульд заасан хариуцлага хүлээнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Ерөнхий боловсролын сургуулийг төлөөлж: | Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг төлөөлж: |
|---|---|
| ............................................................ | ............................................................ |

20.. оны ... сарын ...өдөр

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 15 өдөр | Дугаар [illegible] | Улаанбаатар хот

Хуулийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, "Сургалт зохион байгуулах, зардал батлах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/419 дүгээр тушаал, "Хөтөлбөр батлах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/492 дугаар тушаалын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг 2019-2020 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхлэхтэй холбогдуулан орон нутагт 2019 оны 8 дугаар сарын 15-30-ны өдрүүдэд зохион байгуулагдах сургалтад ээлжийн амралтын хугацаанд хамрагдах багш, удирдах ажилтанд 2019-2020 оны хичээлийн жилд багтаан амралтыг нь нөхөн эдлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт даалгасугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт үүрэг болгосугай.

САЙД Ё.БААТАРБИЛЭГ

БАТЛАВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД

Е.БААТАРБИЛЭГ

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН
**2019-2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

Бүх шатны сургалтын байгууллагын багш бүр хичээл, сургалтын бэлтгэлийг чанартай хангах, үр дүнтэй хэрэгжүүлэх, багш, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх, суралцагчийн хөгжил, төлөвшилд ахиц гаргах зорилго дэвшүүлж байна. Энэхүү зорилгыг хангах чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

1. Хичээл, сургалтын үйл ажиллагаанд заах аргын нэгдэл, багаар хамтран чанартай бэлтгэх, ээлжит хичээлийг хүүхдийн хэгаатай байдал, хэрэгцээ, сонирхлыг харгалзан, адил тэгш оролцоог хангах үр өгөөжтэй удирдан зохион байгуулах чиглэлээр багшийн заах арга, ур чадварыг хөгжүүлэх;

2. Суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадварын явц, үр дүнд тогтмол шинжилгээ хийж, сургалтын хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмшүүлэхэд сургалтын төлөвлөгөөн дэх "Багш зохицуулах цаг"-ийг үр өгөөжтэй ашиглан агуулгын хоцрогдолгүй сургах;

3. Багш ажлын байранд мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх соёл төлөвшүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх;

4. Сургалтын менежер, арга зүйчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө багшид өгөх, тэдний хамтын ажиллагааг дэмжих, хичээлийн явц, үр дүнд судалгаа, шинжилгээ хийх, ёс зүй, харилцаа, хандлагаар манлайлан мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн чиг үүргээ бүтээлчээр хэрэгжүүлэх;

5. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн насны бүх хүүхдийг хөгжлийн онцлог, хэл соёл, оршин суугаа газар, амьжиргааны түвшнээс үл хамааран боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургах ажлыг үр дүнтэй зохион байгуулах;

6. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд тогтмол хамрагдах чадахгүй байгаа хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжүүлэх сургуульд бэлтгэх ажлыг эцэг, эх, асран хамгаалагч, нутгийн засаг захиргааны байгууллагын оролцоонд суурилан үр дүнтэй зохион байгуулах;

7. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг нэвтрүүлэх, сурах бичгээр бүрэн хангах;

8. Сургалтын байгууллагын үнэлгээг баримт нотолгоонд тулгуурлан хийж, цаашдын үйл ажиллагааны зорилго, төлөвлөлтийг хамтын оролцоотой тодорхойлох соёлыг төлөвшүүлэх;

9. Сургалтын байгууллагын орчныг аюулгүй байдлын стандарт, шаардлагад нийцүүлэх, аливаа болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, байнгын хяналт тавих;

10. Хүүхдийн сурлага, хүмүүжил, хөгжил, хамгааллын асуудлаар эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах гэрээ байгуулж, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх;

11. Албан бус, насан туршийн боловсролын үйлчилгээний хүрээ, арга хэлбэрийг бүх насны хүн амын хэрэгцээнд нийцсэн байдлаар өргөжүүлэх.

---ooo---

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 22 өдөр | Дугаар A/374 | Улаанбаатар хот

Чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэл"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаалаар батлагдсан чиглэлийг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтийг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нэм-Очир/, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Энхболд/-т тус тус даалгасугай.

САЙД Ё.БААТАРБИЛЭГ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2019 оны … дугаар
... сарын …-ний өдрийн … дугаар
тушаалын хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Ерөнхий боловсролын сургууль /цаашид "сургууль" гэх/-д хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлыг төлөвлөх, зохион байгуулахад энэхүү чиглэлийг баримтална.

1.2. Чиглэл нь сургуулийн зорилго тодорхойлох, хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлыг зохион байгуулах, үнэлэх, багшийн мэргэжлийн хөгжлийг хангах, сургалтын эрүүл, аюулгүй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх асуудлыг хамарна.

1.3. Энэхүү чиглэлийг хэрэгжүүлэхэд суралцагчийн хөгжих, эсэн мэнд амьдрах, хамгаалагдах, оролцох эрхийг хүндэтгэх, суралцах адил тэгш боломж олгох, хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлыг суралцагчийн ялгаатай байдал болон орон нутгийн онцлог, хэрэгцээг харгалзан уян хатан арга хэлбэрээр талуудын оролцоог тэгш хангаж зохион байгуулах зарчим баримтална.

1.4. Сургууль хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлын нэгдсэн төлөвлөгөөтэй байна.

**Хоёр. Сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэл**

***2.1. Сургуулийн зорилго тодорхойлох, үнэлэх***

2.1.1. Сургуулийн үйл ажиллагааг хичээлийн жилээр төлөвлөх бөгөөд энэ нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах тасралтгүй үйл явц байхаар зохион байгуулах;

2.1.2. Сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлтийг тухайн хичээлийн жилд дэвшүүлэх зорилго тодорхойлохоос эхлэх;

2.1.3. Сургуулийн зорилгыг тодорхойлоход сургуулийн менежментийг сайжруулах цикл (төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, сайжруулалт)-д тулгуурлах;

2.1.4. Сургуулийн зорилго нь боловсролын бодлогыг хэрэгжүүлэхийн тулд тухайн хичээлийн жилд суралцагчийн хөгжлийг дэмжих талаар юу хийх, ямар үр дүнд хүрэхийг тодорхойлох бөгөөд энэ нь сургуулийн үнэт зүйлс, онцлогт нийцсэн, тодорхой, хэрэгжихүйц байх;

2.1.5. Сургуулийн зорилгыг суралцагчийн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшилд ахиц гаргах суурь асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлэх;

2.1.6. Сургуулийн зорилгыг тодорхойлоход сургуулийн бодит байдлыг судалгаа, баримт нотолгоонд суурилан хамтын оролцоотой хэлэлцэж шийдвэрлэх;

2.1.7. Сургуулийн зорилгын биелэлтийг хичээлийн жилийн эцэст үнэлж, хэлэлцсэний үндсэн дээр дараагийн хичээлийн жилийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөлтийн үндэслэл болгох.

## *2.2. Хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлыг зохион байгуулах*

2.2.1. Тухайн хичээлийн жилд дэвшүүлсэн сургуулийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаагаар хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлаар зохион байгуулах;

2.2.2. Хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлыг зохион байгуулахад хичээлийн жилийн бүтэц, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр болон холбогдох норм, нормативыг удирдлага болгох;

2.2.3. Хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд суралцагчийг нийт 7 долоо хоног амраах, зуны амралтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хугацаанд эхлүүлэхээр тооцож төлөвлөх;

2.2.4. Хичээлийн хуваарийг хичээлийн жилийн бүтэц, сургалтын төлөвлөгөөнд үндэслэн зохиох бөгөөд хүүхдийн анхаарал төвлөрч сэтгэн бодох үйл ажиллагаа шаардах хичээлийн өмнө биеийн тамир, хөгжим, дизайн-технологи зэрэг хичээлийг хуваарилахгүйгээр зохиох;

2.2.5. Дунд, ахлах ангийн суралцагчийн хөгжил, тухайн хичээлийн агуулга, зохион байгуулалтын онцлогоос хамаарч зарим хичээлийн үргэлжлэх хугацаа 80 минутаас хэтрэхгүй байхаар тогтоох;

2.2.6. Ахлах ангийн сонгон судлах хичээлийн анги дүүргэлт тогтоосон нормативт хүрэхгүй тохиолдолд сургууль дундын бүлэг үүсгэж зохион байгуулах;

2.2.7. Хос хэлний болон төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эсхүл боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагаас баталсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

2.2.8. Сургалтын төлөвлөгөөгөөр батлагдсан хичээлд ногдох цагийг хорогдуулах, бусад хичээлд шилжүүлэх эсхүл хичээл шинээр үүсгэж өөрчлөхгүйгээр хэрэгжүүлэх;

2.2.9. Хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлаар XXI зууны иргэнд шаардагдах бүтээлч сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх, бусадтай хамтран ажиллах, харилцах, асуудалд шүүмжлэлтэй хандах, технологи ашиглах, шинэ орчин, нөхцөлд дасан зохицох зэрэг ур чадвар эзэмшүүлэхэд сургалтын үйл ажиллагааг чиглүүлэх;

2.2.10. Суралцагчийг аюулгүй амьдрах арга ухаанд сургах, эзэмшсэн мэдлэг, чадвараа практикт хэрэглэх чадамжтай болгох, STEM (шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик сэтгэлгээг хөгжүүлэх) боловсрол олгох, лего робот болон бусад зохион бүтээх хэрэгсэл, тоноглол дээр ажиллуулах зэргээр суралцагчдад шинжлэн судлах арга барил эзэмшүүлэх, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлаар хэрэгжүүлэх;

2.2.11. Сургалтын төлөвлөгөөн дэх "Багш зохицуулах цаг"-ийн хэрэгжилтэд заах арлын ногдол, сургалтын менежер хяналт тавих, багшийн хичээл заах үндсэн цагт тооцох;

2.2.12. "Багш зохицуулах цаг"-ийг нэг төрлийн хичээлд багцаар нь зарцуулахгүй, сургалтын төлөвлөгөөнд заасны дагуу хэрэгжүүлэх;

2.2.13. Дугуйлан, секц, хөгжүүлэх үйл ажиллагааг сургуулийн онцлог, давуу талд түшиглэх, шаардлагатай тохиолдолд бусад сургуультай хамтран зохион байгуулах.

**2.3. *Хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, суралцагчийн сурах үйл явцыг дэмжих***

2.3.1. Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаар суралцагчийн суурь мэдлэг, чадвар, хандлага, хэрэгцээ, сонирхлыг харгалзан, адил тэгш оролцоог хангасан байхаар төлөвлөх, хичээлийн бэлтгэлийг чанартай хангаж үр дүнтэй зохион байгуулах;

2.3.2. Хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөхөд заах аргын нэгдэл, тэнхим, багаар хамтран хэлэлцэх, хичээл хоорондын агуулгын залгамж холбоог хангаж хэрэгжүүлэх, явцын болон үр дүнгийн үнэлгээнд шинжилгээ хийж ажиллах;

2.3.3. Суралцагчийн буруу тогтсон ойлголт, төсөөллийг урьдчилан тооцож хичээл төлөвлөлтөд тусгах;

2.3.4. Сургалтын материал, нөөц хэрэглэгдэхүүнийг хамтран бэлтгэх, сонгох, орон нутгийн материал, жишээ, баримтыг түлхүү ашиглан хичээлийг амьдрал, практик хэрэглээтэй холбох;

2.3.5. Суралцах бэрхшээлтэй суралцагчид нэмэлт туслалцаа үзүүлэх, тэдний онцлогт тохирсон үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлэх, ахиц, өөрчлөлтийг үнэлэх;

2.3.6. Сургуулийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг нэгдмэл байдлаар үнэлэх өөрийн үнэлгээний агуулга, арга хэлбэр, хугацааг тогтоон мөрдөх;

2.3.7. Сургуулийн хэмжээнд тааруу үнэлгээтэй шалгагдсан сэдэв, агуулгыг илрүүлэн, шалтгааныг тодруулах, тухайн агуулгыг суралцагчдад бүрэн эзэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг сургууль, заах аргын нэгдэл, тэнхим, багаар хамтран төлөвлөж хэрэгжүүлэх;

2.3.8. Суралцагчид өгөх гэрийн даалгаврын талаар баримтлах сургуулийн бодлого/удирдамж/-ыг боловсруулж, хэлэлцэн батлан мөрдөх;

2.3.9. Энэхүү чиглэлийн 2.3.8-д заасан бодлого/удирдамж/-д гэрийн даалгаврын агуулга, хэмжээ, гэрийн даалгавар гүйцэтгэхэд өдөрт зарцуулах хугацаа /ангиар/-г тооцох, даалгаврын гүйцэтгэл, үр дүнг хэлэлцэж, хариу мэдээлэл, зөвлөмж өгөх, заавал унших номын жагсаалт, улирлын болон зуны амралтаар академик агуулга бүхий гэрийн даалгавар өгөхөөс татгалзах зэрэг асуудлыг тусган хэрэгжүүлэх;

2.3.10. Орон нутгаа судлах, түүх, соёл, ёс заншил, уламжлалаа таниж мэдэхэд чиглэсэн аялал, экскурсийг хичээлийн жилд 2-оос доошгүй удаа анги хамт олноор зохион байгуулах;

2.3.11. Багш өдөр тутмын хичээл, сургалтын үйл ажиллагаа болон суралцагчийн ирц, сурлагын амжилтын үнэлгээ, тэдний хувийн мэдээлэл, хөгжил төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг багшийн журнал, анги удирдсан багшийн дэвтэрт зааврын дагуу тухай бүр тэмдэглэх;

2.3.12. Энэ чиглэлийн 2.2.2-д заасан эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хянах, үр дүнг тооцохдоо хичээлийн баталгаажуулсан хуваарь, багшийн хичээл, үйл ажиллагааны төлөвлөлт, журнал, анги удирдсан багшийн дэвтэрийг албан ёсны баримт болгох.

***2.4. Хичээл, сургалтын хэвийн ажиллагаа, суралцагчийн сурч боловсрох эрхийг хангах***

2.4.1. Эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, онцгой дэглэмээс бусад тохиолдолд хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоох, тасалдуулах, багшийн үндсэн чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтод үл хамаарах ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхгүй байх;

2.4.2.Ээлжит хичээлийн явцад анги, танхимаас багшийг дуудах, хичээлийн цагаар багш, суралцагчийг хамаарсан ажил зохион байгуулах, хичээлийн дундуур анги, танхимын нөхцөл байдал, багшийн үйл ажиллагаатай танилцах, судалгаа авах болон бусад шалтгаанаар хичээл, сургалтын үйл ажиллагааг саатуулах, тасалдуулахгүй байхаар сургуулийн үйл ажиллагааг зохион байгуулах;

2.4.3. Суралцагчдад хүндрэл бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх, хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлыг тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үр дүнтэй зохион байгуулах;

2.4.4. Нэгдүгээр ангид тухайн онд 6 нас хүрэх хүүхдийг элсэлтийн шалгалт, сорил авахгүйгээр элсүүлэх;

2.4.5. Шинээр элсэн суралцах буй хүүхдийг сургуулийн орчин, суралцах үйл ажиллагаанд дасан зохицоход нутгийн захиргааны байгууллага, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран дэмжлэг үзүүлэх;

2.4.6. Суралцагч бага боловсролоос суурь боловсролд шилжин суралцахад үүсэх хүндрэл, бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх;

2.4.7. Бага ангийн суралцагчдын дунд тэдний хувийн амжилтаар ялгаа үүсгэн эрэмбэлэх зорилго бүхий аливаа уралдаан, тэмцээн, олимпиад зохион байгуулахыг хориглох;

2.4.8. Сургалтын төлбөр барьцаалан хүүхдийн суралцах эрхэд халдахгүй байх, шилжин суралцах тохиолдолд хувийн хэргийг аливаа саадгүйгээр хүлээлгэн өгөх, боловсролын салбарын мэдээллийн систем дэх бүртгэлээс хасалт хийх.

**Гурав. Багшийн мэргэжлийн хөгжлийг**
**хангахад баримтлах чиглэл**

3.1. Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 7.1-д заасны дагуу багшийн хөгжлийн төвийг үр дүнтэй ажиллуулах, багшийн мэдлэг, боловсрол, ур чадварыг ажлын байранд нь тасралтгүй дээшлүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох;

3.2. Багшийг ажлын байранд нь мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх төлөвлөгөөг багш нарын оролцоотой боловсруулах, хэрэгжүүлэх бөгөөд энэхүү төлөвлөгөөнд үндэслэн багш бүр Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 10.1-д заасан төлөвлөгөө боловсруулан ажиллах;

3.3. Багш нарын мэргэжил, ур чадварыг хөгжүүлэх ажлын хүрээнд сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, агуулга тэдгээрийн залгамж холбоог сайтар судлуулах;

3.4. Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх талаар багш нар харилцан туршлага солилцох уулзалт, сургалтыг үр дүнтэй зохион байгуулах, багш бүр хичээлийн судалгаа тогтмол хийх, хичээлийн чанар, өгөөжийг нэмэгдүүлэхэд ажлын байран дахь мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг чиглүүлэх;

3.5. Сургалтын менежер нь заах аргын нэгдэл, танхим, багшийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, хамтын ажиллагаагаар дэмжих, суралцагч төвтэй сургалтын арга зүйг багш нарт сайтар эзэмшүүлэх, хичээлийн явц, үр дүнд судалгаа, шинжилгээ хийх, суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх даалгаврын сан бүрдүүлэх, суралцагчийн сурах үйл ажиллагааг дэмжих ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах чиглэлээр үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлэх;

3.6. Заах аргын нэгдэл, багш нарын багийн ажлыг хичээл төлөвлөх, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, даалгаврын сан бүрдүүлэх, хичээлийн ажиглалт, судалгаа хийх, үнэлгээний үр дүнд шинжилгээ хийх, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, онол, арга зүйн мэдлэгээ дээшлүүлэх, XXI зууны иргэнд шаардагдах ур чадварыг хэрхэн хичээл, сургалтаар эзэмшүүлэхэд чиглүүлэх;

3.7. Багшийн мэдээллийн технологийн боловсрол, сургалтад технологи ашиглах ур чадварыг дээшлүүлэх, багш хөгжлийн танхимын орчин нөхцөлийг сайжруулах, байнгын ажиллагаагаар хангах.

**Дөрөв. Сургалтын орчны эрүүл, аюулгүй байдлыг сайжруулахад баримтлах чиглэл**

4.1. Хичээл, сургалтын үйл ажиллагааг эрүүл, аюулгүй байдал хангасан анги, танхим, лабораторит зохион байгуулах;

4.2. "Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал" ерөнхий шаардлага, "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль түүний дотуур байрын орчны эрүүл ахуйн шаардлага", Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын орчин, үйлчилгээ" ерөнхий шаардлагын хэрэгжилтэд үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээ авах;

4.3. Энэхүү чиглэлийн 4.2-д заасан арга хэмжээг нутгийн захиргаа, сургууль, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоог хангах;

4.4. Сургалтын орчны аюулгүй байдалд тодорхой давтамжтай үзлэг, шалгалт хийхээр төлөвлөх, хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авах;

4.5. Сургалтын үйл ажиллагаанд мэдээллийн технологи ашиглах, сургалтын материал, хэрэглэгдэхүүний цахим сан, бусад програм хангамж ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, тэдгээрийн эрүүл, аюулгүй байдлыг хангах;

4.6. Сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бодис урвалж, хэрэглэгдэхүүний хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах;

4.7. Сургалтын ажлын явцад хийгдэх лаборатори, дадлага ажил, семинар, аялал, туршилт хийх явцад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх;

4.8. Сургуулийн номын сангаар дамжуулан төрөөс хангах сурах бичгийг зорилтот бүлгийн суралцагчдад багцаар нь хэрэглүүлэх;

4.9. Сургуулийн номын сангаар дамжуулан сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг журмын дагуу зохион байгуулах;

4.10. Сургуульд сэтгэл зүйн таатай орчин, эерэг уур амьсгал бүрдүүлэх, харилцааны зөв дадал хэвшил төлөвшүүлэхэд удирдлага, багш ажилтны үлгэр дуурайлал, манлайллыг эрхэмлэх.

—ooo—

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 18 өдөр — Дугаар А/659 — Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.13 дахь зорилтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд секц, дугуйлан хичээл байгуулах, санхүүжүүлэх аргачлал"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Аргачлалын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нямочир/, Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Нансалмаа/-т тус тус даалгасугай.

3. Аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

4. Аргачлалын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг жил тутам хийж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Энхболд/-т даалгасугай.

САЙД Б.БААТАРБИЛЭГ

0613 0[illegible]057

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/... дугаар тушаалын хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СЕКЦ, ДУГУЙЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ АРГАЧЛАЛ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль /цаашид "сургууль" гэх/-д секц, дугуйлан хичээллүүлэх, түүнийг санхүүжүүлэхэд энэхүү аргачлалыг баримтална.

1.2. Секц, дугуйлан нь суралцагчийн чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх, хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвараа бататгах, хөгжүүлэх, тэдний хэрэгцээ сонирхлыг дэмжих авьяасыг хөгжүүлэхэд чиглэнэ.

1.3. Сургууль нь секц, дугуйланг суралцагчийн сонирхол, хэрэгцээ, багшийн ур чадвар, хүний нөөц, орон нутгийн онцлогийг харгалзаж, нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагыг түшиглэн эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоотой зохион байгуулна.

1.4. Секц, дугуйлангийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн, үр дүнд суурилсан, тэгш хамрагдах боломж олгосон, олон хувилбартай, нээлттэй, хяналттай байх зарчим баримтална.

1.5. Секц, дугуйланг төлбөргүй болон төлбөртэйгээр зохион байгуулна.

1.5.1. Төлбөртэй хичээллэх секц, дугуйлан гэж эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлтээр мэргэжлийн байгууллага, мэргэшсэн иргэнтэй гэрээний үндсэн дээр төлбөр, хураамж авч хамтран зохион байгуулж буй секц, дугуйланг ойлгоно.

1.6. Урлаг, спорт, технологийн тусгай ур чадвар, нөөц шаардагдах секц, дугуйланг мэргэжлийн байгууллага, мэргэшсэн иргэнтэй хамтран зохион байгуулж болно.

1.6.1. Тусгай ур чадвар, нөөц шаардагдах секц, дугуйлан гэж урлаг, спорт, технологийн тодорхой чиглэлээр нарийн мэргэжил эзэмшсэн, спортын өндөр зэрэгтэй, урлаг, уран техник, зохион бүтээх чиглэлээр авьяас, ур чадвартай хүүхдийн анги, иргэний дэмжлэгтэйгээр соёлын биет бус өвийг өвлүүлэх, тусгайлсан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, ховор материал, эд зүйлс ашиглах секц, дугуйланг ойлгоно.

1.6.2. Тусгай ур чадвар бүхий иргэн нь хүүхэдтэй ажиллах эв дүй, туршлагатай, сэтгэцийн болон халдварт өвчингүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй байна.

**Хоёр. Удирдлага, зохион байгуулалт**

2.1. Тухайн хичээлийн жилд хичээллэх секц, дугуйлангийн нэр төрлийг суралцагч, багш нарын санал, хүсэлтэд үндэслэн санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийг сургуулийн захирал томилон ажиллуулна.

2.1.1. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл орсон байна.

2.1.2. Ажлын хэсэг нь суралцагчдаас асуулга авч, секц, дугуйлангийн нэр төрөл, хамрагдах суралцагчдын тоог тандан төлбөргүй болон төлбөртэй зохион байгуулах секц, дугуйлангийн талаар санал, дүгнэлт гаргаж, багш нарын зөвлөлийн хуралд танилцуулна.

2.1.3. Ажлын хэсгийн санал, дүгнэлт нь суралцагчдаас авсан асуулгын үр дүн, байр танхимын болон хүний нөөцийн боломж, санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан байна.

2.1.4. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг багш нарын зөвлөлийн хурлаар жил бүрийн 5 дугаар сард багтаан хэлэлцэж, дараагийн хичээлийн жилд хичээллэх секц, дугуйлангийн нэр төрөл, долоо хоногт хичээллэх хугацаа, хамрагдах суралцагчийн тооны хязгаарыг тогтооно.

2.2. Төлбөртэй зохион байгуулах секц, дугуйлангийн нэр төрлийг суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлд үндэслэн шийдвэрлэнэ.

2.3. Багш нарын зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийг захирлын тушаалаар баталгаажуулна.

2.4. Төлбөртэй хичээллэх секц, дугуйлангийн орлого, зарлагыг дараа оны төсвийн төсөлд тусгана.

2.5. Секц, дугуйлангийн төлөвлөгөө, хөтөлбөрийг тухайн секц, дугуйлан удирдах багш, мэргэжлийн байгууллага, мэргэшсэн иргэн боловсруулж, сургалтын менежер хянан, сургуулийн захирал баталгаажуулна.

2.6. Секц, дугуйлангийн хөтөлбөр нь суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, суралцагчийн мэдлэг, ур чадварыг шатлан ахиулах агуулгатай байна.

2.8. Секц, дугуйлан хичээллүүлэх багш, мэргэшсэн иргэн нь дараах шаардлагыг хангаж ажиллана.

2.8.1. Секц, дугуйлан хичээллэх анги, танхим, сургалтын хэрэглэгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг бүрэн хангасан байх;

2.8.2. "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм"-ийг баримтлах;

2.8.3. Суралцагчийн эрүүл мэнд, ёс зүйд харшлах үйл ажиллагаа явуулахгүй байх;

2.8.4. Секц, дугуйлангийн үеэр аливаа шашны зан үйл, бусад үйл ажиллагаа сургалт зохион байгуулахгүй байх;

2.8.5. Секц, дугуйлан хичээллэх байх хугацаанд суралцагчийн аюулгүй байдлыг хангаж хариуцах, тэднийг хараа хяналтгүй орхихгүй байх.

2.9. Секц, дугуйланг ганцаарчилсан, анги дагнасан, холимог бүлгийн, сургууль дундын хэлбэрээр зохион байгуулж болно.

2.10. Сургууль дундын хэлбэрээр зохион байгуулах секц, дугуйланг орон нутгийн онцлог, багшийн ур чадвар, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний нөөцийг харгалзан сургуулийн болон мэргэжлийн байгууллагын байр, танхим, спорт, соёлын үйлчилгээний газар, сургалт-туршилтын талбайд хичээллүүлж болно.

2.11. Сургууль дундын хэлбэрээр зохион байгуулах секц, дугуйлангийн үйл ажиллагааг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавьж ажиллана.

2.12. Секц, дугуйлангийн нэр төрөл, удирдаж буй багш, хамрагдаж буй суралцагчийн мэдээллийг сургалтын менежер боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэнэ.

2.13. Секц, дугуйлан удирдаж буй багш, хамрагдаж буй суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч сургуулийн захиргаа гурвалсан гэрээ байгуулж, хамтран ажиллана.

2.14. Секц, дугуйлангийн үйл ажиллагаа цаг хугацаандаа, бэлтгэл, зохион байгуулалт сайтай, чанартай явагдаж, энэхүү аргачлалын 2.8-д заасан шаардлага хангагдаж байгаа эсэхэд эцэг эх, асран хамгаалагч болон сургалтын менежер хяналт тавина.

**Гурав. Санхүүжилт, тайлагнал**

3.1. Секц, дугуйланг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

3.1.1. Улсын болон орон нутгийн төсөв

3.1.2. Сургуулийн үндсэн үйл ажиллагааны орлого;

3.2. Секц, дугуйлан төлбөртэй хичээллүүлэхээс олсон орлогыг дараах зүйлд зарцуулна:

3.2.1. сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, орчин нөхцөлийг сайжруулах;

3.2.2. багшийн ажлын хөлс, урамшуулал;

3.2.3. хичээллэх байр, танхимын зардал;

3.2.4. хувцас хэрэглэл;

3.2.5. аймаг, дүүрэг, хот, улсын чанартай тэмцээн, уралдаанд оролцох зардал.

3.3. Төлбөргүй секц, дугуйланд хамрагдаж буй суралцагчийн сургалтын хэрэгслийг эцэг эх, асран хамгаалагч хариуцна.

3.4. Төлбөргүй зохион байгуулж буй секц, дугуйлангийн үйл ажиллагааг сар бүр үнэлж, удирдсан багшийн илүү цагийн ажлын үр дүнд тооцно.

3.5. Секц, дугуйлангийн үйл ажиллагааны явц, хүүхдийн хөгжлийн ахиц, санхүүжилтийн тайланг гэрээнд оролцогч талууд хичээлийн жилд 2 удаа хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгнө.

3.6. Төлбөртэй хичээллэх секц, дугуйланд амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцах хүсэлт гаргасан тохиолдолд нэг секц, дугуйланд хоёроос доошгүй суралцагчийг төлбөргүй хамруулж болно.

3.7. Ганцаарчилсан хэлбэрээр төлбөртэй хичээллэх секц, дугуйлангийн нэг цагийн төлбөр нь ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын 2 хувиас хэтрэхгүй байна.

3.8. Бүлгийн хэлбэрээр секц, дугуйлан хичээллүүлсэн тохиолдолд нэг цагийн төлбөр нь ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардлын нормативын 0.8 хувиас хэтрэхгүй байна.

3.9. Төлбөртэй хичээллүүлсэн секц, дугуйлангийн орлогын 40-өөс доошгүй хувийг тухайн секц, дугуйланг удирдсан багшийн ажлын хөлсөнд зарцуулна.

3.10. Төсвийн жилийн дундуур секц, дугуйлан шинээр хичээллүүлснээс олсон орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан үйл ажиллагаанд зарцуулна.

3.11. Секц, дугуйлан хичээллүүлэх үйл ажиллагаанаас олсон орлого, зарлагыг санхүүгийн тайланд тусгана.

3.12. Төлбөртэй секц, дугуйлан хичээллүүлэхээр орлого төлөвлөсөн нь төсөвт байгууллагын улсын төсвийн санхүүжилтыг бууруулах үндэслэл болохгүй.

----000----

# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 11 өдөр | Дугаар А/619 | Улаанбаатар хот

Хуулийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4, 5 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийн тухай хуульд заасанаас бусад хэлбэрийн баяр, тэмдэглэлт өдрийг бүх шатны боловсролын сургалтын байгууллагын суралцагчдын дунд тэмдэглэн өнгөрүүлэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газар, бүх шатны боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

2. Цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц баяр, арга хэмжээнд хүүхдээ оролцуулахгүй байх, амралт чөлөөт цагийг нь зөв зохистой өнгөрүүлэхэд анхаарч, тогтмол хяналт тавьж байхыг эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нэм-Очир/, сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Х.Мягмар/-т тус тус даалгасугай.

САЙД Е.БААТАРБИЛЭГ

0619 02263

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 09 өдөр          Дугаар А/691          Улаанбаатар хот

Албан тушаалд тавих нийтлэг
шаардлага, үндсэн чиг үүрэг батлах тухай

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.27 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" 03 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалд тавих нийтлэг шаардлага, үндсэн чиг үүргийг нэгдүгээр хавсралт, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, үндсэн чиг үүргийг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Хавсралтаар баталсан нийтлэг шаардлага, үндсэн чиг үүрэгт нийцүүлэн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, батлах, албан хаагчийг сонгон шалгаруулах, албан тушаалд томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, ажлын үр дүнг үнэлэхэд баримтлан ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалыг олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын лаборатори сургууль, тусгай сургууль, их дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулах хамтарсан сургууль, гадаадын хөрөнгө оруулалттай ерөнхий боловсролын сургуулиас бусад ерөнхий боловсролын сургуульд мөрдсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нямочир/, аймаг нийслэлийн Боловсролын газарт тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны "Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт батлах тухай" 351 дүгээр тушаалын хоёр, гуравдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД          Е.БААТАРБИЛЭГ

0619 02277

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны [illegible] дугаар сарын [illegible]-ны өдрийн [illegible] дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ТУШААЛД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА, ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

| | |
|---|---|
| **Боловсрол** | Дээд боловсролтой, бакалаврын зэрэгтэй байх |
| **Мэргэжил** | Багш мэргэжил эзэмшсэн байх |
| **Мэргэшил** | Боловсрол, нийгэм, төрийн удирдлага, боловсрол судлалын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх |
| **Туршлага** | • Ерөнхий боловсролын сургуульд үндсэн орон тоонд 5-аас доошгүй жил багшилсан байх;<br>• 3-аас доошгүй жил ерөнхий боловсролын сургуульд удирдах албан тушаалд эсхүл боловсролын салбарын байгууллагад удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажилласан байх |
| **Ур чадвар** | **Багаар ажиллах, багийг удирдан зохион байгуулах чадвар:**<br>- Байгууллагын зорилго, зорилтод хамт олныг нэгтгэх;<br>- Байгууллагын хөгжлийг төлөвлөх, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх<br>- Санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх<br>- Албан хаагчдын оролцоог тэгш хангах;<br>- Албан хаагч нарыг сэдэлжүүлэх, урам зориг өгөх;<br>- - |
| | **Асуудал шийдвэрлэх чадвар:**<br>- Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах;<br>- Шийдвэрийн үр дагаврыг урьдчилан тооцоолох;<br>- Гаргасан шийдвэрийн үр дагаврыг хариуцах;<br>- Маргаан, санал зөрүүг байгууллагын зорилго, оролцогч талуудын нийцэл, ойлголцол, оролцоог хангах шийдвэрлэх ; |
| | **Манлайлах чадвар:**<br>- Ёс зүйгээр бусдыг үлгэрлэх;<br>- Бүтээлч, санаачилгатай, ажил хэрэгч байх;<br>- Ажлын шинэ арга барилыг нэвтрүүлэх, хөгжүүлэх;<br>- Харилцаа, хандлага, хувийн зохион байгуулалтаар үлгэр дууриал үзүүлэх;<br>- Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд өөрөө үлгэрлэн, манлайлах; |
| | **Бусад:**<br>- Баримт бичиг боловсруулах, дүн шинжилгээ хийх чадвартай байх; |

| | |
|---|---|
| | - Мэдээллийн технологийг ажил хэрэгтээ ашиглах чадвартай байх;<br>- Гадаад аль нэг хэлээр мэдээлэл ашиглах, боловсруулах, албан бичгээр харилцах чадвартай байх; |
| Үндсэн чиг үүрэг. | **Салбарын бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр:**<br>- Салбарын бодлого, хууль тогтоомж, сургуулийн хэв шинжид нийцүүлэн байгууллагын стратегийн төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;<br>- Аймгийн Засаг даргатай хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ байгуулах, байгууллагын тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;<br>- Байгууллагын төсвийн төсөөлөл, төсвийг төлөвлөх, батлуулах, зориулалтын дагуу зарцуулах, хяналт тавих, аудит хийлгэх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв, хугацаанд нь тайлагнах;<br>- Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох, төсвийн байгууллагын өдөр тутмын удирдлагыг хэрэгжүүлэх;<br>- Байгууллагын дотоод үйл ажиллагааны эрхзүйн баримт бичгийг баталж мөрдүүлэх /Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, ажил албан тушаалын жагсаалт, албан тушаалын тодорхойлолт, цалин, нэмэгдэл олгох нөхцөл, журам болон бусад гэрээ, заавар, хөтөлбөр, төлөвлөгөө, норм норматив зэрэг/<br>- Боловсролын талаархи төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, явц, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах;<br>- Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах;<br>- Тухайн сургуулийн хамран сургах тойргийн хүүхдийн тоо, төлөв байдлын судалгаа хийх, сөрөг/эсвэл өсөлтийн төлөвийн таамаглал боловсруулах, хамран сургах тойргийн суралцагчдын элсэлтийг зохион байгуулах, элсүүлэн суралцуулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах;<br>- Багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл/заах аргын нэгдэл/танхимийн ажиллах журмыг тогтоох;<br>- Боловсролын баримт бичгийг захиалах, олгох ажлыг удирдлагаар хангах, тайлагнах;<br>- Боловсролын статистик мэдээллийг хянан баталгаажуулах, тогтоосон хугацаанд тайлагнах; |

- Байгууллагыг хөгжүүлэх чиглэлээр дотоод гадаадын сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн дагуу гэрээ хэлцэл хийж хамтран ажиллах;
- Байгууллагад өөрийн үнэлгээ, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, удирдамжаар хангах;
- Сургууль, багшийн үйл ажиллагаа, сургалтын чанар, төгсөгчдийн чанар, боловсролын хүртээмж, үр дүнгийн үзүүлэлтийг тогтмол хянах, шинжилгээ хийх, тайлагнах;
- Сургуулийн үйл ажиллагааны чанар, үр дүнг тандах судалгаа, оношлогоо, хэрэглэгчийн үнэлгээний ажлыг багш, ажилтан, суралцагч, эцэг эх, олон нийтийн оролцоотой зохион байгуулах, хариу арга хэмжээ төлөвлөх, хэрэгжилтийг хангах;
- Бусад төрийн байгууллагаас шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээ мэдээллийг шуурхай, чанартай боловсруулж, хүргүүлэх;
- Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, мэдээллийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх, байгууллагын болон хувь хүний нууцыг хамгаалах;
- Төрийн байгууллагын албан хэргийг холбогдох журам, стандартын дагуу хөтлөх, архив бүрдүүлэх ажлыг удирдлагаар хангах, хяналт тавих;
- Хичээл болон хичээлээс гадуурх арга хэмжээний хүрээнд суралцагчдад авлигын хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлэх, түүнийг үл тэвчих өс суртахууныг төлөвшүүлэх, батлагдсан жагсаалтын дагуу хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хууль тогтоомжид заасны дагуу мэдүүлэх ажлыг зохион байгуулах;
- Сургуулийн нийгмийн ажил, хүүхэд хамгаалал, төлөвшлийн чиглэлээрх бодлого, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтийг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах;
- Төрийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.

**Бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сургалтын арга зүй, технологийг хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангах чиглэлээр:**

- Сургуулийн менежмент, маркетинг хөгжүүлэх, сургалтын талаар баримтлах бодлого, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох, хэрэгжилтийг захиргааны удирдлагаар хангах;

- Хөгжлийн чиг хандлагад баримжаалан, хичээл, сургалтын зохион байгуулалт, сургалтын арга зүй, технологи, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, сургалтын орчны хөгжлийн асуудлаар багш, ажилтныг мэдээллээр хангах, дэвшилтэт арга зүй, технологийг турших,

| | |
|---|---|
| | нэвтрүүлэх ажлыг захиргааны удирдлагаар хангах, дэмжих, зөвлөн туслах;<br>- Бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүй, үнэлгээний хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Боловсролын газрын удирдлага дор зохион байгуулж, үр дүнг тайлагнах;<br>- Сургуулийн бүтцийн нэгж, хэв шинж, ангийн менежментийг оновчтой тогтоох;<br>- Хичээл болон хичээлээс гадуурх сургалтын ажлыг чанартай зохион байгуулахад сургалтын менежер, багш нарт дэмжлэг үзүүлэх, удирдлагаар хангах, хамтран ажиллах;<br>- Багш нарын зөвлөл, Заах аргын нэгдлийг мэргэжил арга зүйн удирдлагаа хэрэгжүүлэхэд нь захиргааны дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах;<br>- Багш нарын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн суралцагчийг анги дэвшүүлэн суралцуулах, сургууль төгсөх асуудлыг шийдвэрлэх;<br>- Сургалтын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч болон зохих байгууллагад шаардлага тавьж шийдвэрлүүлэх;<br>- Насан туршийн болон албан бус сургалтыг зохион байгуулах ажлыг удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх.<br><br>**Байгууллагын хүний нөөцийн хөгжил, төлөвшлийг хангах, багшийн мэргэжил дээшлүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах чиглэлээр:**<br><br>- Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, нөөцийг зөв байршуулах, төлөвшүүлэх;<br>- Ажлын байранд тавигдах шаардлагад нийцсэн ажилтныг сонгон шалгаруулах, хуульд заасан үндэслэлээр ажилд томилох, ажлаас чөлөөлөх;<br>- Багш ажилтны хөдөлмөрийн үр дүн, ур чадварыг үнэлэх, урамшуулах, дэмжих, хариуцлага тооцох эрхзүйн орчныг бүрдүүлэх;<br>- Төрийн албан хаагчдын хувийн хэрэг, мэдээллийн санг баяжуулах, шинэчлэх, архивлан хадгалуулах ажлыг зохион байгуулах;<br>- Багш, ажилтны мэргэжил, ур чадварын тасралтгүй хөгжлийг дэмжих орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байранд мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг баталж, тогтвортой хэрэгжүүлэх; |

| | |
|---|---|
| | - Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах;<br>- Багшийн ёс зүйн орон тооны бус зөвлөлийг байгуулах, ажиллах нөхцөл боломжоор хангах, багш, ажилтныг мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;<br>- Багш нарын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн багшид мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах;<br>- Багш, ажилтны бүтээлч үйл ажиллагааг сурталчилан таниулах, урамшуулах, шилдэг арга зүй, технологи, менежмент, маркетинг, соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах.<br>**Байгууллагын санхүүгийн болон материаллаг нөөцийг төлөвлөх, хэрэгжүүлэх, суралцагч, багш ажилтныг эрүүл, аюулгүй таатай орчинд сурч, төлөвших, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр:**<br>- Бага, суурь, бүрэн дунд боловсролын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эрүүл, аюулгүй байдал хангасан сургалтын материаллаг орчин бүрдүүлэх, сайжруулах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах, хяналт тавих, эрсдлийн үнэлгээ тогтмол хийх;<br>- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн эрүүл, аюулгүй дэд бүтэц бүрдүүлэх;<br>- Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх;<br>- Байгууллагын өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагаандаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмших, ашиглах, эд хөрөнгийн бүртгэлийг цахимжуулах, өмч эзэмшигчийн картыг шинэчлэх ажлыг зохион байгуулах;<br>- Хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлах, мөрдөж ажиллах;<br>- Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, статистикийн мэдээлэл, бусад шаардлагатай мэдээ, судалгаа, тайланг үнэн зөв гаргах, холбогдох байгууллага, албан тушаалтанд тогтоосон хугацаанд нь мэдээлэх, тайлагнах;<br>- Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг ил тод, нээлттэй, цаг хугацаанд нь мэдээлэх;<br>- Сургуулийн барилга байгууламж дахь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай байр, талбай, тоног төхөөрөмжийг нийтийн өмчийг ашиглах, эзэмших, захиран зарцуулахтай |

| | |
|---|---|
| | холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актаар тогтоосон журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулалтаар зориулалтын дагуу түрээслүүлэх;<br>- Шийдвэр гаргахад багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл, багш, суралцагч, эцэг, эх, олон нийтийн оролцоог хангах, сургуулийн үйл ажиллагаа, сургалтын явц, үр дүнгийн талаар нээлттэй мэдээлэх;<br>- Сургуулийн орчин дахь хоол, хүнс, ундны цэвэр ус, бие засах газрын эрүүл ахуй, аюулгүй байдлын баталгааг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;<br>- Суралцагчид дотуур байранд амьдрах орчин нөхцлийг тогтмол сайжруулах, хяналт тавих;<br>- Суралцагчийг сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчил гарах, гэмт хэрэг, зөрчил хэрэг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажиллагаар тэлөвлөх, хэрэгжилтийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;<br>- Төрийн байгууллагын албан хэргийг холбогдох журам, стандартын дагуу хөтлөх, архив бүрдүүлэх ажлыг удирдлагаар хангах, хяналт тавих;<br>- Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, стандарт, зааврын дагуу төлөвлөх, үдийн цайны цэс батлах, зохион байгуулах, мэргэжлийн ажилтнаар хангах, давтан сургах ажлыг удирдах;<br>- Сурагчдыг сурах бичиг, дүрэмт хувцсаар хангах ажлыг холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотой зохион байгуулах;<br>- Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, дотоод үйл ажиллагаа, харилцааны таатай уур амьсгал бүрдүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах;<br>- Суралцагчдын өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;<br>- Сургуулийн үйл ажиллагаанд эцэг, эх, олон нийтийн оролцоог хангах, сургуулийн орчинд нийгэм-сэтгэл зүйн таатай уур амьсгал бүрдүүлэх. |

--- 000 ---

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2019 оны [illegible] дугаар сарын [illegible]-ны өдрийн
[illegible] дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН МЕНЕЖЕРИЙН АЛБАН ТУШААЛД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА, ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

| | |
|---|---|
| **Боловсрол** | Дээд боловсролтой, бакалаврын зэрэгтэй байх |
| **Мэргэжил** | Багш мэргэжил эзэмшсэн байх |
| **Мэргэшил** | Боловсрол, нийгэм, төрийн удирдлага, боловсрол судлалын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх |
| **Туршлага** | • Ерөнхий боловсролын сургуульд үндсэн орон тоонд 5-аас доошгүй жил багшилсан байх;<br>• 2-оос доошгүй жил заах аргын нэгдэл /тэнхим/ удирдаж ажилласан туршлагатай байх; |
| **Ур чадвар** | **Багаар ажиллах, багийг удирдан зохион байгуулах чадвар:**<br>- Байгууллагын зорилго, зорилтод хамт олныг нэгтгэх;<br>- Байгууллагын хөгжлийг төлөвлөх, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх<br>- Санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх<br>- Шийдвэр гаргахад хамт олны оролцоог тэгш хангах;<br>- Багш, ажилтныг сэдэлжүүлэх, урам зориг өгөх; |
| | **Дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх чадвар:**<br>- Дүн шинжилгээ хийх өндөр чадвартай байх;<br>- Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах;<br>- Шийдвэрийн үр дагаврыг урьдчилан тооцоолох;<br>- Гаргасан шийдвэрийн үр дагаврыг хариуцах;<br>- Маргаан, саналын зөрүүг байгууллагын зорилго, оролцогч талуудын нийцэл, ойлголцол, оролцоог хангах шийдвэрлэх ; |
| | **Манлайлах чадвар:**<br>- Ёс зүйгээр бусдад үлгэрлэх;<br>- Бүтээлч, санаачилгатай, ажил хэрэгч байх;<br>- Ажлын шинэ арга барилыг нэвтрүүлэх, хөгжүүлэх;<br>- Харилцаа, хандлага, хувийн зохион байгуулалтаар үлгэр дуурайл үзүүлэх;<br>- Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд өөрөө үлгэрлэн, манлайлах; |
| | **Бусад:**<br>- Баримт бичиг боловсруулах;<br>- Мэдээллийн технологийг ажил хэрэгтээ ашиглах чадвартай байх;<br>- Гадаад аль нэг хэлээр мэдээлэл ашиглах, боловсруулах, албан бичгээр харилцах чадвартай байх;<br>- Заах аргач ба түүнээс дээш зэрэгтэй байх. |

| | |
|---|---|
| Үндсэн чиг үүрэг | **Бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, үнэлгээ, арга зүйн хэрэгжилтийг сургуулийн хэмжээнд урт болон дунд, богино хугацаагаар төлөвлөх, сургалтын өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр:**<br>- Сургуулийн сургалтын бодлого, стратегийн зорилт, сургалтын зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох, хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангах;<br>- Бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүй, үнэлгээний хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Боловсролын газрын удирдлага дор зохион байгуулж, үр дүнг тайлагнах;<br>- Салбарын бодлого, хууль тогтоомж, сургалтын чиглэлээр батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм журам, аргачлалын хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;<br>- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд үндэслэн сургуулийн хэв шинж, багшийн мэргэжил, ур чадвар, суралцагчдын хэрэгцээ сонирхолд тулгуурласан сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;<br>- Сургалтын үйл явцын зохион байгуулалтыг хичээлийн жил, улирлаар төлөвлөн хичээлийн хуваарь батлах, хэрэгжилтэд хяналт тавих;<br>- Сургуулийн хэв шинжид нийцүүлэн, анги бүлгийн менежментийг оновчтой тогтоох, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;<br>- Сургуулийн мэргэжил арга зүйн нэгжүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;<br>- Сургуулийн сургалтын үйл явцад өдөр тутмын зохицуулалт хийх, хяналт тавих;<br>- Суралцагчийг анги дэвшүүлэн суралцуулах, сургууль төгсөх асуудлыг Багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, санал дүгнэлтийг удирдлагад танилцуулах;<br>- Сургалтын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч болон зохих байгууллагад шаардлага тавьж шийдвэрлүүлэх;<br>- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн сургалтын орчин, арга зүй бүрдүүлэх;<br>**Багшийн хөгжлийг дэмжих сургуулийн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох чиг үүргүүд:**<br>- Сургуулийн багшийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, багшийн мэргэжил дээшлүүлэх төлөвлөгөөг урт болон дунд, богино хугацаагаар батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;<br>- Хөгжлийн чиг хандлагад баримжаалан, хичээл, сургалтын зохион байгуулалт, сургалтын арга зүй, технологи, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, сургалтын орчны хөгжлийн асуудлаар багш, ажилтныг мэдээллээр хангах, дэвшилтэт арга зүй, технологийг туршиж, |

| | |
|---|---|
| | нэвтрүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, дэмжих, зөвлөн туслах;<br>- Багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл/тэнхимийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдлага арга зүйгээр хангах, хяналт тавих, зөвлөн туслах;<br>- Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдлага зохицуулалтаар хангах;<br>- Багш нарын хичээлийн бэлтгэлд хяналт тавих, хичээл сургалтын үйл явц, үр дүн, ур чадварын хөгжилд ажиглалт, судалгаа, шинжилгээ хийх, зөвлөн туслах;<br>- Багшийн хөдөлмөрийн үр дүн, ур чадварыг үнэлэх, урамшуулах, дэмжих, хариуцлага тооцоход дүгнэлт санал боловсруулж, танилцуулах;<br>- Багш, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр хэрэгжилтийг хангахад сургуулийн удирдлагад дэмжлэг үзүүлэх;<br>- Багшийг ажлын байран дээр суралцах, хамтран ажиллах, ур чадвараа хөгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, дүгнэх, тайлагнах;<br>- Багшийн бүтээлч үйл ажиллагааг сурталчилан таниулах, урамшуулах, шилдэг арга зүй, технологийг түгээн дэлгэрүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах;<br>- Багшид мэргэжлийн зэрэг олгох, сунгах, цуцлах асуудлыг Багш нарын зөвлөлд хэлэлцүүлэх, санал дүгнэлтийг сургуулийн удирдлагад танилцуулах;<br>- Багш мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ зөрчих, авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах.<br>**Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчийн сурлагын чанарт хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ дүгнэлт өгөх, зөвлөмж, аргачлал боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр:**<br>- Сургалтын үйл ажиллагааны дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, арга зүйн удирдамжаар хангах;<br>- Сургууль, багшийн үйл ажиллагаа, сургалтын чанар, төгсөгчдийн чанар, боловсролын хүртээмж, үр дүнгийн үзүүлэлтийг тогтмол хянах, шинжилгээ хийх, график төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэх, тайлагнах;<br>- Сургалтын хөтөлбөрт анализ хийж, үнэлгээ өгөх, зөвлөмж, аргачлалаар хангах; |

| | |
|---|---|
| | - Үнэлгээний даалгавар боловсруулах, сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэх;<br>- Сургуулийн сургалтын үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд тайлагнах, мэдээлэх;<br>- Улсын шалгалт, анги дэвших шалгалтыг төлөвлөх, зохион байгуулах, дүнд анализ хийх, тайлагнах;<br>**Боловсролын статистик мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, боловсролын салбарын мэдээллийн системд сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн санг бүрдүүлэх, тогтмол шинэчлэн хөтлөх, тайлагнах чиглэлээр:**<br>- Боловсролын болон сургалтын баримт бичгийг хөтлөх, олгохтой холбоотой дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангах;<br>- Боловсролын статистик мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах ажлыг сургуулийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, тайлагнах;<br>- Сургалтын баримт бичиг болох сурагчийн хувийн хэрэг, ангийн журналыг хөтлөх журмын хэрэгжилтийг зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангах;<br>- Боловсролын салбарын мэдээллийн системд сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн санг бүрдүүлэх, тогтмол шинэчлэн хөтлөх, тайлагнах;<br>- Боловсролын болон сургалтын баримт бичиг, бүртгэл мэдээллийг холбогдох дүрэм журмын дагуу архив бүрдүүлэх, хадгалуулах ажлыг хариуцах;<br>- Төрийн болон төрийн бус байгууллагад ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээ мэдээллийг шуурхай, чанартай боловсруулж, хүргүүлэх;<br>- Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, мэдээллийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх, байгууллагын болон хувь хүний нууцыг хамгаалах. |

---000---

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 28 өдөр Дугаар А/756 Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.27 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Монгол Улсын Их хурлын 2017 оны "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 46 дугаар тогтоолын 4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Насан туршийн боловсрол" хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажиллагааг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нэм-Очир/, аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажиллагааг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /З.Энхболд/-т даалгасугай.

САЙД Ё.БААТАРБИЛЭГ

My documents. Tushaal. A4

0619 02535

БСШУСЯ-ны сайдын 2019 оны
11 дүгээр сарын 28 өдрийн А/[illegible] дугаар
тушаалын хавсралт

## "НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ" ХӨТӨЛБӨР

### НЭГ. ХЭРЭГЦЭЭ, НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-д "Иргэн бүрт насан туршдаа боловсрол эзэмших орчин, нөхцөл боломжийг бүрдүүлэн, нас, бие, сэтгэцийн онцлог, авьяас, хүсэл сонирхолд нийцүүлж мэргэжил, чадвараа дээшлүүлэх сургалтын төрөл, хэлбэрийг дэмжин хөгжүүлэх" зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.27-д "Орчин үеийн мэдээлэл, технологийн ололтод тулгуурласан насан туршийн боловсролын тогтолцоог эрчимтэй хөгжүүлнэ." гэж заасан.

"Тогтвортой хөгжил: 2030 хөтөлбөр"-т боловсролын зорилго нь "Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролыг баталгаажуулж, хүн бүрийг насан туршдаа суралцах боломжоор хангах явдал" хэмээн тодорхойлжээ.

Насан туршийн боловсролыг хөгжингүй орнууд хувь хүний хөгжлийг хангах, цагаан иргэдийн боловсролыг дээшлүүлэх арга зам болгодог бол, хөгжиж байгаа орнууд хэл, соёл, мэдээллийн технологийн чадварыг насанд хүрэгчдэд эзэмшүүлэхэд анхаарч байна. Харин буурай хөгжилтэй улс орнууд насан туршийн боловсролын үйлчилгээг иргэдэд бичиг үсэг, эрүүл мэнд, амьдрах ухааны чадвар эзэмшүүлж, ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлогоор хэрэгжүүлдэг.

Монгол Улс насан туршийн боловсролыг бүх нийтийн боловсролоор соён гэгээрүүлэх гол хэрэглүүр, насанд хүрэгчдийн боловсролын үйлчилгээ хэлбэрээр хөгжүүлж, амьдрах эрдэд тасралтгүй суралцдаг, ур чадвартай иргэн төлөвшүүлэх зорилт дэвшүүлсэн.

Гэвдээ Монгол Улсад албан бус насан туршийн боловсролын тогтолцоо үүсч хөгжөөд 20 жил болж байгаа хэдий ч дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд түс тогтолцооны эрх зүй, бүтэц, зохион байгуулалт, боловсон хүчний чадвах, санхүүгийн нөөц хүрэлцээгүй хэвээр байна.

Иймд иргэдэд насан туршийн боловсролын үйлчилгээ үзүүлэх чадамжийг бэхжүүлэх, цаашид үндэсний хэмжээнд насан туршийн боловсролын тогтолцоо бүрдүүлж, төлөвшүүлэх зорилгоор түс хөтөлбөрийг боловсруулав. Энэхүү хөтөлбөр нь иргэний амьдралын чанарыг эзэмшсэн боловсролоос нь шууд хамааралтайгаар сайжруулахад чиглэсэн боловсролын бодлогын суурь болно.

### ХОЁР. НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН АЛСЫН ХАРАА

Иргэн бүр сайхан амьдралын төлөө тасралтгүй суралцаж болдог, сурсан зүйл нь үнэлэгдэн амьдралын чанарыг бодитойгоор дээшлүүлдэг, улмаар боловсролоор дамжуулан нийгмийг бүхэлд нь соён гэгээрүүлэх боломж Монголын нийгэмд бүрдэх болно.

### ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Нийгмийн захиалга, хувь хүний хэрэгцээнд нийцсэн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, хүртээмжтэй хэлбэрээр тасралтгүй эзэмшүүлэх насан туршийн боловсролын тогтолцооны чадамжийг нэмэгдүүлж, боловсронгуй болгоно.

## ДӨРӨВ. СТРАТЕГИ ЗОРИЛТУУД

**Стратегийн зорилт 1.** Иргэдэд насан туршийн боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах эрх зүй, боловсон хүчин, бүтэц, зохион байгуулалт, сургалтын хөтөлбөр, орчин, санхүүгийн тогтолцоог бэхжүүлэх;

**Стратегийн зорилт 2.** Цаашид үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлж, салбар дамнасан насан туршийн боловсролын тогтолцоо бүрдүүлж төлөвшүүлэх суурь эхлэлийг тавих.

## ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗАРЧИМ

5.1. Насан туршийн боловсролын үйлчилгээ нь дэлхий нийтийн жишиг, Монгол Улсын хөгжлийн чиг хандлагад нийцсэн, хувь хүний хэрэгцээ, амьдралын чанар, бодит амьдралд чиглэсэн байна.

5.2. Үйлчилгээний арга, хэлбэр нь сонгох боломжтой, уян хатан, нээлттэй, тэгш хүртээмжтэй байх ба засаг захиргааны нэгж, нийгмийн салбаруудын хамтын ажиллагаанд суурилсан байна.

## ЗУРГАА. НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

**6.1. Цахим платформд суурилсан нээлттэй контентийн үйлчилгээ**

- Мэдээллийн технологи, цахим хэрэглээний сургалт
- Гадаад дахь монгол иргэнд зориулсан сургалт
- Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт
- Үндэсний болон гадаад хэлний сургалт
- Соён гэгээрүүлэх цахим сургалт

**6.2. Насанд хүрэгчдийн тасралтгүй сургалт**

- Гэр бүл, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт
- Иргэний эрх зүй, улс төрийн боловсрол олгох сургалт
- Харилцаа, ёс зүйн боловсрол олгох сургалт
- Соёл, гоо зүйн боловсрол олгох сургалт
- Амьдрах ухаан, санхүүгийн боловсрол олгох сургалт
- Шинжлэх ухааны ололт, технологийн хөгжлийг амьдралд хэрэглэх чадвар эзэмшүүлэх сургалт

**6.3. Ерөнхий боловсрол нөхөн олгох сургалт**

- Сургууль завсардсан хүүхэд зориулсан танхимын сургалт
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан гэрийн сургалт
- Насанд хүрэгчдэд зориулсан зайны сургалт
- Гадаад дахь монгол иргэдийн хүүхдэд зориулсан зайны сургалт
- Лам хүүхдэд зориулсан танхимын болон зайны сургалт
- Засан хүмүүжих байгаа иргэнд зориулсан танхимын сургалт

## ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ХУГАЦАА

Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- Нэгдүгээр үе шат: 2019-2021 онд насан туршийн боловсролын тогтолцооны эрх зүй, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийн горим, менежментийн чадавхийг бэхжүүлнэ.
- Хоёрдугаар үе шат: 2021-2022 онд үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, салбар дамнасан насан туршийн боловсролын тогтолцоо бүрдүүлэх бэлтгэлийг хангана.

## НАЙМ. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 8.1. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1: САЛБАРЫН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### 8.1.1. Үндэсний түвшинд

- Аймаг, дүүргийн Насан туршийн боловсролын төвийг бие даасан, улсын төсвөөс санхүүждэг байгууллага хэлбэрээр байгуулах тухай заалтыг боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгад оруулах;
- Насан туршийн боловсролын салбарт авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;
- Насан туршийн боловсролын төвийн үлгэрчилсэн дүрэм, ажилтнуудын албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлах;
- Насан туршийн боловсролын хүрээнд иргэдэд хэрэгцээт ур чадвар олгох болон дүйцсэн сургалтын чиглэл бүрээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Насан туршийн боловсролын багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын эрх зүй, зохион байгуулалт, санхүүгийн орчныг сайжруулах;
- Насан туршийн боловсролын сургалтад хамрагдаж ур чадвар эзэмшсэн иргэний мэдээллийн сан бий болгох;
- Шийдвэр гаргагч нар болон орон нутгийн удирдлагын хандлага, ойлголтыг сайжруулах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах;
- Гадаад оронд байгаа монгол иргэдийн хүүхдэд үндэсний хэл бичиг, соёл, ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг эхлэх;
- Аймаг дүүргийн төвүүдэд онлайн сургалтын орчин бүрдүүлж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;
- Насан туршийн боловсролын Үндэсний төвийг түшиглэн зайны сургалтын төв байгуулж, хэвлэлийн цех, теле студийн тоног төхөөрөмжийг шинэчлэх.

#### 8.1.2. Орон нутгийн түвшинд

- Аймаг, нийслэлийн Насан туршийн боловсролын төвүүдийг байртай болгох, бүтэц, орон тоо, үйл ажиллагааны чиглэлийг жигдрүүлэх;
- Төвийг мэргэжлийн багшаар хангах, багш ажилтнаар бусад чиг үүрэг хавсран гүйцэтгүүлэхгүй, бие даасан орон тоон дээр ажиллуулах;
- Дүйцсэн хөтөлбөрөөр явуулах сургалтын журмыг хэрэгжүүлж, ерөнхий боловсролын сургуулийн багш нараар гэрээний дагуу хичээл заалгах;
- Эхэлүү хөтөлбөрийн 6-д заасан сургалтыг үндэсний болон орон нутгийн төр, иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй хамтран явуулах;
- Насан туршийн боловсролын багш нарын ур чадварын үнэлгээ, өнөө тэргүүний төв шалгаруулах үйл ажиллагаа зохион байгуулдаг болох;
- Орон нутагт хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмж хүргүүлж, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээнд дээрх асуудлуудыг тусгах.

#### 8.1.2. Олон улсын байгууллага, хөтөлбөрийн хамтын ажиллагааны түвшинд

- Насан туршийн боловсролын салбарт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өөрөө үйлдвэрлэх, хөдөлмөр, мэргэжлийн чиг баримжаа олгох Зөвлөгөө-мэдээллийн төвийн аймаг, дүүргийн Насан туршийн төвийг түшиглэн байгуулах төслийг Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх;
- Дүйцсэн хөтөлбөр болон сургалтын журмыг шинэчлэх, модуль боловсруулж хэвлүүлэх, иргэд, өөрөө үйлдвэрлэх эрүүл мэндийг дэмжих гарын авлага боловсруулж, сургалт зохион байгуулах ажлыг НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хийж гүйцэтгэх;

- Насан туршийн боловсролын агуулгыг боловсронгуй болгох, цахим хэлбэрт оруулах, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, хэвлэх, түгээх, МУБИС-ын насан туршийн боловсролын бакалаврын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, сургалт зохион байгуулах ажлыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийж гүйцэтгэх;
- Боловсролын удирдлагын мэдээллийн системд дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч, насанд хүрэгчдийн сургалтад хамрагдсан иргэдийн мэдээллийг байршуулж, салбарын статистик судалгааны мэдээг бүрэн шинэчлэх болон өсвөр үеийнхэнд харилцааны ур чадвар эзэмшүүлэх төслийг Японы Хүүхдийг ивээх сантай хамтран хэрэгжүүлэх;
- Өсвөр үеийнхэн, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах ажлыг НҮБ-ын Хүн амын сантай хамтран хийж гүйцэтгэх;
- Насан туршийн боловсролын багшийн мэдээллийн технологи, төрийн үйлчилгээг цахимаар авах иргэдийн ур чадварыг сайжруулах сургалт, үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
- Аймаг, сум дахь иргэдийн насан туршийн боловсролын үйлчилгээг нийгмийн салбаруудтай холбох, түншлэл бэхжүүлэх, "Ардын их сургууль" хэлбэрээр туршин ажиллуулах үйл ажиллагааг "Тогтвортой хөгжил" төсөлтэй хамтран хийж гүйцэтгэх.

## 8.2. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2: ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 8.2.1. Салбар дундын хамтын ажиллагааны чиглэл

- Иргэдэд хэрэгцээтэй ур чадвар тасралтгүй олгох ажлыг үндэсний хэмжээнд удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Насан туршийн боловсролын үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд байгуулах;
- Насан туршийн боловсрол олгох сургалтаар эзэмшсэн иргэний мэдлэг, чадварыг үнэлэх, гэрчилгээ олгох баталгаажуулах эрх зүйн нөхцөл орчин бүрдүүлэх асуудлаар холбогдох яамдтай санал солилцож, нэгдсэн ойлголтод хүрэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн иргэдэд шаардагдаж байгаа ур чадварын судалгаа, мэдээллийн ажлыг Насан туршийн боловсролын үндэсний төв, аймаг, дүүргийн төвүүдээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх;
- Иргэнд зориулсан насан туршийн боловсролын сургалт явуулах байгууллага, хувь хүнд тавигдах шалгуур үзүүлэлтийг сургалтын чиглэл бүрээр боловсруулж, магадлан итгэмжлэх, эрх олгох, хяналт тавих эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлаар холбогдох яамтай хамтран ажиллах;
- Үндэсний мэргэжлийн хүрээнд нийцүүлэн хэрэгцээт ур чадвар олгох сургалтын үр дүнг дүйцүүлсэн жишиг нормативийг мэргэжил-сургалтын чиглэл бүрээр боловсруулах;
- Насан туршийн боловсролын үйлчилгээг орон нутаг дахь эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, номын сан, урлаг, биеийн тамир, хүүхэд, байгаль орчин, онцгой байдал, хүүхэд, залуучууд, гэр бүлийн чиглэлээрх төр, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулах;
- Нийгмийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг цахим сүлжээ, тв, сонин хэвлэлээр зохион байгуулах;
- Гадаад орны насан туршийн боловсролын байгууллагуудтай хамтран ажиллах.

### 8.2.2. Судалгааны ажлын чиглэл

- Нийгмийн захиалга, хувь хүний өсөн нэмэгдэж байгаа амьдрах ухаан, ажил мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх хэрэгцээнд нийцсэн сургалтын иж бүрэн

тогтолцоо бүрдүүлэх, агуулга, арга зүй, үнэлгээг сайжруулах зорилгоор үндэсний түвшинд судалгаа хийх;
- Төр, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгжээс ажилтан, иргэдэд зориулан явуулж буй сургалтын нэгдсэн бүртгэл гаргах, бүртгэл-мэдээлэл, менежментийн нэгдсэн сүлжээнд оруулах, мэргэжлийн болон зөөлөн ур чадвар олгох сургалтын курс, загвар тогтоох судалгаа хийх;

## ЕС. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
- Улс, орон нутгийн төсөв
- Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр
- Өөрийн үйл ажиллагааны орлого

## АРАВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

10.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын чиг үүргийг үндэсний хэмжээнд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

10.2. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын чиг үүргийг аймаг, нийслэлийн Насан туршийн боловсролын төв гүйцэтгэн Засаг даргад тайлагнаж, тайланг хагас жил, жилийн эцсээр гарган боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

10.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц болон хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараах хяналт-шинжилгээ, үнэлгээг Насан туршийн боловсролын үндэсний төв хийж гүйцэтгэн үр дүнг Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдад тайлагнана.

10.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж нь холбогдох бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл болно.

## АРВАН НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ҮР ДҮН

**Тоон үнэлгээний шалгуур үзүүлэлт**

- Насан туршийн боловсролын асуудлаар гарсан, шинэчилсэн эрх зүйн баримт бичгийн тоо
- Улсын болон орон нутгийн төсвөөс насан туршийн боловсролын салбарт зарцуулдаг хөрөнгийн хэмжээ, өсөлт
- Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын болон насанд хүрэгчдэд боловсрол олгох зориулалттай хөтөлбөр, гарын авлага, онлайн сургалтын материалын тоо, өсөлт
- Насан туршийн боловсролын мэдээллийн үндэсний сангийн тоон үзүүлэлт, баталгаажилт
- Насан туршийн боловсролын багш нарт зориулсан сургалтын тооны өсөлт
- Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч гадаад оронд амьдарч байгаа болон лам, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооны өсөлт
- Насан туршийн боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн гадаад улс орон, хандивлагч байгууллагын төсөл, хөтөлбөр тоо, санхүүжилтийн тоон өсөлт

**Чанарын үнэлгээний шалгуур үзүүлэлт**

- Аймаг, нийслэл, сумын Насан туршийн боловсролын төв, нэгжийн менежментийн чадавх, багшийн мэргэжил, менежментийн мэдлэг, ур чадварын өсөлт

- Үндэсний төвийн хэвлэлийн цах, зайны сургалтын студийн үйл ажиллагаа тогтворжсон байдал, үйлчилгээний цар хүрээ
- Насан туршийн боловсролын аймаг, дүүргийн төв, сумын нэгжийн сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хүрэлцээ нэмэгдсэн байдал
- Орон нутагт төр, иргэний нийгмийн байгууллагуудын албан бус сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтын нэгдмэл байдал
- Хүн амын боловсролын түвшинг дээшлүүлэх ажилд төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоо нэмэгдсэн байдал

**Хүрэх үр дүн**

- Иргэдэд насан туршийн боловсролын үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах эрх зүйн орчин, боловсон хүчин, бүтэц, зохион байгуулалт, сургалтын хөтөлбөр, орчин, санхүүгийн тогтолцоог бэхжүүлсэн байна.
- Насан туршийн боловсролын үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, салбар дамнасан тогтолцоо бүрдүүлэх суурь эхлэл тавигдсан байна.

---000---

# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны [illegible] сарын 17 өдөр Дугаар A/303 Улаанбаатар хот

## Журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-ын 3.18 дахь заалт, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа үнэлэх журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал, аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтан нарт үүрэг болгосугай:

3.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа үнэлэх журмыг хэрэгжүүлэх зөвлөмжийг 2020 оны I улиралд багтаан боловсруулж, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газарт хүргүүлэхийг Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Ж.Мягмар/, Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нэм-Очир/-т;

3.2. Байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийх арга зүйн сургалтыг 2020 оны III улиралд багтаан үе шаттайгаар зохион байгуулахыг Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Ж.Мягмар/, Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нэм-Очир/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/-д;

3.3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа үнэлсэн үнэлгээний үр дүнг боловсролын салбарын мэдээллийн системээр цуглуулах, шинжилгээ хийх програм хангамжийг хөгжүүлэх шийдлийг 2020 оны I улиралд багтаан танилцуулахыг Мэдээллийн технологи, статистикийн хэлтэс /О.Дунжинхандмаа/-т;

3.4. Журмыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулан, үнэлгээний бодлогыг арга зүйгээр хангах, хөндлөнгийн үнэлгээг үр дүнтэй зохион байгуулж байхыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт.

0619 02646

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайханд даалгасугай.

5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2003 оны 321 дүгээр тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх тоон болон чанарын шалгуур үзүүлэлт"-ийг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Е.БААТАРБИЛЭГ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2019 оны 12 дугаар
сарын [illegible]-ний өдрийн [illegible] дугаар
тушаалын хавсралт

## ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль /цаашид "цэцэрлэг, сургууль" гэх/-ийн үйл ажиллагааны чанар, үр дүнг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээ /цаашид "үнэлгээ" гэх/-ний зорилго нь байгууллагын менежмент, багшлах, суралцах үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулахад оршино.

1.3. Үнэлгээ нь тасралтгүй явагдах эргэх холбоо бүхий үйл явц бөгөөд тухайн байгууллага дэвшүүлсэн зорилгодоо хүрч буй эсэхийг тогтоож, цаашид сайжруулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно.

1.4. Үнэлгээ нь хууль тогтоомжид нийцсэн, ил тод, нээлттэй, шударга ёсны зарчимд тулгуурласан, албан ёсны тоо баримт, мэдээлэлд суурилсан, боловсролын харилцаанд оролцогч талуудын оролцоог хангасан, үнэлгээ, дүгнэлт нь бодитой, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц, хөндлөнгийн нөлөөллгүй байна.

1.5.Үнэлгээ нь өөрийн болон хөндлөнгийн гэсэн хэлбэртэй байна.

1.5.1. Өөрийн үнэлгээ гэж цэцэрлэг, сургууль дэвшүүлсэн зорилгодоо хүрч буй эсэх, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чанар, нийцийг баримт нотолгоонд тулгуурлан хамтын оролцоотой үнэлж, байгууллагын түвшинд сайжруулах шаардлагатай асуудлыг илрүүлэх оношилгоог ойлгоно.

1.5.2. Хөндлөнгийн үнэлгээ гэж өөрийн үнэлгээ бодитой эсэхийг магадлан баталгаажуулах, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад шаардагдах дэмжлэгийг тодорхойлох зорилгоор хөндлөнгийн байгууллагаас хийх үнэлгээг ойлгоно.

1.6. Өөрийн үнэлгээнд тулгуурлан хөндлөнгийн үнэлгээг зохион байгуулна.

1.7. Үнэлгээг тухайн байгууллагын бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, удирдлагын шийдвэр, хичээл, сургалтын явц болон сургалтад хэтлэгдэж буй баримт бичиг, сургалтын чанар, үр дүнд хийсэн дүн шинжилгээ, хичээл ажиллагааны тэмдэглэл, удирдлагын манлайлал, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн хамтын ажиллагаа, хүүхдэд үзүүлэх үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хамаарах албан ёсны баримт мэдээлэлд тус тус үндэслэн хийнэ.

1.8. Үнэлгээ хийхэд энэ журмын хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлтийг баримтлах бөгөөд үнэлгээний үнэн зөв, бодит байдлыг үнэлгээний баг хариуцна.

1.9. Өөрийн үнэлгээг жил бүр, хөндлөнгийн үнэлгээг 3 жил тутам тус тус хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээг хугацаанаас нь өмнө хийж болно.

**Хоёр. Өөрийн үнэлгээний зохион байгуулалт**

2.1. Өөрийн үнэлгээг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлын тушаалаар томилсон үнэлгээний баг зохион байгуулна.

2.1.1. Цэцэрлэг, сургуулийн хэв шинж, багш, ажилтны тооноос хамаарч үнэлгээний баг 5-15 гишүүнтэй байна.

2.1.2. Үнэлгээний багийн бүрэлдэхүүнд цэцэрлэг, сургуулийн зөвлөл, заах аргын нэгдлийн ахлагч, багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл байна.

2.1.3. Үнэлгээний багийн бүрэлдэхүүнд ажиллах хүний тоо, төлөөлөл, багт ажиллах багш, ажилтны нэрийг хамт олны хурлаар хэлэлцэж тогтох бөгөөд хамт олны хуралд нийт багш, ажилтны 90-ээс доошгүй хувь нь оролцож, тэдний 60-аас доошгүй хувь нь хэлэлцэж буй асуудлыг дэмжсэн тохиолдолд шийдвэрийг хүчинтэйд тооцно.

2.1.4. Энэ журмын 2.1.3-т заасан хурлын шийдвэрт үндэслэн үнэлгээний багт ажиллах суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг суралцагчийн болон эцэг, эх, асран хамгаалагчийн зөвлөлийн хурлаас нэр дэвшүүлнэ.

2.1.5. Цэцэрлэг, сургуулийн хамт олны хурал болон энэ журмын 2.1.4-д заасан зөвлөлийн хурлын шийдвэрт тус тус үндэслэн үнэлгээний багийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал баталгаажуулна.

2.2. Үнэлгээний баг гишүүдийн ажлын чиг үүргийг тодорхойлох, өөрийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан үе шаттай хэрэгжүүлнэ.

2.3. Үнэлгээний баг энэ журмын хавсралтаар баталсан шалгуурын дагуу холбогдох баримт, нотолгоо, мэдээлэл цуглуулах асуулга, ярилцлагад нийт багш, ажилтны 90-ээс доошгүй хувь, VII-XII ангийн суралцагчдын 80 хүртэл хувийг тус тус хамруулна.

2.3.1. Дотуур байрны үйлчилгээний талаар дотуур байранд амьдарч буй VII-XII ангийн суралцагчдаас асуулга авна.

2.4. Хичээл, үйл ажиллагааны зохион байгуулалтын шалгуур үзүүлэлтийг багшийн хичээлд ажиглалт хийх замаар үнэлэх бөгөөд 6 хүртэл бүлэгтэй цэцэрлэгийн багшийг 100 хувь, түүнээс дээш бүлэгтэй цэцэрлэгийн нийт багшийн 50 хувь, 10 хүртэл багштай сургуулийн багшийг 100 хувь, түүнээс дээш багштай сургуулийн нийт багшийн 20-30 хувийг тус тус хамруулна.

2.5. Багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч нь шалгуур үзүүлэлтийн дагуу асуулга /хавсралт/-ыг үнэн зөв, бодитой бөглөнө.

2.6. Үнэлгээний баг нь хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явц, хүүхэд хоцрогдолгүй суралцахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр сургалтын байгууллагаас эцэг эх, асран хамгаалагчдын дунд зохион байгуулдаг ажил, мэдээлэл, зөвлөгөө тэдгээрийн үр дүн, цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа болон шийдвэр гаргахад эцэг эх, асран хамгаалагч оролцох тэгш боломжоор хангагдсан байдлын талаар эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг цэцэрлэгт 30 хувь, сургуульд 10-20 хувийг тус тус хамруулан асуулга авна.

2.7. Суралцагч, эцэг эх, асран хамгаалагчаас мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг үнэлгээний багт ажиллаж байгаа суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл хариуцан зохион байгуулна.

2.8. Багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчаас цуглуулсан мэдээлэл, энэ журмын 2.4-т заасан хичээл, үйл ажиллагааны ажиглалт нь өөрийн үнэлгээний дүгнэлт гаргах, хөндлөнгийн үнэлгээний баталгаажуулалт хийх суурь мэдээлэл болно.

2.9. Багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчаас цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шалгуур үзүүлэлт бүрийг үнэлэх, тайлан боловсруулах, үр дүнг танилцуулах ажлыг энэ журмын 2.1-т заасан баг хариуцна.

2.10. Өөрийн үнэлгээ хийхэд 3-аас доошгүй сарын хугацаа зарцуулах бөгөөд жил бүрийн 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор дууссан байна.

2.11. Үнэлгээний багийн ажиллах нөхцөл боломжийг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал бүрдүүлнэ.

## Гурав. Хөндлөнгийн үнэлгээний зохион байгуулалт

3.1. Хөндлөнгийн үнэлгээг нутгийн захиргаа, мэргэжил, арга зүйн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 3-5 хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэх бөгөөд багийн бүрэлдэхүүнийг аймаг, нийслэлийн боловсролын газрын даргын тушаалаар томилно.

3.2. Хөндлөнгийн үнэлгээнд тухайн хичээлийн жилд хамрагдах цэцэрлэг, сургуулийн нэрсийг аймаг, нийслэлийн боловсролын газрын даргын тушаалаар батлах, тухайн оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор тухайн цэцэрлэг, сургуульд тус тус мэдэгдэнэ.

3.3. Хөндлөнгийн үнэлгээнд хамрагдах мэдэгдэл хүлээн авсан цэцэрлэг, сургууль өөрийн үнэлгээний тайлан, энэ журмын хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлтийг хангасан болохыг нотлох баримт бичгийг тухайн оны 9 дүгээр сарын сарын 20-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн боловсролын газарт хэвлэмэл хэлбэрээр хүргүүлнэ.

3.4. Хөндлөнгийн үнэлгээний баг тухайн цэцэрлэг, сургууль дээр ажлын 5-аас илүүгүй хоног ажиллана.

3.5. Хөндлөнгийн үнэлгээг тухайн оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хийж дууссан байна.

3.6. Үнэлгээний баг нь өөрийн үнэлгээний тайлан, энэ журмын 1.7-д заасан баримт бичиг, материалтай танилцаж дүн шинжилгээ хийх, хичээл ажиглах, цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааны талаар сум, дүүргийн Засаг дарга, багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл болон цэцэрлэг, сургуулийн удирдлагын багтай уулзалт, ярилцлага хийх зэрэг ажлыг зохион байгуулна.

3.6.1. Хичээл, үйл ажиллагааны зохион байгуулалтын шалгуур үзүүлэлтийг үнэлэх ажиллагаанд 6 хүртэл бүлэгтэй цэцэрлэгийн нийт багшийн 50 хувь, түүнээс дээш бүлэгтэй цэцэрлэгийн нийт багшийн 30 хувь, 10 хүртэл багштай сургуулийн нийт багшийн 50 хувь, түүнээс дээш багштай сургуулийн нийт багшийн 10-20 хувийг тус тус хамруулна.

3.7. Сургалтын үр дүнг үнэлэхэд цэцэрлэгийн хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээ, суралцагчийн сурлагын амжилтын хичээлийн жилийн эцэс, анги дэвших болон улсын шалгалтын дүнд хийсэн шинжилгээ, Боловсролын үнэлгээний төвөөс үндэсний хэмжээнд зохион байгуулсан сургуульд батлагдсан байдал, чанарын үнэлгээний судалгааг тус тус ашиглах бөгөөд шаардлагатай гэж үзвэл суралцагчдаас шалгалт авч болно.

3.8. Энэ журмын 3.6, 3.7-д заасан үйл ажиллагааны үр дүн нь хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт гаргах нотолгоо болно.

3.9. Хөндлөнгийн үнэлгээгээр тухайн цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааны онцлог, хичээл, сургалтын үр дүн, сайн туршлагыг тус тус илрүүлэн, үйлчилгээний чанар, үр ашгийг сайжруулахад нэн тэргүүнд анхаарах шаардлагатай асуудлыг тодорхойлно.

3.10. Хөндлөнгийн үнэлгээнд энэ журмын 5.4.2-д заасны дагуу дахин хамрагдах тохиолдолд цэцэрлэг, сургууль өмнө хийгдсэн хөндлөнгийн үнэлгээний үр дүнгээр анхаарал хандуулах шаардлагатай гэж үзсэн асуудлын хэрэгжилтийг үнэлгээ дахин хийхээс өмнө аймаг, нийслэлийн боловсролын газарт тайлагнана.

3.11. Хөндлөнгийн үнэлгээний баг нь энэ журмын 3.6, 3.7-д заасан баримт бичиг, материалаас гадна нэмэлт баримт бичиг, материалыг цэцэрлэг, сургуулиас шаардахгүй.

**Дөрөв. Үнэлгээний шалгуур үзүүлэлт**

4.1. Цэцэрлэгийн үйл ажиллагааг энэ журмын 1 дүгээр хавсралт, сургуулийн үйл ажиллагааг журмын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлт үзүүлэлт үзүүлэлтээр тус тус үнэлнэ.

4.2. Энэ журмын хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлт бүрийг 3, 2, 1, 0 оноогоор дараах аргачлалыг баримтлан үнэлнэ:

4.2.1. тухайн шалгуур үзүүлэлтэд тусгагдсан бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны зохицуулалт, зохион байгуулалт бүрэн хийгдсэн, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ тогтмолжсон, бодит үр дүн гарсан бол 3 оноо;

4.2.2. тухайн шалгуур үзүүлэлтэд тусгагдсан бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны зохицуулалт, зохион байгуулалт хийгдсэн, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ тогтмолжоогүй, үр дүн тогтвортой биш бол 2 оноо;

4.2.3. тухайн шалгуур үзүүлэлтэд тусгагдсан бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны зохицуулалт, зохион байгуулалт хангалтгүй хийгдсэн, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ тодорхой бус, үр дүн гараагүй бол 1 оноо;

4.2.4. тухайн шалгуур үзүүлэлтэд тусгагдсан бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны зохицуулалт, зохион байгуулалт хийгдээгүй буюу зарим үйл ажиллагаа хийгдсэн ч үр дүнгүй бол 0 оноо.

4.3. Хичээл, үйл ажиллагааны зохион байгуулалтын шалгуурыг үнэлэхэд ажиглалтад хамрагдсан багш нарт өгсөн онооны арифметик дундажаар тооцно.

4.4. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд өгсөн нийт онооны нийлбэрийг хувьд шилжүүлж дараах үнэлгээ өгнө:

95 ба түүнээс дээш хувьтай бол "үлгэр жишээ үйл ажиллагаатай";

80-94 хувьтай бол "хэвийн үйл ажиллагаатай";

60-79 хувьтай бол "дундаж үйл ажиллагаатай";

0-59 хувьтай бол "дэмжлэг шаардлагатай".

**Тав. Үнэлгээний тайлан, үр дүн танилцуулах**

5.1. Энэ журмын 2.1, 3.1-т заасан үнэлгээний баг холбогдох баримт, нотолгоонд тулгуурлан үнэлгээний тайлан бичиж, үнэлгээний багийн гишүүдээр баталгаажуулна.

5.2. Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний тайланд цэцэрлэг, сургуулийн товч мэдээлэл, үнэлгээ хийсэн баг, үнэлгээний арга зүй, шалгуур үзүүлэлт бүрийг хангаж буй эсэхийг нотлох баримт, тавьсан зорилгодоо хүрч буй эсэх талаарх дүн, дүгнэлт, үйл ажиллагааны давуу болон сул тал, үйлчилгээний чанарт гарсан ахиц өөрчлөлт, хүндрэл бэрхшээл, цаашид байгууллагын менежмент, багшлах, суралцах үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулахад нэн тэргүүнд анхаарах асуудлын талаар тус тус тусгана.

5.3. Өөрийн үнэлгээний баг үнэлгээний дүн, дүгнэлтээ сургалтын байгууллагын захиргааны зөвлөлийн хуралд жил бүрийн 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор танилцуулж, цэцэрлэг, сургуулийн удирдлагад хүлээлгэн өгнө.

5.3.1. Сургалтын байгууллагын удирдлага үнэлгээний дүн, дүгнэлтийг цэцэрлэг, сургуулийн зөвлөл, багш нарын зөвлөл болон суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчид жил бүрийн 9 дүгээр сарын 5-ны өдрийн дотор танилцуулна.

5.3.2. Өөрийн үнэлгээний тайлан нь цэцэрлэг, сургуулийн тухайн оны үйл ажиллагааны тайлангийн салшгүй хэсэг байна.

5.4. Хөндлөнгийн үнэлгээний баг нь цэцэрлэг, сургуулийн үйлчилгээний чанар, үр дүнд өгсөн үнэлгээ, дүгнэлтийг үнэлгээний ажил дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор аймаг, нийслэлийн боловсролын газрын арга зүйн зөвлөлд танилцуулна.

5.4.1. Хөндлөнгийн үнэлгээний дүн, дүгнэлтийг сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх ажлыг аймаг, нийслэлийн боловсролын газар хариуцна.

5.4.2. Хөндлөнгийн үнэлгээгээр өөрийн үнэлгээний дүн, дүгнэлт бодит бус болох нь нотлогдох тохиолдолд аймаг, нийслэлийн боловсролын газраас тухайн цэцэрлэг, сургуульд өөрийн үнэлгээ дахин хийх чиглэл өгнө.

**Зургаа. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө боловсруулах**

6.1 Цэцэрлэг, сургуулийн удирдлага өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнг байгууллагын үйл ажиллагаагаа сайжруулахад ашиглана.

6.2 Үнэлгээний дүн, дүгнэлтээр цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд нэн тэргүүнд сайжруулах шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг хамарсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

6.3 Энэ журмын 6.2-т заасан төлөвлөгөөг багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой боловсруулж хэрэгжүүлнэ.

6.4 Хөндлөнгийн үнэлгээний ажил эхлэхийн өмнө сүүлийн 2-3 жилийн өөрийн үнэлгээний үр дүнд боловсруулсан байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөний биелэлтийг гаргах, хамт олонд тайлагнах ажлыг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал хариуцна.

6.5 Цэцэрлэг, сургууль нь үнэлгээний үр дүнд тулгуурлан байгууллага хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө, дотоод журам болон холбогдох бусад дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой зохион байгуулна.

6.6 Хөндлөнгийн үнэлгээний дүн, дүгнэлтэд үндэслэн тухайн цэцэрлэг, сургуульд зөвлөн туслах ажлыг аймаг, нийслэлийн боловсролын газар хариуцна.

**Долоо. Бусад**

7.1. Хөндлөнгийн үнэлгээ хийхтэй холбогдох зардлыг аймаг, нийслэлийн боловсролын газар хариуцна.

7.2. Хөндлөнгийн үнэлгээний дүнгээр цэцэрлэг, сургуулийг эрэмбэлэх, байр эзэлүүлэхийг хориглоно.

7.3. Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулсантай холбогдох баримт бичгийг хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт хадгална.

—000—

Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмын хоёрдугаар хавсралт

## ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

| Чиглэл | Үзүүлэлт | Шалгуур | | Оноо (0.1.2.3) |
|---|---|---|---|---|
| 1. Байгууллагын менежмент, удирдлагын манлайлал (30оноо) | 1.1 Байгууллагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн | 1.1.1 | Байгууллагын үнэт зүйл, эрхэм зорилгыг сургуулийн өмнөх насны хүүхдийн эрэлт хэрэгцээг харгалзан бодитой тодорхойлж, хэрэгжилтийг хангаж, үнэлгээ хийдэг байдал | 1-3 |
| | | 1.1.2 | Цэцэрлэг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны төлөвлөлтийг үнэт зүйл, эрхэм зорилготой уялдуулан, нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн, хэрэгжилтийн байдлаар тодорхойлон боловсруулж, хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүгнэсэн байдал | 1-3 |
| | | 1.1.3 | Тухайн хичээлийн жилийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөг урт, дунд, богино хугацааны төлөвлөлттэй нийцүүлэн хүүхэд, эцэг эх, багш, ажилтны хэрэгцээ, шаардлагыг тусгаж боловсруулж, хэрэгжүүлэн, тухай бүр дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцон ажиллаж буй байдал | 1-3 |
| | | 1.1.4 | Цэцэрлэгийн үйл ажиллагааг зохицуулах байгаа дүрэм, журмыг хамтын оролцоотой боловсруулж, хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийж ажилладаг байдал | 1-3 |
| | | 1.1.5 | Цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааны тогтвортой байдал, ажлын үр дүн | 1-3 |
| | 1.2 Удирдлагын манлайлал | 1.2.1 | Байгууллагын удирдах ажилтны мэдлэг, ур чадвар, арга барил нь баталгаатай болон суралцахуйд, ажилтан тэргүүлэх манлайлагч, хамт олныг багийн манлайлалд уриалан чиглүүлдэг байдал | 1-3 |
| | | 1.2.2 | Эрхлэгч, арга зүйч нь байгууллагын үйл ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийж, чанар үр нөлөөг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгийг багш ажилтанд өгч ажилладаг байдал | 1-3 |
| | | 1.2.3 | Цэцэрлэгийн удирдлага нь ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, ажлын арга барил, үг хэллэг, харилцаа, хандлага, биеэр үлгэрлэн манлайлдаг байдал | 1-3 |
| | | 1.2.4 | Байгууллагын соёл төлөвшүүлэх, хамт олны зөрчилгүй уур амьсгалыг бүрдүүлэх талаар цэцэрлэгийн удирдлагын зүгээс төлөвлөн хэрэгжүүлж буй ажил, үр дүн | 1-3 |
| | 1.3 Төсөв, санхүүгийн менежмент | 1.3.1 | Төсөв санхүүгийн төлөвлөлт, зарцуулалт нь эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтанд ил тод, нээлттэй байдал | 1-3 |
| | | 1.3.2 | Баталгаажсан төсөв, үйл ажиллагааны орлого, хандив тусламж, цэцэрлэг хөгжүүлэх сангийн хөрөнгийг үр өгөөжтэй зарцуулсан байдал | |
| 2. Хүний нөөцийн менежмент (27 оноо) | 2. 1 Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт | 2.1.1 | Хүний нөөцийн хөгжлийн болон дунд хугацааны бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд хийсэн дүн шинжилгээ | 1-3 |
| | | 2.1.2 | Багш, ажилтныг албан тушаалд томилох, чөлөөлөхөд хууль, журмыг баримталдаг, сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулсан байдал | 1-3 |
| | | 2.1.3 | Багш, ажилтныг тогтвор суурьшилтай ажиллах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, мэргэжлийн багшийн хангамж | 1-3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 2.1.4 | Багш ажилтнуудад албан тушаалын зорилго, зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх орчин нөхцөлийг хангасан байдал, тэдний бүтээлч санааг дэмжсэн, ажлын ачааллыг зохицуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн | 1-3 |
| | | 2.1.5 | Багш, ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх бүх арга хэлбэр нь хамт олныг хөгжүүлэх, ажлын чанар үр дүнг сайжруулахад чиглэсэн байдал түүний хэрэгжилт үр дүн | 1-3 |
| | 2.2 Багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, ёс зүй | 2.2.1 | Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг тэдний хөгжих хэрэгцээний судалгаанд үндэслэн төлөвлөж, хэрэгжүүлдэг байдал, үр дүн | 1-3 |
| | | 2.2.2 | Багш, ажилтан ажлын байран дээр мэргэжил дээшлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж, хамтран суралцах, харилцан туршлага солилцох, бие даан мэргэжил дээшлүүлэхэд дэмжих арга хэлбэрийг ашиглан үр дүнд хүрсэн байдал | 1-3 |
| | | 2.2.3 | Мэргэжил дээшлүүлэх сургалтын үзэл санааг түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бүрдүүлж, үр дүн нь сургалтын чанар, ажил үйлчилгээнд хэрхэн нөлөөлж буйд дүн шинжилгээ хийж буй байдал | 1-3 |
| | | 2.2.4 | Сургалтын орчинд багш, ажилтнууд ёс суртахууны хэм хэмжээг сахиж, ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж буй байдал | 1-3 |
| 3. Сургалтын нөхцөлбүрдлийн менежмент (66 оноо) | 3.1 Өдрийн дэглэмийн төлөвлөлт, хэрэгжилт | 3.1.1 | Өдрийн дэглэмийг цэцэрлэг, хүүхдийн нас, хөгжлийн онцлогт нийцүүлэн, улирал цаг үүрийн нөхцөлийг харгалзан уян хатан, үйл ажиллагаа хоорондын уялдааг хангаж төлөвлөсөн байдал | 1-3 |
| | | 3.1.2 | Өдрийн дэглэмийг цагийн хуваарийн дагуу мөрдөж хэвшсэн эсэх, түүнд хяналт тавьж хэрэгжилтийг хангаж буй байдал | 1-3 |
| | 3.2 Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт | 3.2.1 | Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, үнэлэхэд Заах аргын нэгдэл, багш нар хамтран багийн зарчмаар ажиллаж хэвшсэн байдал | 1-3 |
| | | 3.2.2 | Багшийн арга зүйн сан бүрдүүлж, баяжуулан хичээл, хөгжүүлэх үйл ажиллагаандаа хэрэглэдэг байдал | 1-3 |
| | | 3.2.3 | Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн онцлог, хэрэгцээ сонирхлыг харгалзан, адил тэгш оролцоог хангаж төлөвлөж, үр дүнтэй хэрэгжүүлж буй байдал | 1-3 |
| | | 3.2.4 | Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг сургалтын олон хэлбэрээр төлөвлөн хэрэгжүүлж буй байдал | 1-3 |
| | | 3.2.5 | Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны зорилго нь нийгэмшихүйн хөгжлийг дэмжсэн, уламжлалт ёс заншил, эх оронч үзэл хандлагатай бие хүнийг төлөвшүүлэхэд чиглэсэн байдал | 1-3 |
| | | 3.2.6 | Хүүхдийн гүйцэтгэх үйл, даалгавар нь хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны зорилготой нийцэж буй байдал | 1-3 |
| | | 3.2.7 | Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн боловсролын онцлогт нийцсэн орчинг бүрдүүлж, тэдэнд ээлтэй дэмжлэгийг хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж буй байдал | 1-3 |
| | | 3.2.8 | Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлж, дүнгээ түүнд үндэслэн төлөвлөлтийг сайжруулж буй байдал | 1-3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 3.3 Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт | 3.3.1 | Анги танхимд багш-хүүхэд, хүүхэд-хүүхдийн нээлттэй, хүндэтгэлтэй харилцааг эрхэмлэж буй байдал | 1-3 |
| | | 3.3.2 | Багшийн арга зүй нь хүүхдийн мэдэх, хийж бүтээх оролцоог дэмжсэн, эрэл хайгуул хийлгэсэн, алдаа дээрээ суралцах боломж олгосон байдал | 1-3 |
| | | 3.3.3 | Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг нээлттэй чөлөөтэй, сонирхолтойгоор зохион байгуулж, хүүхэд бүрийн оролцоог дэмжиж буй байдал | 1-3 |
| | | 3.3.4 | Багш хүүхдийн зөв үйлдлийг дэмжиж, буруу үйлдлийг засаж, нөхцөл байдалд тохируулан эерэг хариу мэдээлэл өгч буй байдал | 1-3 |
| | | 3.3.5 | Дасгал даалгавар, энгийн туршилтыг өөрийн мэдлэг, бодит амьдрал, хэрэглээтэй холбож буй байдал | 1-3 |
| | | 3.3.6 | Хүүхэд бусадтай хамтран ажиллах, дасгал даалгавар гүйцэтгэх явцад бусдыг хүндэтгэх, туслах, хүлээцтэй хандах, дүрэм журмыг биелүүлэх, сэтгэл хөдлөлөө зохицуулах зэрэг үйлдлийг дэмжиж буй байдал | 1-3 |
| | | 3.3.7 | Сургалтын хэрэглэгдэхүүн нь хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны агуулгад нийцсэн, хүртээмжтэй, хүүхэд бүрд сонголт хийх боломж олгосон байдал | 1-3 |
| | 3.4 Хүүхдийн хөгжлийн үнэлгээ, үр дүнд хийсэн шинжилгээ | 3.4.1 | Үнэлгээний арга, хэрэгслийг ашиглан хүүхдийн суралцах арга барилын онцлог, хандлага зэргийн бодит байдлыг илрүүлж дүн шинжилгээ хийж баримтжуулж буй байдал | 1-3 |
| | | 3.4.2 | Явцын үнэлгээнд түшиглэн үр дүнгийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан байдал | 1-3 |
| | | 3.4.3 | Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдалд үнэлгээ хийж, сургуулийн бага ангийн багш нартай хамтран ажиллаж буй байдал | 1-3 |
| | | 3.4.4 | Хүүхдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэх дугуйлан болон бусад үйл ажиллагаа зохион байгуулж, гарсан үр дүнг хүүхдийн хөгжлийн үнэлгээнд харгалзан тооцдог байдал | 1-3 |
| | | 3.4.5 | Хүүхдийн хөгжил, төлөвшлийн онцлог илэрсэн байдлыг илрүүлэх, үнэлэх, ахиц талаар эцэг эхэд мэдээлэл өгөх, хамтран ажиллахдаа хүүхдийн эрхийг дээдэлдэг байдал | 1-3 |
| 4. Сургалтын орчин, үйлчилгээ хүүхдэд ээлтэй байдал (30 оноо) | 4.1 Хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг | 4.1.1 | Хүүхдэд эрүүл аюулгүй дадал хэвшил олгох, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажил, түүний үр дүнг тооцдог байдал | 1-3 |
| | | 4.1.2 | Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, усан хангамжийн эрүүл аюулгүй шаардлага хангасан орчныг бүрдүүлж, чанар, аюулгүй байдалд хяналт тогтмол хийж, үр дүнг тооцдог байдал | 1-3 |
| | | 4.1.3 | Хүүхэд хамгааллын бодлогыг үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж буй байдал, үр дүн | 1-3 |
| | | 4.1.4 | Цэцэрлэгт шилжин элссэн болон сургуульд элсэн суралцах хүүхдийн шинэ орчин, үйл ажиллагаанд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж буй байдал, үр дүн | 1-3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 4.2 Орчны аюулгүй байдал | 4.2.1 | Гадна орчин дахь эд зүйлс, биеийн тамир, тоглоомын талбайг хүүхдэд зохистой, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн байдлаар өнгө үзэмжтэй, аюулгүй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материал ашиглан хийсэн, байгаль экологид зохистой, орчны стандартын шаардлагыг хэрэгжүүлж буй байдал | 1-3 |
| | | 4.2.2 | Барилга байгууламж, бүлгийн өрөө, ариун цэврийн өрөө, хангамж, биеийн тамирын танхим, гал тогоонд тавигдах стандарт шаардлагыг хэрэгжүүлж буй байдал | 1-3 |
| | | 4.2.3 | Бүлгийн сургалтын тавилга, хэрэгсэл, тоглоом нь хүртээмжтэй, хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон, олон хувилбартай, сонголттой, орчны стандартын шаардлагыг хэрэгжүүлж буй байдал | 1-3 |
| | | 4.2.4 | Галын аюулгүй байдал, ариун цэврийн байгууламж, хүүхэд тоглох тоглоомын хэрэгсэл, гэр цэцэрлэгийн аюулгүй байдлыг хангаж буй байдал | 1-3 |
| | | 4.2.5 | Онцгой байдал, гамшиг осол, аюулт үзэгдэл болох үед авах хариу арга хэмжээ, аюулын горим, орчин нөхцөлийг бүрдүүлсэн байдал | 1-3 |
| | | 4.2.6 | Орчны аюулгүй байдалд байнгын хяналт үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээг тогтмол хийдэг, энэ талаар хэрэгжүүлсэн ажлын үр дүн | 1-3 |
| 5. Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэл (18 оноо) | 5.1 Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн хамтын ажиллагаа | 5.1.1 | Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн сэтгэл ханамжийг тандан судалж, сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг төлөвлөж хэрэгжүүлэхэд тэдний саналыг тусган шийдвэрлэсэн байдал | 1-3 |
| | | 5.1.2 | Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн хөгжил, төлөвшил, хамгааллын талаар хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой болгож, байнгын оролцоог хангасан байдал | 1-3 |
| | | 5.1.3 | Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд цэцэрлэгийн үйл ажиллагаа, орчинтой танилцах, хяналт тавих, мэдээлэл авах боломжийг хангасан байдал | 1-3 |
| | | 5.1.4 | Эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байдал | 1-3 |
| | 5.2 Нийгмийн түншлэл | 5.2.1 | Олон нийтийн байгууллага болон гэрээт байгууллагатай түншлэн ажилладаг байдал, нийтэд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа, үр дүн | 1-3 |
| | | 5.2.2 | Цэцэрлэгийн орчин, үйл ажиллагааг сайжруулахад орон нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн дэмжлэг, түүний үр дүн, хариу тайлагнадаг байдал | 1-3 |
| | | | **Авбал зохих нийт оноо** | **174** |

---oOo---

Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмын хоёрдугаар хавсралт

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

| Чиглэл | Үзүүлэлт | Шалгуур | | Оноо (0,1,2,3) |
|---|---|---|---|---|
| 1. Байгууллагын менежмент, удирдлагын манлайлал (36 оноо) | 1.1 Байгууллагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн | 1.1.1 | Сургуулийн үнэт зүйл, эрхэм зорилгыг оролцогч талуудын оролцоотой бодитой тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулж, үнэлгээ хийдэг байдал | 0-3 |
| | | 1.1.2 | Сургууль хөгжүүлэх урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлтийг нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн, байгууллагын үнэт зүйл, эрхэм зорилгод нийцүүлэн хэрэгжихүйц байдлаар боловсруулсан, хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийсэн байдал | 0-3 |
| | | 1.1.3 | Хичээлийн жилийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөг багш, ажилтан болон үйлчлүүлэгчийн хэрэгцээ, шаардлага, хүлээлтийг тооцож боловсруулсан, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээ авсан байдал | 0-3 |
| | | 1.1.4 | Сургуулийн үйл ажиллагааг зохицуулах байгаа дүрэм, журмыг хамтын оролцоотой боловсруулсан, тэдгээрийн хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийж ажилладаг байдал | 0-3 |
| | 1.2. Удирдлагын манлайлал | 1.2.1 | Багш, ажилтан болон суралцагчийн амжилт гаргахад нөлөөлөхүйц мэдлэг, ур чадвар, туршлага бүхий сургуулийн захирал, удирдлагын баг сургуулийг удирдаж байгаа эсэх | 0-3 |
| | | 1.2.2 | Бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргах үйл ажиллагаанд багш, ажилтан, суралцагч, олон нийтийн оролцоог хангахад удирдлагын багаас хэрэгжүүлдэг арга хэмжээ, үр дүн | 0-3 |
| | | 1.2.3 | Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, багшлах болон сурах үйл ажиллагааны чанар, үр нөлөөг сайжруулахад сургуулийн захирал, сургалтын менежерийн оролцоо, багшид үзүүлж буй дэмжлэг, туслалцаа, үр дүн | 0-3 |
| | | 1.2.4 | Сургуулийн захирал, удирдлагын багаас хүүхдийн сурах болон хөгжих үйл явцыг дэмжих, тэгш хамран сургах соёл төлөвшүүлэх талаар хийж буй ажил, үр дүн | 0-3 |
| | | 1.2.5 | Байгууллагын соёл төлөвшүүлэх, хамт олны эерэг уур амьсгал бүрдүүлэх талаар сургуулийн захирал, сургалтын менежерээс төлөвлөн хэрэгжүүлдэг ажил, үр дүн | 0-3 |
| | | 1.2.6 | Сургуулийн удирдлага нь ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, ажлын арга барил, үг хэллэг, харилцаа, хандлага, биеэр үлгэрлэн манлайлдаг байдал | 0-3 |
| | 1.3. Төсөв, санхүүгийн менежмент | 1.3.1 | Батлагдсан төсөв, өөрийн үйл ажиллагааны орлого, хандив, тусламж, сургууль хөгжүүлэх сангийн хөрөнгө, түүний зарцуулалт, үр ашигтай байдал | 0-3 |
| | | 1.3.2 | Батлагдсан төсөв, өөрийн үйл ажиллагааны орлого, хандив, тусламж, сургууль хөгжүүлэх сангийн хөрөнгө, түүний зарцуулалт болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг ил тод, нээлттэй мэдээлдэг байдал | 0-3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2. Хүний нөөцийн менежмент /30 оноо/ | 2.1. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт | 2.1.1 | Хүний нөөцийн хөгжлийн болон дунд хугацааны бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилт, үр дүнд хийсэн шинжилгээ | 0-3 |
| | | 2.1.2 | Багш, ажилтныг албан тушаалд томилох, чөлөөлөхөд баримталдаг журам, тавих шаардлага, шалгуур үзүүлэлт, түүний хэрэгжилт, сонгон шалгаруулах үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал | 0-3 |
| | | 2.1.3 | Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхи бүхий мэргэжлийн багшаар хангагдсан байдал | 0-3 |
| | | 2.1.4 | Шинээр томилогдсон багш, ажилтныг ажлын байранд нь дасан зохицоход туслах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлдэг үйл ажиллагаа, үр дүн | 0-3 |
| | | 2.1.5 | Багш, ажилтны тогтвортой байдал /сүүлийн 3 жилд шилжих хөдөлгөөнд орсон багш, ажилтны тоо, шалтгаан/ | 0-3 |
| | 2.2. Багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, ёс зүй | 2.2.1 | Сургалтын хөтөлбөр болон багшийн хэрэгцээг тооцон багш, ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг ажлын байранд нь дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа, түүний залгамж чанар, үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээ | 0-3 |
| | | 2.2.2 | Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тооцсон байдал | 0-3 |
| | | 2.2.3 | Мэргэжил дээшлүүлэх төлөвлөсөн сургалтад оролцогч сургалтын үр дүнг бусдад түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бүрдсэн байдал | 0-3 |
| | | 2.2.4 | Мэргэжил дээшлүүлэх ажлын үр дүн нь сургалтын чанарт хэрхэн нөлөөлж буйг үнэлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, үр дүн | 0-3 |
| | | 2.2.5 | Анги танхимд болон сургуулийн орчинд багш, ажилтан ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, үг хэллэг, харилцаа, хандлага, биеэр үлгэрлэн манлайлдаг байдал | 0-3 |
| 3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн /84 оноо/ | 3.1. Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх менежмент | 3.1.1 | Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа суралцагчийн суурь, мэдлэг, чадвар, хандлагатай байдал, хэрэгцээ, сонирхлыг харгалзан, адил тэгш оролцоог хангасан байхаар төлөвлөж, үр дүнтэй зохион байгуулдаг байдал | 0-3 |
| | | 3.1.2 | Хичээл, сургалтын үйл ажиллагааг заах арга, нөхцөл, технологи, багшаар хамтран хэлэлцэж, хичээл хоорондын агуулгын залгамж холбоог хангах төлөвлөдөг байдал | 0-3 |
| | | 3.1.3 | Сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг хамтран бэлтгэх, сонгох, орон нутгийн материал, жишээ баримтыг түлхүү ашиглаж хичээлийг амьдрал, практик хэрэглээтэй холбон явуулах үйл ажиллагаа тогтмолжсон байдал | 0-3 |
| | | 3.1.4 | Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх даалгаврын сантай бүрдүүлсэн, түүний хэрэглээ, сайжруулж, баяжуулдаг байдал | 0-3 |
| | | 3.1.5 | Суралцагч өөрийн зохих түвшинд хугацаандаа хүрч байгаа байдалд хийсэн шинжилгээ, түүний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн | 0-3 |
| | 3.2. Хичээл зохион байгуулалт | 3.2.1 | Багшийн зүгээс бүх суралцагчдад хүндэтгэлтэй хандах уур амьсгал бүрдүүлсэн байдал | 0-3 |
| | | 3.2.2 | Жендэрээр ялгаварлан хандлага гаргахгүй байх, суралцагчийн зөв үйлдлийг дэмжих, буруу үйлдлийг засах буй байдал | 0-3 |
| | | 3.2.3 | Хичээлийн зорилгыг тодорхой болгон танилцуулж, хичээл дээр хийх үйл ажиллагааг бүрэн ойлгуулж буй байдал | 0-3 |
| | | 3.2.4 | Шинжлэх ухааны нэр томьёо, үг хэллэгийг суралцагчийн нас, сэтгэхүйд тохируулан оновчтой, товч, тодорхой сонгон хэрэглэж буй байдал | 0-3 |
| | | 3.2.5 | Хичээл дээр ажиллах бүх дасгал, даалгавар, үйл ажиллагаа нь хичээлийн зорилгод нийцсэн байдал | 0-3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 3.2. Хичээл зохион байгуулалт | 3.2.6 | Хичээлийн явцад хүүхдийн онцлогийг харгалзсан, хөгжлийн ялгааг дэмжсэн сургалтын идэвхтэй арга хэрэглэж, хамтын оролцоог хангаж буй байдал | 0-3 |
| | | 3.2.7 | Суралцах бэрхшээлтэй, сурлагын хоцрогдолтой эсхүл чадварлаг суралцагчийн хэрэгцээг тооцсон ялгаатай арга техник хэрэглэж байдал | 0-3 |
| | | 3.2.8 | Дасгал, даалгавар, шийдвэрлэх асуудал, туршилт, дадлага ажлыг өмнөх мэдлэг, бодит амьдрал, хэрэглээтэй холбож буй байдал | 0-3 |
| | | 3.2.9 | Бие даан болон бүлгээр ажиллах явцад ажиглалт хийж, тэдний ойлголтыг илрүүлэн нэмэлт тайлбар хийж, шаардлагатай дэмжлэгийг цаг нь үзүүлж буй байдал | 0-3 |
| | | 3.2.10 | Суралцагчдад сонголт хийх, өөрийгөө илэрхийлэх, асуух боломж олгох замаар бие даасан байдлыг хөгжүүлж буй байдал | 0-3 |
| | | 3.2.11 | Нээлттэй/хаалттай хариулт шаардсан асуулт тавих, дүн шинжилгээ хийх, дасгал ажиллуулах замаар суралцагчдын эргэцүүлэн бодох, бүтээлч сэтгэлгээг дэмжиж буй байдал | 0-3 |
| | | 3.2.12 | Дасгал, даалгавар, туршилт, дадлага ажлыг хийх гүйцэтгэх зааварчилгааг суралцагчдад ойлгомжтой тайлбарлаж буй байдал | 0-3 |
| | | 3.2.13 | Багш суралцагчдын сайн гүйцэтгэлийг олж тогтоон урамшуулж, хандлага, урам зоригийг үнэлдэг | 0-3 |
| | | 3.2.14 | Суралцагчид өөрийгөө болон бусдыг үнэлэх, бие биедээ туслах үйлийг дэмжиж буй байдал | 0-3 |
| | | 3.2.15 | Суралцагч тухайн агуулгыг ойлгосон эсэхийг богино хугацаанд илрүүлэх арга техникийг оновчтой сонгон хэрэглэж буй байдал | 0-3 |
| | | 3.2.16 | Асуудал шийдвэрлэх, хамтран ажиллах явцад бусдын санаа бодлыг хүндэтгэх, сэтгэл хөдлөлөө зохицуулах үйлийг дэмжиж буй байдал | 0-3 |
| | | 3.1.17 | Хичээлд хэрэглэж буй технологи, сургалтын хэрэглэгдэхүүн нь хөтөлбөрийн агуулга, суралцагчийн насны онцлогт нийцсэн, суралцах идэвх, сонирхол, бүтээлч үйлийг дэмжсэн байдал | 0-3 |
| | 3.3. Сургалтын амжилтын үнэлгээ, үр дүнд хийсэн шинжилгээ | 3.3.1 | Сургуулийн хэмжээнд суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний агуулга, арга хэлбэр, хугацааг тодорхойлсон нэгдсэн төлөвлөгөө, түүний хэрэгжилт | 0-3 |
| | | 3.3.2 | Оношлох, явцын болон эцсийн үнэлгээ /түвшин тогтоох, бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцсийн, анги дэвших болон улсын шалгалт/-ийн үр дүнд хийсэн шинжилгээ, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ахиц, өөрчлөлт /хичээл бүрээр/ | 0-3 |
| | | 3.3.3 | Сургуулийн хэмжээнд тааруу үнэлгээтэй шалгагдсан сэдэв, агуулгыг суралцагчдад бүрэн эзэмшүүлэхэд багш, заах аргын нэгдлээс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүний үр дүн | 0-3 |
| | | 3.3.4 | Суралцах бэрхшээлтэй суралцагчид нэмэлт туслалцаа үзүүлэх, тэдний онцлогт тохирсон үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлснээр гарсан ахиц, өөрчлөлт | 0-3 |
| | | 3.3.5 | Сургалтын амжилтын өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний сүүлийн 3 жилийн үр дүнд хийсэн шинжилгээ, ахиц өөрчлөлт | 0-3 |
| | | 3.3.6 | Мэргэжлийн байгууллагаас хийсэн хөндлөнгийн үнэлгээний дүн /аймаг, нийслэлийн Боловсролын газар, Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулдаг чанарын үнэлгээ/, түүнд хийсэн шинжилгээ, авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ, үр нөлөө | 0-3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4. Сургалтын орчин, үйлчилгээг хүүхдэд ээлтэй байлгах /45 оноо/ | 4.1. Суралцагчдад үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг | 4.1.1 | Суралцагчдын ирцэд хийсэн шинжилгээ, түүний үр дүнд үндэслэн хичээлд суугаагүй суралцагчдад үзүүлсэн үйлчилгээ, үр дүн | 0-3 |
| | | 4.1.2 | Сургуулийн номын сангийн үйлчилгээний хүртээмж, хамтран байгууллагатай үйл ажиллагаа, үр дүн | 0-3 |
| | | 4.1.3 | Суралцагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх үйлчилгээний бэлэн байдал | 0-3 |
| | | 4.1.4 | Суралцагчдын авьяасыг хөгжүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа, мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлэх үйлчилгээ | 0-3 |
| | | 4.1.5 | Дотуур байранд амьдардаг хүүхдийн сурах, хөгжих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, бага ангийн сурагчдад асаргаа халамж үзүүлдэг байдал | 0-3 |
| | | 4.1.6 | Сургуульд шинээр элсэн болон бага ангиас дунд ангид дэвшин суралцаж буй суралцагчид сургуулийн орчин, сургалтын үйл ажиллагаанд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байдал | 0-3 |
| | | 4.1.7 | Шилжин ирсэн суралцагчдад сургуулийн орчин, үйл ажиллагаанд мөрддөг дүрэм, журам болон аюулгүй ажиллагааны заавар танилцуулах, дасан зохицоход дэмжлэг үзүүлэх зохион байгуулалттай арга хэмжээ авдаг байдал | 0-3 |
| | | 4.1.8 | Суралцагч бүрт чиглэсэн хувийн дэмжлэг, зөвлөгөө үзүүлдэг, санал бодлыг нь сонсож хариу арга хэмжээ авдаг байдал | 0-3 |
| | | 4.1.9 | Сургуулийн орчинд суралцагчид бие биенээ ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, дарамтлах зэрэг үйлдэл гаргахын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн | 0-3 |
| | 4.2. Сургалтын орчны аюулгүй байдал | 4.2.1 | Сургалтын орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах "Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын ерөнхий шаардлага MNS 6782:2019", "Дотуур байрын орчин, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага MNS 6781:2019", "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрын орчны эрүүл ахуйн ерөнхий шаардлага" стандартын хэрэгжилт | 0-3 |
| | | 4.2.2 | Сургалтын орчны аюулгүй байдал, ус, ариун цэврийн байгууламж, үйлчилгээнд үзлэг, шалгалтыг давтамжтай хийх хэвшсэн график, түүний хэрэгжилт, үзлэг, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ | 0-3 |
| | | 4.2.3 | Онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах дадлын горим, галын болон аюулгүйн нөхцөл байдлыг хангаж буй байдал | 0-3 |
| | | 4.2.4 | Суралцагчдын сургуульд ирэх, буцах үеийн аюулгүй байдлыг хангах талаар хийж буй ажлын үр дүн | 0-3 |
| | | 4.2.5 | Хүүхдийн хоол, хүнсний аюулгүй байдал тавих хяналтын систем, авч хэрэгжүүлдэг арга хэмжээ, гарсан өөрчлөлт, шийдвэрлэлт | 0-3 |
| | | 4.2.6 | Сургалтад технологи, сургалтын техник хэрэгсэл, бусад нөөцийг ашиглах боломж бүрдсэн байдал, ашиглалт | 0-3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5. Эцэг эх, олон нийтийн оролцоо, түншлэл /21 оноо/ | 5.1. Эцэг, эх, олон нийтийн хамтын ажиллагаа | 5.1.1 | Хүүхдийн сурах, хөгжих үйлийг дэмжих чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч болон олон нийттэй үр дүнтэй харилцаа тогтоосон байдал | 0-3 |
| | | 5.1.2 | Эцэг эх, асран хамгаалагч болон олон нийтийн санал бодлыг сонсох, харилцах албан ёсны арга хэлбэр, санал, хүсэлт, гомдлын мөрөөр арга хэмжээ хэрэгжүүлсэн, үр дүнг тайлагнадаг байдал | 0-3 |
| | | 5.1.3 | Хүүхдийн хөгжил, төлөвшил, суралцах үйл явц, ахиц амжилтын талаар эцэг эх, асран хамгаалагчдад сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх хуваарь, түүний хэрэгжилтийн байдал | 0-3 |
| | | 5.1.4 | Эцэг, эх, асран хамгаалагч, олон нийт сургуулийн орчин, үйл ажиллагаатай танилцах, хяналт тавих, мэдээлэл авах боломжийг хангасан байдал | 0-3 |
| | 5.2. Нийгмийн түншлэл | 5.2.1 | Сургуулийн орчин, үйл ажиллагааг сайжруулахад орон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн холбоо, иргэдийн дэмжлэг, түүний үр дүн | 0-3 |
| | | 5.2.2 | Гэрээт байгууллагатай хамтран түншлэн ажилладаг, түүний үр дүн | 0-3 |
| | | 5.2.3 | Сургуулийн хамт олноос зохион байгуулж буй нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа, үр дүн | 0-3 |
| **Авбал зохих нийт оноо** | | | | **216** |

--- o0o ---

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр | Дугаар 450 | Улаанбаатар хот

Хоолны зардлын норматив тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Боловсролын тухай хуулийн 40.2, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15.1, 15.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 (хоёр мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр, 24 цагаар ажилладаг, сувиллын болон тусгай цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 3600 (гурван мянга зургаан зуун) төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 (гурван мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдийн үдийн цайны өдрийн зардлыг 900 (есөн зуун) төгрөгөөр, ерөнхий боловсролын тусгай сургуулийн нэг хүүхдийн үдийн хоолны зардлыг 2400 (хоёр мянга дөрвөн зуун) төгрөгөөр тус тус тогтоосугай.

4. Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянах, зарцуулалтыг тооцох байдлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

5. Хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжих, зайлшгүй шаардлагатай илчлэг, шим тэжээлийн шаардлагыг хангасан, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсний бүтээгдэхүүн бэлтгэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих, ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цолмонхүү)-т үүрэг болгосугай.

6. Энэ тогтоолыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хоолны зардлын дундаж норматив батлах тухай" Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолын 1, 2, 4 дэх заалт, 3 дахь заалтын "Ерөнхий боловсролын сургууль..." гэснийг, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2017 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 162 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.БААТАРБИЛЭГ

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
СТАНДАРТЫН БОЛОВСРУУЛАГЧИД ОЛГОСОН ХУВЬ

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 03.080.30

| | |
|---|---|
| Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага | MNS 6781:2019 |
| Secondary school dormitory environment and service. General requirements | |

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

### 1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын орчин нөхцөл, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тогтооно.

### 2 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын үйл ажиллагааг үнэлэх, хяналт тавихад хэрэглэгдэнэ.

### 3 Норматив эшлэл

Энэхүү стандартад холбогдох хууль, дүрэм, журам, норм болон дараах стандартаас эш татсан бөгөөд эдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалаас эш татна. Үүнд:

- MNS 5666:2006, Аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид зайлшгүй байх шаардлагатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн норм;
- MNS 5742:2016, Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага;
- MNS 4990:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрын орчин. Эрүүл ахуйн шаардлага;
- MNS 4946:2013, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага;
- MNS 5682:2006, Авто замын байгууламж. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага;
- MNS 6444:2014, Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 0900:2018, Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ;
- MNS 5390:2004, Цахилгааны галын аюулгүй байдал, ерөнхий шаардлага;
- MNS 6066:2009, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөсөн заавар;
- MNS 6065:2009, Иргэний барилгын төлөвлөлтөд бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага;
- MNS 4115:1991, Барилгын галын аюулгүй байдал. Барилгын материалын нэгдсэн чанар. Тэсвэрлэх шатдаг материалын анги тодорхойлох арга;

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Ангилалтын код: 03.080.30**

| | |
|---|---|
| **Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага** | **MNS 6782:2019** |
| **School environment safety. General requirements** | |

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

### 1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь ерөнхий боловсролын сургууль /цаашид "сургууль" гэх/-ийн гадаад болон дотоод орчинд тавих ерөнхий шаардлагыг тодорхойлж, аюулгүй байдлыг хангахад оршино.

### 2 Хамрах хүрээ

Энэхүү стандартыг бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, нийгмийн түнш, багш, суралцагч, суралцагч, ерөнхий боловсролын асуудал эрхэлсэн төрийн болон орон нутгийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд хэрэглэнэ.

### 3 Норматив эшлэл

Энэхүү стандартад холбогдох хууль, дүрэм, журам, норм болон дараах стандартаас эш татсан бөгөөд эдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалаас эш татна. Үүнд:

- БНбД 08-68, Сургалт хүмүүжлийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм;
- БНбД 66-79, Ерөнхий боловсролын сургууль. Дотуур байрт сургууль;
- MNS CAC RCP 39:2011, Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал;
- БНбД 31.03.03, Олон нийт, иргэний барилга;
- БНбД 30.01.04, Хот тосгоны төлөвлөлт барилгажилт;
- БНбД 41.01.11, Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер;
- БД31-113-11, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт;
- БД 43-101-03, Цахилгаан байгууламжийн дүрэм;
- MNS 6055:2009, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага;
- MNS 4585:2016, Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 6444:2014, Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 0900:2018, Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт;
- MNS 6682:2016, Сурагчийн ширээ ба сандал. Техникийн шаардлага;
- MNS 4990:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага;
- MNS 6924:2018, Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага;

СТАНДАРТЫН БОЛОВСРУУЛАГЧИД ТОГТООСОН ХУВЬ

**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

**Ангилалтын код 03.180; 03.080.39**

| | |
|---|---|
| **Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага** | **MNS 6799:2019** |
| **Environmental hygiene requirements for educational facilities** | |

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн С/58 дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

## 1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь сургалт, хүмүүжлийн орчин /цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байр/ гэх мэт эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг бүрдүүлэх, гадаад болон дотоод орчны хүүхдийн эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын шаардлагыг хангуулахад оршино.

## 2 Хамрах хүрээ

**2.1** Энэхүү стандартыг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны орчны эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад мөрдөнө.

**2.2** Энэхүү стандартыг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны барилга байгууламжийн байршил тогтоох, зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд үндэслэл болгоно.

**2.3** Энэхүү стандартыг төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуульд үйлдвэрлэл, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хяналт тавихад хэрэглэнэ.

## 3 Норматив эшлэл

Энэхүү стандартад холбогдох хууль, дүрэм, журам, норм болон дараах стандартаас эш татсан бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалаас эш татна. Үүнд:

- БНбД 66-88, Сургалт хүмүүжлийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм;
- БНбД 31-03-03, Олон нийт, иргэний барилга;
- БД 31-111-11, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт;
- БНбД 30.01.03, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм;
- БНбД 41.01.1, Халаалт, агаар сэлгэлт ба кондицонер;
- БНбД 40-06-16, Дотор сантехникийн систем;
- MNS 6055-2009, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин;
- MNS 4585:2016, Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 5850-2019, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS 3297:2019, Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний

**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

**Ангилалтын код 11.180.30**

| | |
|---|---|
| **Монгол брайль үсгийн тэмдэглэгээ** | **MNS 6800:2019** |
| **Transliteration of Mongolian braille characters** | |

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн С/80 дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

## 1 Хамрах хүрээ

Энэ стандартаар монгол Брайль бичгийг ашиглах, хэвлэх, хөрвүүлэх зарчмыг тогтоосон.

## 2 Норматив иш татсан

Олон улсын Англи Брайль бичгийн зөвлөл (International Council on English Braille - ICEB)-ээс 2013 онд эрхлэн гаргасан Нэгдсэн Англи Брайль бичгийн журам (The Rules of Unified English Braille - UEB)-ыг мөрдлөг болгов.

## 3 Нэр томьёо, тодорхойлолт

**3.1**
**Брайль үсэг**
Францын хараагүй иргэн Луи Брайль (1809-1852)-ийн анхлан боловсруулсан хараагүй хүмүүсийн тэмтэрч унших, бичихэд зориулагдсан товгор тэмдэгтийн сан

**3.2**
**Брайль тэмдэгт**
3 мөр, 2 багана бүхий нийт 6 товгор цэгээс тогтох ба цэгүүдийг зүүн дээд булангаас доошоо 1, 2, 3, баруун дээд булангаас доошоо 4, 5, 6 хэмээн дугаарлана.



Брайль үсгийн харагдах байдлыг энэ товхимолд дараах байдлаар дүрсэлнэ.
Товгор цэгийг тод хараар, үлдэх цэгийг цэгээр мөн хэддүгээр цэг товойсныг ЦXXXXX гэж тэмдэглэв.



Ц234

1

# ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2019 оны 08 дугаар сарын 13-ний өдөр Дугаар А/304 А/266 Улаанбаатар хот

## Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйл, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсрол сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Халиунаа/-т даалгасугай.

3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын бүрэн дунд боловсрол олгох сургалтын үнэлгээг Боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний баталсан боловсролын стандартын хэрэгжилтийг үнэлэх журмаар зохицуулсугай.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, мөрдөж ажиллахыг Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээний төв /Ц.Батдорж/, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн захиралуудад тус тус үүрэг болгосугай.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД С.ЧИНЗОРИГ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД Е.БААТАРБИЛЭГ

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,*
*Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын*
*сайдын 2019 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн*
*[illegible] дугаар хамтарсан тушаалын хавсралт*

## СУРАЛЦАГЧИЙН МЭДЛЭГ, ЧАДВАР, ДАДЛЫГ ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус өмчийн политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшил, дадлын түвшин түүний ахиц өөрчлөлтийг үнэлж, дүгнэхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, стандарт, чанарын үнэлгээнд нийцсэн сургалтын явцын, чадамжийн нэгжийн, улирлын, төгсөлтийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх, баталгаажуулах үйл ажиллагааг Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан холбогдох дүрэм, журмын хүрээнд хэрэгжүүлнэ.

1.4. Политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж, баталгаажуулах, хөндлөнгийн үнэлгээг хийх холбогдох журмаар зохицуулна.

### *ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ*

2.1. Боловсролын үнэлгээний стандартад нийцүүлэн үнэлгээний арга зүй, төрөл, хэлбэрийг уян хатан тогтоож, тухайн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнг илрүүлэхүйц, агуулгыг бүрэн хамруулсан байна.

2.2. Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/50 дугаар тушаалаар баталсан "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж, баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт

зохион байгуулах журам"-ын 2.1-т тусгасан зарчим, 2.5-д тусгагдсан ерөнхий шалгуур, 5 дугаар зүйлд тусгагдсан үнэлгээний орчныг тус тус баримтална.

2.3. Суралцагчийг үнэлж, дүгнэх шалгуурыг тухайн хичээлийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх суурь, сонгох хэсгийн агуулгын хүрээнд боловсруулж, үнэлгээний төрөл, арга хэлбэрийг зөв оновчтой сонгоно.

2.4. Мэргэжлийн болон мэргэжлийн боловсрол олгох сургалтын мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн үнэлгээг чадамжтай/чадамжгүй, харамсалтай чадамж эзэмшээгүй/, ерөнхий суурь хэсгийн хичээл, техникийн боловсрол олгох сургалтыг бүхэлд нь стандарт үнэлгээгээр үнэлнэ.

2.5. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, дадлын түвшин, түүний ахиц өөрчлөлтийг сургалтын явцын, чадамжийн нэгжийн, улирлын, төгсөлтийн үнэлгээний төрлөөр үнэлнэ.

2.5.1. "Явцын үнэлгээ" гэж залгамж хичээлийн үеэр суралцагчийн эзэмшиж буй мэдлэг, ур чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг тогтоох үйл явц;

2.5.2. "Чадамжийн нэгжийн үнэлгээ" гэж тухайн чадамжийн нэгжийн хүрээний мэдлэг, ур чадвар, хандлагыг цогцоор нь эзэмшсэн эсэхийг тогтоох, баталгаажуулах үйл явц;

2.5.3. "Улирлын үнэлгээ" гэж тухайн улиралд судалсан хичээлийн агуулгыг бүрэн эзэмшсэн эсэхийг тодорхойлох үйл явц;

2.5.4. "Төгсөлтийн үнэлгээ" гэж тухайн мэргэжил, мэргэшилд хамаарах хичээлийн агуулгын хүрээг цогцоор нь эзэмшсэн эсэхийг төгсөлтийн шатанд тогтоох, баталгаажуулах үйл явц.

2.6. Техникийн боловсрол олгох сургалт нь 90-ээс доошгүй багц цагаар хэмжигдэх бөгөөд явцын үнэлгээ, улирлын үнэлгээ, төгсөлтийн үнэлгээний төрлийг хэрэгжүүлнэ.

2.7. Мэргэжлийн боловсрол олгох 1 жилийн сургалт 1230 цаг, 2.5-3 жилийн сургалт нь 3300-3980 доошгүй цагаар хэмжигдэх бөгөөд явцын үнэлгээ, чадамжийн нэгжийн үнэлгээ, төгсөлтийн үнэлгээний төрлийг хэрэгжүүлнэ.

2.8. Мэргэжлийн сургалтын үргэлжлэх хугацаа нь чадамжийн нэг буюу хэд хэдэн нэгжийг бүрэн эзэмшүүлбэл зохих хугацаагаар хэмжигдэх бөгөөд явцын үнэлгээ, чадамжийн нэгжийн үнэлгээний төрлийг хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд чадамжийн нэгжийн үнэлгээ нь төгсөлтийн үнэлгээ болно.

2.9. Энэхүү журмын 2.5–т заасан үнэлгээний төрлийг онолын, ур чадварын хэсгээс шалтгаалан үнэлгээний дараах 6 аргаас сонгон зохион байгуулна. Үүнд:

2.9.1. Мэдлэгийг системтэй бүрэн эзэмшсэн байдлыг хянальтын ажил, тест, илтгэл, реферат, тайлан, төсөл бичих, тооцоолох, эссэ, зохиомж найруулан бичих, аяллын маршрут зохиох, ажиглах, тайлбарлах,

ярилцлага, маргаан, мэтгэлцээн хийх зэрэг аргаар онолын хэсгийг үнэлнэ.

2.9.2. Мэдлэгийг бүтээлчээр тодорхой нөхцөлд шилжүүлэн дадлагын ажил, сорил туршилт, үйлчилгээ, бүтээл, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, даалгавар өгөх, төслийн ажил гүйцэтгүүлэх зэрэг аргаар ур чадварын хэсгийг үнэлнэ.

2.10. Сургалтын албанаас сургалтын чанарт дотоодын баталгаажуулалтыг улирадд нэг удаа хийнэ. Үнэлгээний төлөвлөгөөний дагуу стандарт, холбогдох журамд нийцүүлэн дотоодын үнэлгээ зохион байгуулагдсан эсэхийг хянах, дүгнэлт гаргах, санал зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж дотоодын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.

2.11. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч шалгалт өгөх тохиолдолд тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон орчин бүрдүүлэх.

**2.12. Явцын үнэлгээний зохион байгуулалт:**

2.12.1. Багш хичээлийн явцын үнэлгээг хийхдээ агуулгын аль хэсэгт суралцагч мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмшиж чадахгүй байгааг шинжлэн тогтоож, гүйцэтгэлийн хувиар тооцож, нотолгоог бүрдүүлнэ.

2.12.2. Чадамжийн элементийг эзэмшүүлэх явцад болон төгсгөлд явцын үнэлгээг хийнэ. Элементийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гүйцэтгэлд тохирсон ажилбарын хүрээнд мэргэжлийн багш ажлын даалгаврыг боловсруулна. Даалгаврын агуулгаас хамаарч үнэлгээний арга хэлбэрийг сонгоно.

2.12.3. Явцын ур чадварын үнэлгээнд шаардлагатай материал, багаж, хэрэгслийг хичээл заасан багш бэлтгэж, үнэлгээний орчныг бүрдүүлнэ.

**2.13. Чадамжийн нэгжийн үнэлгээний зохион байгуулалт:**

2.13.1. Тухайн чадамжийн нэгжийг судалж дууссаны дараа нэгжийн үнэлгээг зохион байгуулна. Чадамжийн нэгжийн элементийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд гүйцэтгэлд тохирсон ажилбарын ажлын даалгавар болон онолын мэдлэг үнэлэх үнэлгээний материалыг мэргэжлийн багш боловсруулж, сургалтын менежер хянаж, баталгаажуулна.

2.13.2. Хөндлөнгийн үнэлгээний ажилтан оролцсон үнэлгээний баг чадамжийн нэгжийн үнэлгээг хийж, холбогдох тэнхим, сургалтын менежер хяналт тавина.

2.13.3. Чадамжийн нэгжийн үнэлгээнд "Хараахан чадамж эзэмшээгүй" (ХЧЭ) гэж үнэлэгдсэн суралцагчдад агуулгыг бие даан нөхөж судлах боломж

олгож, багш нар зөвлөн туслах төлөвлөгөөт хуваарийн дагуу суралцагчдад дэмжлэг үзүүлнэ.

2.13.4. Чадамжийн нэгжийн үнэлгээний онолын болон ур чадварын дүнг журналд гүйцэтгэлийн хувь, чадамжтой, хараахан чадамж эзэмшээгүй гэсэн үнэлгээгээр тэмдэглэж, улирлын дүн гаргах суурь нөхцлийг бүрдүүлнэ.

2.13.5. Чадамжийн нэгжийн үнэлгээний төлөвлөгөө, удирдамжийн дагуу үнэлгээнд шаардлагатай түүхий эд материал, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүний зардлын тооцоог тухайн мэргэжлийн багш хийж, сургалтын байгууллага үнэлгээний орчныг бүрдүүлнэ.

**2.14. Улирлын үнэлгээний зохион байгуулалт:**

2.14.1. Улирлын үнэлгээ нь техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын стандарт, хөтөлбөрт нийцсэн, тухайн улиралд үзсэн хичээлийн агуулгыг бүрэн хамарсан байна.

2.14.2. Улирлын үнэлгээг батлагдсан төлөвлөгөөний дагуу улирлын төгсгөлд зохион байгуулна. Сургалтын албанаас сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл бүрээр улирлын шалгалтын хуваарийг гаргаж, баталгаажуулан эхлэн 2-оос доошгүй долоо хоногийн өмнө багш, суралцагчдад мэдээлнэ.

2.14.3. Улирлын үнэлгээний багийг захирлын тушаалаар байгуулна.

2.14.4. Улирлын үнэлгээний онолын мэдлэг шалгах материалыг сургалтын хөтөлбөрт үндэслэн холбогдох тэнхимийн мэргэжлийн багш 4-өөс доошгүй хувилбартайгаар боловсруулна. Сургалтын алба тухайн хувилбараас сонгож, шалгалтыг хуваарийн дагуу зохион байгуулна.

2.14.5. Үнэлгээний баг шалгалт эхлэхээс 1 хоногийн өмнө сонгосон шалгалтын материалын нууцлалыг алдагдуулахгүй хувилж, битүүмжилнэ.

2.14.6. Үнэлгээ явагдах эхлэхээс 15 минутын өмнө шалгагч багш үнэлгээний танхимд сурагчдыг бүртгэж, суудал хуваарилан суулгаж, үнэлгээний дэгийг танилцуулан материалыг тараана.

2.14.7. Улирлын үнэлгээний материалыг мэргэжлийн багш засч, дүнг тухайн өдөрт нь мэдээлнэ.

2.14.8. Үнэлгээний багийн шийдвэрийн дагуу улирлын үнэлгээнд хүндэтгэх шалтгаанаар хамрагдаагүй болон хангалтгүй үнэлгээ авсан суралцагчийг 14 хоногийн дотор шалгалтын хуваарь гарган дахин үнэлгээнд хамруулна.

2.14.9. Суралцагчийн улирлын үнэлгээний дүнг сургалтын алба баталгаажуулан мэдээллийн нэгдсэн системд оруулна.

2.14.10. Улирлын үнэлгээний дунд дүн-шинжилгээ хийх, тестийн сан бүрдүүлэх ажлыг сургалтын менежер, үнэлгээний баг хариуцан гүйцэтгэнэ.

**2.15. Төгсөлтийн үнэлгээний зохион байгуулалт:**

2.15.1. Төгсөлтийн үнэлгээ нь техникийн болон мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын стандарт, хөтөлбөрт нийцсэн тухайн мэргэжлийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх суурь, сонгон судлах хичээлийн агуулгыг бүрэн хамарсан байна.

2.15.2. Төгсөлтийн үнэлгээнд улирлын болон чадамжийн нэгжийн үнэлгээнд тэнцсэн, техникийн болон мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын стандарт, хөтөлбөрийн шаардлагыг хангасан суралцагч орно.

2.15.3. Төгсөлтийн үнэлгээний багийн бүрэлдэхүүн, удирдамжийг сургалтын байгууллага тухай бүр батлан удирдлага зохион байгуулалтаар хангана.

2.15.4. Үнэлгээний баг нь суралцагчдын даалгаврын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу ажиглах, нэмэлт асуулт тавьж хариулт авах, гүйцэтгэлийн үр дүнд үзүүлэлт бүрээр үнэлгээ өгч дүнг нэгтгэнэ.

2.15.5. Сургалтын менежер, үнэлгээний баг материалыг хүлээлцэх, задлах, хувилах, үнэлгээний дүнг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

2.15.6. Үнэлгээний баг төгсөлтийн үнэлгээний явц, давуу болон сул тал, цаашид анхаарах асуудлын талаар дүгнэлт гаргана.

2.15.7. Мэргэжил эзэмшихээр суралцаж байгаа тохиолдолд бүх чадамжийн нэгж /хичээл-ийг эзэмшиж, "Чадамжтай/Хангалттай" гэж үнэлэгдсэн тохиолдолд төгсөлтийн үнэлгээнд орох эрхтэй.

2.15.8. Чадамжийн нэгж эзэмшихээр суралцаж байгаа тохиолдолд чадамжийн нэгжийн үнэлгээ нь төгсөлтийн үнэлгээ байна.

2.15.9. Төгсөлтийн үнэлгээ нь хөндлөнгийн байж болох бөгөөд энэ тохиолдолд сургалтын байгууллага, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулна. Үнэлгээнд дүнд дүн шинжилгээ хийх, тестийн сан бүрдүүлэх ажлыг Мэргэжлийн боловсрол үнэлгээний төв хариуцан гүйцэтгэнэ.

2.15.10. Хөндлөнгийн үнэлгээ хийгдэж байгаа үед сургалтын байгууллага суралцагчийн суралцсан хугацааны мэдээлэл бусад нотлох баримтыг

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвд тогтоосон хугацаанд гаргаж хүргүүлнэ.

2.15.11. Энэхүү журамд тусгагдаагүй зохион байгуулалтын чанартай аливаа асуудлыг шалгалтын болон үнэлгээний удирдамжаар тухай бүр зохицуулна.

## ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

**3.1.** Мэргэжлийн болон мэргэжлийн боловсрол олгох сургалтын мэргэжлийн суурь, мэргэшүүлэх чиглэлийн үнэлгээг чадамжаар /чадамжтай, хараахан чадамж эзэмшээгүй/, үнэлгээгээр үнэлнэ.

**3.2.** Чадамжтай хараахан чадамж эзэмшээгүй гэсэн үнэлгээг Үнэлгээний хяналтын хуудсанд заагдсан гүйцэтгэлийн хувийг хэрхэн хангаж байгааг шалгуур болгон үзнэ.

## ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ

**4.1. Сургалтын байгууллагын эрх, үүрэг:**

4.1.1. **Сургалтын байгууллагын эрх:**

4.1.1.1. Үнэлгээний нэгдсэн төлөвлөгөө гаргаж баталгаажуулан оролцогч талуудад мэдээллийг бүрэн хүргэх;

4.1.1.2. Тодорхой үндэслэл, шалтгаанаар үнэлгээний төлөвлөгөөг бүхэлд нь буюу хэсэгчлэн өөрчлөлт хийж, зарлан мэдэгдэх;

4.1.1.3. Үнэлгээний багийг бүрдүүлж, үнэлгээний удирдамжийг батлах, зохион байгуулалтаар бүрэн хангах;

4.1.1.4. Үнэлгээтэй холбогдон гарсан аливаа санал, гомдлыг шийдвэрлэх;

4.1.1.5. Суралцагчийг тодорхой шалтгааны улмаас шалгалтанд оруулахгүй байх, шалгалтаас чөлөөлөх, шалгалтанд орох эрхийг сэргээх, дахин шалгалтыг зохион байгуулах.

4.1.2. **Сургалтын байгууллагын үүрэг:**

4.1.2.1. Үнэлгээг зохион байгуулах эрх олгосон гэрчилгээтэй байх;

4.1.2.2. Үнэлгээний болон баталгаажуулалтын ажилтантай байх;

4.1.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлага хангасан анги, танхим, дадлагын газар, тоног төхөөрөмж, бүхий үнэлгээний орчныг бүрдүүлсэн байх;

4.1.2.4. Явцын, чадамжийн нэгжийн, улирлын үнэлгээг сургалтын байгууллага, төгсөлтийн үнэлгээг сургалтын байгууллага, хөндлөнгийн үнэлгээний эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах;

4.1.2.5. Үнэлгээг шууд хариуцан зохион байгуулах, явцад нь хяналт тавих, гүйцэтгэлийн үр дүнг тооцох, анализ дүгнэлт хийж түүний дагуу тодорхой арга хэмжээ авч ажиллах.

**4.2. Багшийн буюу үнэлгээний багийн гишүүний эрх, үүрэг**

**4.2.1. Багшийн буюу үнэлгээний багийн гишүүний эрх:**

4.2.1.1. Сургалтын байгууллагын ёс зүйн дүрмийг баримтлах;

4.2.1.2. Үнэлгээг зохион байгуулах, оролцох тухай 3-5 хоногийн өмнө тухайн байгууллагад мэдэгдэж, үнэлгээ хийгдэх орчин, нөхцөлтэй танилцаж баталгаажуулах;

4.2.1.3. Суралцагчдын тэгш оролцоог хангах, шударга үнэлэх, бусадтай харьцуулахгүй байх, үнэлгээний явцад хувийн чанартай асуулт асуухгүй байх.

**4.2.2. Багшийн буюу үнэлгээний багийн гишүүний үүрэг:**

4.2.2.1. Сургалтын байгууллагын ёс зүйн дүрмийг баримтлах;

4.2.2.2. Үнэлгээг зохион байгуулах, оролцох тухай 3-5 хоногийн өмнө тухайн байгууллагад мэдэгдэж, үнэлгээ хийгдэх орчин, нөхцөлтэй танилцаж баталгаажуулах;

4.2.2.3. Суралцагчдын тэгш оролцоог хангах, шударга үнэлэх, бусадтай харьцуулахгүй байх, үнэлгээний явцад хувийн чанартай асуулт асуухгүй, хөндлөнгийн нөлөөнд автахгүй байх;

4.2.2.4. Үнэлгээний журмыг баримтлах;

4.2.2.5. Үнэлгээний шийдвэрийг суралцагч хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд гомдлыг хүлээн авч, нэгтгэн шийдвэрлэх.

**4.3. Суралцагчийн эрх, үүрэг**

**4.3.1. Суралцагчийн эрх:**

4.3.1.1. Суралцагч нь сургалтын төлөвлөгөөний нийт цагийн 40 хувь ба түүнээс дээш цагт хүндэтгэх шалтгаан(өөрөө өвчлөх, ар гэрийн гачигдал тохиолдох)-ы улмаас хамрагдаагүй нь нотлогдсон тохиолдолд заавал эзэмших агуулгыг бие даан судалж, үнэлгээнд орох;

4.3.1.2. Мэдлэг, чадвар, хандлагаа үнэн зөв, бодитой шударгаар үнэлүүлэх;

4.3.1.3. Суралцагч үнэлгээний баг болон шалгагч багшийн тавьсан үнэлгээг зөвшөөрөхгүй тохиолдолд сургалтын албанд гомдлыг бичгээр үнэлгээ зохион байгуулагдсанаас хойш 24 цагийн дотор гаргах.

4.3.2. Суралцагчийн үүрэг:

4.3.2.1. Үнэлгээний төлөвлөгөөтэй урьдчилан танилцаж, мэдээллийг мэргэжлийн багш, үнэлгээний багаас 3-аас доошгүй өдрийн өмнө авч баталгаа хангасан байх;

4.3.2.2. Өөртөө болон бусдад хохирол учруулах ёс зүйгүй үйлдэл гаргахгүй, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчихгүй байх;

4.3.2.3. Үнэлгээний явцад зөвшөөрөгдөөгүй эд зүйлс, хэрэгсэл ашиглахгүй бусдаас болон бичиж тэмдэглэсэн зүйлээс хуулахгүй;

4.3.2.4. Үнэлгээнд орохын өмнө мэргэжлийн багшаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа авч гарын үсэг зурсан байх.

## ТАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

5.1. Үнэлгээний журам зөрчсөн багш, ажилтанд хөдөлмөрийн гэрээ, сургуулийн дотоод журамд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

5.2. Суралцагч үнэлгээний журам зөрчсөн тохиолдолд анхааруулга өгөх, шалгалтыг үргэлжлүүлэхгүй зогсоох хүртэл арга хэмжээ авна.

5.3. Албан ёсоор батлуулаагүй материалаар авсан шалгалтыг хүчингүйд тооцно.

5.4. Үнэлгээний явцад үнэлгээний багаас бусад хүн зохих ёсны зөвшөөрөлгүйгээр шалгалт авч буй ангид орох, суралцагчтай харилцах, саад болох, дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хориглоно.

## ЗУРГАА. САНХҮҮЖИЛТ

6.1. Чадамжид суурилсан сургалтын үр чадварын үнэлгээнд шаардагдах түүхий эд материал, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүний зардлын тооцоог үндэслэн сургалтын байгууллага санхүүжилтыг шийдвэрлэнэ.

6.2. Үнэлгээний багийн гишүүдийн ажлын хөлсийг холбогдох журмыг үндэслэн тухайн сургалтын байгууллага тооцож олгоно.

6.3. Үнэлгээнд хангалтгүй үнэлэгдсэн суралцагчид дахин нэг удаа үнэлгээнд орох эрх олгох бөгөөд хоёр дахь удаагаа дахин үнэлгээнд орох шаардлагатай бол тухайн чадамжийн нэгжид болон тухайн хичээлийн багц цагт ногдох төлбөрийг сургалтын байгууллагад төлнө.

## ДОЛОО. САНАЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ

7.1. Суралцагчийн улирлын, чадамжийн нэгжийн голч дүнгийн талаар гаргасан маргааныг холбогдох тэнхимийн саналыг үндэслэн сургалтын алба шийдвэрлэнэ.

7.2. Суралцагч төгсөлтийн үнэлгээтэй холбоотой санал, гомдлыг үнэлгээ зохион байгуулсан өдрөөс хойш 3 хоногт багтаан тухайн сургуулийн үнэлгээний багт гаргана. Төгсөлтийн үнэлгээний талаар иргэд, багш, суралцагчийн гаргасан гомдол, мэдээлэл, санал, хүсэлтийг үнэлгээний баг Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээний төвд хүргүүлэх ба үнэлгээний төв ажлын 5 хоногт багтаан арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

7.3. Санал, гомдлын хариут заасан хугацаанд багтаан мэдэгдэж, шийдвэрлэх үйл явц нь нээлттэй, ил тод, шударга байна.

## НАЙМ. БУСАД

8.1. Энэхүү журамд тусгагдаагүй зохион байгуулалтын чанартай аливаа асуудлыг сургалтын байгууллага тухай бүр үнэлгээний удирдамжид тусган зохицуулна.

8.2. Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээний төв нь салбарын сургалтын чанарын үнэлгээнд дүн шинжилгээ хийж, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

8.3. Иргэн, хуулийн этгээд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх хөндлөнгийн шалгалт зохион байгуулахыг хориглоно.

--- oOo ---

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2019 оны 05 дугаар сарын 13 өдөр    Дугаар А/808 А/262    Улаанбаатар хот

### Журам, загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйл, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 16.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдөд мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээ олгох журам"-ыг нэгдүгээр, "Мэргэжлийн дипломын загвар"-ыг хоёрдугаар, "Мэргэжлийн үнэмлэхний загвар"-ыг гуравдугаар, "Мэргэжлийн боловсролын үнэмлэхний загвар"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлагсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Халиунаа/-т, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Нямочир/-т тус тус үүрэг болгосугай.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД    С.ЧИНЗОРИГ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД    Ё.БААТАРБИЛЭГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны [illegible] дугаар сарын 07 -ны өдрийн [illegible] тоот хамтарсан тушаалын хавсралт

**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧДӨД МЭРГЭЖЛИЙН ДИПЛОМ, ҮНЭМЛЭХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Политехник коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв /цаашид "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага"гэх/-д албан болон албан бус хэлбэрээр суралцан мэргэжил, боловсрол эзэмшсэнийг нотолж мэргэжлийн диплом, мэргэжлийн боловсролын үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, /цаашид "диплом, үнэмлэх" гэх/ олгоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдөд олгох мэргэжлийн диплом, үнэмлэх нь улсын бүртгэлийн дугаар, QR кодтой байна. Улсын бүртгэлийн дугаар нь есөн орон бүхий тоо байх бөгөөд эхний дөрвөн орон нь тухайн оныг, сүүлчийн таван орон нь тухайн жилийн төгсөгчдийн тоог илэрхийлсэн байна.

**ХОЁР. Мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээний төрөл, ангилал**

2.1. Техникийн боловсролын хөтөлбөрийн агуулга, багц цагийг бүрэн эзэмшсэн төгсөгчдөд Мэргэжлийн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн диплом олгоно.

2.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцан мэргэжил эзэмшихийн зэрэгцээ бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд мэргэжлийн боловсролын үнэмлэхийг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран олгоно.

2.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцан тухайн мэргэжлийн агуулгыг бүрэн эзэмшсэн төгсөгч болон албан бус сургалтын хэлбэрээр мэргэжил эзэмшиж, үнэлгээнд тэнцсэн иргэнд Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн үнэмлэх олгоно.

2.4. Албан ба албан бус сургалтын хэлбэрийн мэргэжлийн тодорхой түвшний ур чадвар олгох сургалтад хамрагдаж, чадамж эзэмшсэн иргэнд чадамжийн гэрчилгээг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв олгоно.

## ГУРАВ. Мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээний захиалга авах, хэвлүүлэх

3.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэхний захиалгыг тухайн хичээлийн жилийн 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

3.2 Чадамжийн гэрчилгээний захиалгыг холбогдох журамд заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвд албан бичгээр хүргүүлнэ.

3.3 Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэхийг баталсан загвар, захиалсан тоогоор нууцлал бүхий үнэт цаасан дээр хэвлүүлж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад олгох ажлыг зохион байгуулна.

3.4 Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зөвхөн мэргэжлийн боловсролын үнэмлэх олгох ажлыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан холбогдох журмыг баримтлан зохион байгуулна.

3.5 Диплом, үнэмлэх, гэрчилгээний үнэт цаас хэвлүүлэх зардлыг төгсөгч хариуцна.

## ДӨРӨВ. Мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээнд бичилт хийх, баталгаажуулах

4.1. Мэргэжлийн диплом, үнэмлэхний бичилтийг тухайн Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага хариуцан гүйцэтгэж, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв баталгаажуулж, Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

4.2. Мэргэжлийн диплом, үнэмлэхэд кирилл, монгол бичиг англи хэлээр товчилсон үг, үсэг хэрэглэхгүй, компьютерын программ ашиглан бичилт хийнэ. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэрийг улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэснээр үнэн зөв бичнэ.

4.3. Үнэлгээний баг баталгаажуулагчийн дүгнэлтийг үндэслэн Сургалтын албаны менежер нь тухайн боловсролын баримт бичиг, төгсөгчийн хувийн хэрэгт хичээлийн дүн, чадамжийн нэгжийн үнэлгээ, улсын шалгалтын дүнг тус тус тэмдэглэж, баталгаажуулсан байна.

4.4. Мэргэжлийн дипломд Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэр, төгсөгчийн эцэг/эх/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, төгссөн огноо, эзэмшсэн мэргэжлийн нэр, индекс, түвшин, дипломын улсын бүртгэлийн дугаар, судалсан хичээлийн нэр, багц цаг, суралцсан тоон ба үсгэн дүн, төгсөлтийн үнэлгээ, диплом хамгаалсан сэдэв, голч дүнг тэмдэглэж, мэргэжлийн боловсрол, сургалтын

байгууллагын захирал, төгсөлтийн үнэлгээний багийн ахлагч гарын үсэг зурж, баталгаажуулна.

4.5. Мэргэжлийн үнэмлэхэд Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэр, төгсөгчийн эцэг /эх/-ийн нэр болон өөрийн нэр, регистрийн дугаар, суралцсан мэргэжлийн нэр, индекс, түвшин, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх чадамжийн нэгжийн нэр, гүйцэтгэлийн хувь, чадамжтай, хараахан чадамж эзэмшээгүй гэсэн үсгэн тэмдэглэгээг тус тус бичиж, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирал, төгсөлтийн үнэлгээний багийн ахлагч гарын үсэг зурж баталгаажуулна

4.6. Мэргэжлийн боловсролын үнэмлэхэд Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэр, төгсөгчийн эцэг /эх/-ийн нэр болон өөрийн нэр, регистрийн дугаар, суралцсан мэргэжлийн нэр, индекс, түвшин, ерөнхий эрдмийн хичээлийн гүйцэтгэлийн үнэлгээ, түвшин, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх чадамжийн нэгжийн нэр, гүйцэтгэлийн хувь, чадамжтай, хараахан чадамж эзэмшээгүй гэсэн үсгэн тэмдэглэгээг тус тус бичиж, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирал, төгсөлтийн үнэлгээний багийн ахлагч гарын үсэг зурж баталгаажуулна.

4.7. Чадамжийн гэрчилгээнд төгсөгчийн нэр, регистрийн дугаар, эцэг /эх/-ийн нэр, сургалтын байгууллагын нэр, мэргэжлийн нэр индекс, мэргэшлийн түвшин, эзэмшсэн чадамжийн нэгжийн жагсаалт, үнэлгээг бичиж, баталгаажуулалт гэсэн хэсэгт мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн дарга, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын захирал гарын үсэг зурж, баталгаажуулна.

**ТАВ. Мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээг нөхөн олгох**

5.1. Төгсөгч нь диплом, үнэмлэхийг нөхөн авахдаа дараах материалыг бүрдүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

Үүнд:

- Мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэх болон мэргэжлийн боловсролын үнэмлэх нөхөн авах болсон шалтгааныг бичсэн хүсэлт
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Иргэний хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд нотлох баримтын хуулбар
- Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн нэгдсэн сангийн лавлагаа
- Диплом, үнэмлэх дахин авах иргэн энэхүү журмын 3.5-т заасан зардлыг 3 дахин нугалж төлнө.

5.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дээрх бичиг баримтыг хянан үзэж мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэхийг нөхөн олгоно.

5.3. Чадамжийн гэрчилгээг мэдээллийн нэгдсэн сангийн лавлагааг үндэслэн Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв нөхөн олгоно.

5.4. 2017 оноос хойш төгссөн төгсөгчид нөхөн авах баримт бичгийн лавлагааг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн мэдээллийн нэгдсэн сангаас авна.

5.5 2017 оноос өмнөх төгсөгчид Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас нөхөн авах баримт бичгийн лавлагааг авна.

5.6. Нөхөн олгосон баримт бичгийн нүүрэн талын баруун дээд хэсэгт "Нөхөн олгов" гэсэн бичилтийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хийж, баталгаажуулна.

5.7 Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв нь нөхөн олгосон баримт бичгийн мэдээллийг төгсөгч, иргэдийн мэдээллийн нэгдсэн санд байршуулна.

## ЗУРГАА. Мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээ олгосон тухай тайлан, мэдээ гаргах

6.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь улсын ба төгсөлтийн шалгалт дууссанаас хойш 21 хоногт багтаан диплом, үнэмлэх олгосон тухай тайланг "Б" маягт болон үнэлгээний нэгдсэн хуудсыг 2 хувь үйлдэж, 1 хувийг мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвд ирүүлэх ба үлдэх хувийг цаасан болон цахим хэлбэрээр архивлана.

6.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв нь чадамжийн гэрчилгээ олгосон тайлангийн нэг хувийг төгсөлтийн мэдээний хамт улиралд нэг удаа мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

6.3. Мэргэжлийн боловсрол,сургалтын байгууллага нь диплом, үнэмлэх олгосон мэдээллийг төгсөгч, иргэдийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж байршуулна.

## ДОЛОО. Хяналт, хариуцлага

7.1. Диплом, үнэмлэх, гэрчилгээг хууль бусаар олгосон, хуурамчаар үйлдсэн, хүчингүй баримт бичгийг баталгаажуулсан тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Бичилт нь засвартай диплом, үнэмлэхийг хүчингүйд тооцно. Диплом, үнэмлэхийг буруу бичсэн, засварласан тохиолдолд буруутай этгээд хэвлэсэн үнийн дүнг хоёр дахин нугалан төлнө.

-000-

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдөд мэргэжлийн
диплом, үнэмлэх, гэрчилгээ олгох журмын хоёрдугаар хавсралт

Загвар 1

Б. Мэргэжлийн дипломны загвар

МОНГОЛ УЛС

ДИПЛОМ

Тайлбар:

1. [illegible]
2. [illegible]

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН

________________ овогтой ________________ нь

___ ОНД ________________ КОЛЛЕЖИЙГ

"________________"

МЭРГЭЖЛЭЭР (________) СУРАЛЦАЖ ТӨГССӨН ТУЛ

ТӨГСӨЛТИЙН КОМИССЫН ___ ОНЫ ___ -Р САРЫН ___ -НЫ ӨДРИЙН ШИЙДВЭРИЙГ ҮНДЭСЛЭН

ЗАХИРЛЫН ___ ОНЫ ___ -Р САРЫН ___ -НЫ ӨДРИЙН ___ ТООТ ТУШААЛААР

________________ ДИПЛОМ ОЛГОВ.

________________ Коллежийн захирал

________________ Төгсөлтийн комиссын дарга

Бүртгэлийн дугаар ______

Улаанбаатар хот

Б. Мэргэжлийн дипломны загвар

THE CITIZEN OF MONGOLIA

______________________ (surname) ______________________ (first name)

GRADUATED FROM ____________ COLLEGE IN ____________ AND MAJORED IN "____________". THIS DIPLOMA IS AWARDED ACCORDING TO THE ORDER BY DIRECTOR OF THE COLLEGE DATED ____________ BASED ON THE DECISION BY THE GRADUATION COMMITTEE DATED: ____________

______________________
______________________
______________________ Director of the college

______________________
______________________
Secretary of graduation committee

Registration number ________ Ulaanbaatar city

Загвар 1

Б. Мэргэжлийн дипломын загвар



КОЛЕЖ



COLLEGE

APPENDIX TO DIPLOMA No.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдөд мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээ олгох журмын гуравдугаар хавсралт

Загвар 2

А. Мэргэжлийн үнэмлэхний загвар

МОНГОЛ УЛС



МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ

Тайлбар:

1. [illegible]
2. [illegible]

МОНГОЛ УЛС

МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ

Дугаар:

Салбар:
Мэргэжил:
Мэргэжлийн индекс:
Мэргэжлийн зэрэглэл:

Шалгалтын комиссын дарга: ____________
Сургуулийн захирал: ____________
Гишүүд: ____________

Олгосон: ____ оны ____ сарын ____ өдөр

Бүртгэлийн дугаар: ____________

MONGOLIA

VOCATIONAL CERTIFICATE

Certificate No.:

Industrial sector:
Occupation:
Occupational code:
Qualification level:

Head of examination committee: ____________
Director of the school: ____________
Members: ____________

Issued on: ____________

Registration number: ____________

Загвар 2

А. Мэргэжлийн үнэмлэхний загвар





| No. | Title of competencies | Knowledge | | Skills | |
|---|---|---|---|---|---|
| A. | General units of competency | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| 4 | | | | | |
| 5 | | | | | |
| 6 | | | | | |
| 7 | | | | | |
| 8 | | | | | |
| 9 | | | | | |
| B. | Basic professional skills of [illegible] | | | | |
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| 4 | | | | | |
| 5 | | | | | |
| 6 | | | | | |
| 7 | | | | | |
| 8 | | | | | |
| 9 | | | | | |

| C. | Specialized units of competency | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| 4 | | | | | |
| 5 | | | | | |
| 6 | | | | | |
| 7 | | | | | |
| 8 | | | | | |
| 9 | | | | | |
| 10 | | | | | |
| 11 | | | | | |
| 12 | | | | | |
| 13 | | | | | |
| 14 | | | | | |
| D. | Elective units of competency | | | | |
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |

Note: The columns of final results of knowledge and skills shall be filled out either as "Competent" or "Not yet competent".

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдөд мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээ олгох журмын дөрөвдүгээр хавсралт

Загвар 3

В. Мэргэжлийн боловсролын үнэмлэхний загвар

МОНГОЛ УЛС

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ҮНЭМЛЭХ

[illegible]

Загвар 3

В. Мэргэжлийн боловсролын үнэмлэхний загвар



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2019 оны 10 дугаар сарын 29 | Дугаар А/324; А/490 | Улаанбаатар хот

**Сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь хэсгийн агуулгыг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.10, БСШУС-ын сайдын 2019 оны А/491 дүгээр тушаал, Боловсролын хүрээлэнгийн сургалтын төлөвлөгөөнд дүгнэлт гаргаж ирүүлсэн 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр 160 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Мэргэжлийн боловсролын сургалтын 2.5 жилийн сургалтын төлөвлөгөөний "Ерөнхий суурь хэсэг"-ийн агуулгыг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн "Заавал судлах цаг"-ийн агуулгын 60-аас доошгүй хувь байхаар тогтоосугай.

2. Мэргэжлийн боловсролын 2.5 жилийн ангийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь хэсгийн агуулгыг хавсралт ёсоор батлагсугай.

3. Шинэчлэн баталсан сургалтын төлөвлөгөөг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсролын үнэлгээний төв, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв, аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газарт тус тус үүрэг болгосугай.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД С.ЧИНЗОРИГ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД Ё.БААТАРБИЛЭГ

[illegible] 2019 оны [illegible] дугаар сарын [illegible]-ны өдрийн
А/[illegible] дугаар тушаалын хавсралт

Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага

Мэргэжлийн индекс:
Сургалтын хугацаа: 2,5 жил
Элсэгчийн боловсрол: Суурь

Мэргэжил:
Боловсрол: Мэргэжлийн боловсрол
Түвшин: IV

Сургалтын төлөвлөгөө

| № | Чадамжийн нэгж (хичээл/модуль)-ийн нэр | Чадамжийн нэгжийн код | Багц цаг | Суралцахуйн цаг | Нийт | Онол | Семинар | Лаборатори | [illegible] | [illegible] | [illegible] | I | II | III | IV | V |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 14 | 16 | 17 |
| **А.Ерөнхий суурь хичээл** | | | 54 | 1468 | 1468 | 540 | 756 | 162 | 0 | 0 | 0 | 22 | 23 | 20 | 16 | 6 |
| 1 | Монгол хэл бичиг, уран зохиол | | 8.0 | 108 | 108 | 60 | 108 | | 0 | | | 3 | 3 | 3 | 3 | |
| 2 | Тооцоолох бичиг | | 6.0 | 144 | 144 | 72 | 72 | | 0 | | | 4 | 2 | 2 | 2 | |
| 3 | Математик | | 9.0 | 216 | 216 | 108 | 108 | | 0 | | | 3 | 2 | 4 | 4 | |
| 4 | Байгалийн ухаан | | 5.0 | 108 | 108 | 72 | 36 | | 0 | | | 3 | 2 | 1 | 1 | |
| 5 | Монголын түүх | | 2.5 | 54 | 54 | 18 | 36 | | 0 | | | 3 | 1 | | | |
| 6 | Газарзүй | | 3.0 | 72 | 72 | 36 | 36 | | 0 | | | | 2 | 2 | | |
| 7 | Биологи | | 3.0 | 72 | 72 | 36 | 36 | | 0 | | | 2 | | | 2 | |
| 8 | Физик | | 2.7 | 90 | 90 | 18 | 36 | 36 | 0 | | | 1 | 2 | 2 | | |
| 9 | Хими | | 2.7 | 90 | 90 | 18 | 36 | 36 | 0 | | | 2 | 1 | 2 | | |
| 10 | Гадаад хэл / Англи хэл | | 4.5 | 126 | 126 | 36 | 72 | 18 | 0 | | | 2 | 2 | 2 | 1 | |
| 11 | Биеийн тамир | | 4.5 | 144 | 144 | 18 | 126 | | 0 | | | 2 | 2 | 2 | 2 | |
| 12 | Иргэний ёс зүйн боловсрол | | 2.0 | 54 | 54 | 18 | 36 | | 0 | | | 1 | 2 | | | |
| 13 | Мэргэжлийн танилцуулга | | 1.6 | 60 | 60 | | 18 | 72 | 0 | | | 2 | 2 | | 1 | |
| **Б.Мэргэжлийн суурь хичээл** | | | | | | | | | | | | | | | | |
| 21 | [illegible] | ЭС 100-007-201 | 2.0 | 54 | 54 | 18 | 36 | | 0 | | | 1 | 2 | | | |
| **В.Мэргэжлийн хичээл** | | | | | | | | | | | | | | | | |
| **НИЙТ ДҮН** | | | | | | | | | | | | | | | | |

Боловсролын хөтөлбөрийн хэрэгжилт: А, Б, В хэсэг

Мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлийн агуулга, хэрэгжилтийн хариуцлага: Б-В хэсэг

